

1

АНАТОЛЬ ФРАНС



Ундаассан  
Бурхад

Улаанбаатар

1

АНАТОЛЬ ФРАНС



Ундаассан  
Бурхад

Улаанбаатар

АНАТОЛЬ ФРАНС

УНДААССАН БУРХАД - 1  
(1-11)

“УЛСЫН ХЭВЛЭЛИЙН ГАЗАР” Улаанбаатар хотноо 1969 онд эрхлэн  
хэвлүүлсэн номоос

Цогт охин тэнгэр сангийн захиалгаар Цагаан бамбарууш хэвлэлийн  
газарт 2022 онд цахим хэлбэрт хөрвүүлэв.



ЦАХИМ НОМЫН САН: [www.e-nom.mn](http://www.e-nom.mn)

-

\*

\*\*

Уг номыг “[Болор дуран](#)” шалгуураар шүүсэн болно.  
Программтай танилцах бол сурталчилгаа дээр товшиж холбоос руу  
орно уу.

**Б**  
БОЛОР ДУРАН 2.0  
АЛДАА ШАЛГУУР

**"БОЛОР ДУРАН"  
ЗӨВ БИЧИГ ШАЛГАХ  
ПРОГРАМ**

- ✓ 60 сая үгийн сантай.
- ✓ Алдаатай үгсийг илрүүлж, зөв үгсийг санал болгоно.
- ✓ Хэлзүйн тайлбар тольтой.
- ✓ Хувийн үгийн сан үүсгэх боломжтой.

БОЛОР

# УНДААССАН БУРХАД

*Les dieux ont soif*

Урьд IV Генрихийнх гэгдэж байсан Шинэ гүүр хэмээх секцийн гишүүн, Давидын<sup>1</sup> шавь, уран зураач Эварист Гамлен өглөө эрт 1790 оны таван сарын 21-нээс хойш гурван жилийн турш секцийнхний нийтийн хурал цуглааны газар болж байсан Варнавчуудын хуучин сүмийн зүг явав. Уул сүм Шүүхийн торон хашааны хажуугийн явцуухан баргар талбай дээр байдаг билээ. Их бууны сум, уруу нь харуулсан тайгаар чимэглэсэн, сонгодог эртний хоёр багана бүхий, цагийн эргэлтэд элэгдэж хүний эдэлгээнд муудсан нүүрэн дээрх шашны нь сүлдийг ховх татаад оронд нь «Эрх чөлөө, тэгш эрх, ахан дүүсэг ёс, эсвэл үхэл» гэсэн бүгд найрамдахчуудын уриаг хар үсгээр бичсэн ажээ. Эварист Гамлен дотогш оров. Павел гэгээний нийгэмлэгийн, номын хувцас баринтагласан лам нарын хурал хурахыг нэгэн үе чагнаж байсан сүмийн хүнхэр адар одоо засаг захиргааны түшмэдийг сонгох, мөн секцийн ажил төрлийг зөвшин хэлэлцэхээр цугларсан улаан малгайтай эх орончдыг ширтэнэ. Бурхныг байрнаас нь гаргаж хаяад Брут, Жан Жак болон Ле-Пелетье<sup>2</sup> нарын баримлыг тавьжээ. Хоосорсон шүтээний өрөөний дээр хүний эрхийн тунхагтай самбар өлгөөстэй байв.



Энд, долоо хоногт хоёр удаа оройн таван цагаас арван нэг хүртэл олон нийтийн хурал хийнэ. Үндэсний далбаагаар чимэглэсэн тайт ширээ илтгэгчийн индэр болно. Түүний өмнө, энэ хурал цуглаанд өчнөөн төчнөөнөөрөө ирдэг эмэгтэйчүүд, хүүхдийн суух тавцанг харуулдаагүй банзаар хийжээ. Энэ өглөө индрийн ёроол дахь ширээнээ Тионвиллын талбайн мужаан, Ажиглах хорооны арван хоёр гишүүний

нэг, иргэн ахлах Дюпан улаан малгай болон ар хормой нь урт хүрэм өмссөн сууж байна. Лонх, шил аяга, бэхийн сав. Конвентээс<sup>3</sup> үл тэнцэх хорин хоёр гишүүнийг хасах тухай тийш оруулах эрэлт хүсэлт бичсэн дэвтэр ширээн дээр хэвтэнэ.

Эварист Гамлен үзэг авч гарынхаа үсгийг зурлаа.

— Иргэн Гамлен, чамайг гарын үсгээ зурна гэдэгт би итгэж байсан юм. Чи ёстой эх оронч хүн. Гэвч манай секцийнхэн нэг л хийморь муутай, зориг мохоо юм. Хүсэлтэд үсгээ зураагүй хүмүүст иргэний итгэмжлэх бичиг олгохгүй байх саналаа би Ажиглах хороонд оруулсаан гэж Дюпан өгүүлэв.

— Би урвагч федералчуудыг яллах тогтоолд гарын үсэг цусаараа зурах нь ээ ч бэлхэн байна. Маратыг үхээсэй гэж хүссэн тэд өөрсдөө сөнөх болтугай хэмээн Гамлены хэлсэнд

— Хэт амарлингуй байдал л биднийг ганц алж байна. Секцийн есөн зуун бүрэн эрхт гишүүнээс тавиад нь ч хуралд ирэхгүй юм. Өчигдөр бид хорин наймуулхнаа байв шүү гэж ахлах Дюпан хариуллаа.

— Яая гэх вэ, торгуулиар далайлгаж иргэдийг хуралд ирүүлбэл зохино гэж Гамленыг сануулахад

— Болохгүй ээ, хэрвээ бүгдээр цугларвал эх орончид цөөнх нь болчихно... гэж мужаан хөмсөг зангидан татгалзсанаа

— Гамлен, та алдарт Санкюлот<sup>4</sup> нарын эрүүл мэндийн төлөө аяга архи тогтоочихгүй юу?.. гэлээ.

Шүтээний өрөөний зүүн талын ханан дахь «Иргэний хороо», «Ажиглах хороо», «Үзэн ядах хороо» гэсэн хаягуудын хажууд сүмийг дугантай холбосон хонгил руу долоовор хуруугаараа заасан том хар гар үзэгдэнэ. Цаахна нь сүмийн агуулах байсан өрөөний хаалган дээр «Цэргийн хороо» гэсэн хаяг хийжээ. Гамлен энэ хаалгаар оронгуутаа, хорооны нарийн бичгийн дарга, ном, цаас, болд төмрийн өөдөс, сум, шүүн чулуулгийн үлгэр эн тэргүүтэн хөглөрүүлсэн ширээнээ сууж буйг үзэв.

— Сайн байна уу, Грюбер. Тавтай сууж байгаа биз дээ?

— Би юу?.. Яриа байхгүй сайн.

Цэргийн хорооны нарийн бичгийн дарга Фортюне Трюбер амар мэндийг нь мэдсэн хүн болгонд ийнхүү нэгэн янзаар хариулдаг нь тэдний сэтгэлд нийцүүлэх гэснийх биш харин энэ тухай яриаг цааш сунжруулахгүйг хүссэнийх билээ. Хорин наймхан настай боловч

түүний үс шингэрч, нуруу нь бөгтийн арьс нь хөрзийж хацар нь халуурснаас ягааран гэрэлтэнэ. Уран дархнуудын гудамж дахь галт шилний газрын эзэн байсан тэрээр олон нийтийн ажилд биеэ бүрэн зориулахын тул өвгөн даамлуудынхаа нэгэнд хуучин пүүсээ ерэн нэгэн онд худалджээ. Нутгийн хууччуудын уяранхан дурсаж ярьдаг, хорьтойдоо насан өөд болсон голшиг сайхан эхийнхээ цайвгар царай, бүрэг даруу зан, санаашрангуй усгал нүдийг нь өвчиж төржээ. Мөн тийм өвчнөөр гучин нас ч хүрэлгүй талийгаач болсон ордонд галт шил нийлүүлдэг агсан эрдэмтэн эцгийнхээ уйгагүй оролдлого, саруул ухааныг дуурайсан юм.

— За, чи сайн сууж байна уу? хэмээн тэрээр юмаа бичсэн хэвээрээ асуув.

— Сайн, сайн. Сонин сайхан юутай вэ?

— Юмгүй шив дээ. Энд нам тайван байгааг үз ээ биз.

— Байдал ямар байна даа?

— Байдал урьдын адил онц юмгүй байна.

Байдал тун муу байлаа. Бүгд найрамдах улсын шилдэг арми Майнцад хашигдан, Валансьен бүслэгдэж, Фонтене вандойчуудад эзлэгдээд, Севены болон Лионд бослого гарсны дээр испанийн хил эзгүйрэн, департаментын гуравны хоёр нь дургүйцсэн буюу дайсны эрхшээлд орсон ажээ.

Талх ч үгүй, мөнгө ч үгүй болсон Парисыг Австрийн их бууны гал заналхийлж байлаа.

Фортюне Трюбер тайван гэгч бичсээр л суув. Коммуны тогтоолоор, Вандейд илгээх арван хоёр мянган хүнийг цуглуулахыг секцүүдэд даалгасан учир тэрээр урьд IV Генрихийнх гэгдэж байсан Шинэ гүүр хэмээх секцээс гаргах ёстой цэрэг эрсийг элсүүлэх, зэр зэвсгээр хангах асуудлын талаар заавар зохиох ажлыг эрхэлж буй билээ. Байлдааны бүх бууг шинээр байгуулагдаж байгаа отрядуудад өгөх ёстой тул үндэсний гварди зөвхөн ангийн буу жад зэргийг авч үлджээ.

— Их буу цутгуулахаар Люксембург явуулах хонхны бүртгэлийг чамд авчирлаа гэж Гамлен өгүүлэв.

Эварист хэдийгээр ядуу зүдүү авч секцийн бүрэн эрхт гишүүн билээ. Хууль ёсоор бол гурван өдрийн цалингийн дайтай татвар төлсөн иргэн л сонгогч болдог ба хэрвээ сонгогдох эрх олж авъя гэвэл уг болзол арван өдрийн цалин болтлоо өсдөг байв. Гэвч тэгш эрхийн үзэл

санааг сонирхол болгогч Шинэ гүүр секц өөртөө засах засгаа хичээнгүйлэн хамгаалж, үндэсний гвардийн албаны бүрэн хувцас өөрийн хөрөнгөөр авч чадсан иргэн бүрд сонгох сонгогдох эрх олгодог ажээ. Цэргийн хороо ба секцийн бүрэн эрхт гишүүн Гамлены явдал яг тийм байлаа.

Фортюне Трюбер үзгээ хойш тавив.

— Иргэн Эварист, Конвент рүү очиж зоорины хөрсийг шинжлэх, шороо чулууг шүлтжүүлэх, шүү гаргаж авах зааврыг ирүүл гэж шаардаад орхи. Их буугаар зогсохгүй бас дарь бидэнд хэрэгтэй байна.

Бөгтөр нуруутай бяцхан эр чихэндээ үзэг хавчуулж цаас бариад тасалгаанаа орж ирлээ. Энэ бол ажиглах хорооны гишүүн иргэн Бовизаж гэгч билээ.

— Иргэд ээ, бид маш тусгүй мэдээ авлаа. Кюстин цэргээ Ландаугаас гаргажээ хэмээн түүнийг уламжлахад

— Кюстин урважээ! гэж Гамлен дуу алдав.

— Түүнийг цаазаар авна даа гэж Бовизаж дуугарлаа.

Трюбер ердийн тайван байдлаа алдалгүй тасалданги дуугаар

— Одоо нийтийг аврах хороог Конвент зүгээр нэг байгуулаагүй ээ. Кюстины энэ авирын талаар авч хэлэлцэх болно. Кюстин урвагч уу, зүгээр л чадвар мөхөс хүн үү, алин байлаа ч оронд нь ялна гэж эрс шулуудсан жанжныг томилно оо.

Тэгээд л Gaira!<sup>5</sup> гэлээ.

Тэр хэдэн хуудас эргүүлэн алжаангуй нүдээр гүйлгэн харснаа

— Манай цэргүүд үүргээ эгдүүцэн дургүйцэх юм уу, гуйвж дайвахгүй гүйцэтгэхэд ар гэртээ хоцорсон хүмүүсийнхээ аж амьдрал хангалуун байгааг мэдэх нь чухал. Иргэн Гамлен, хэрвээ чи үүнийг зөвшөөрч байвал Үзэн ядах хорооноос Цэргийн хороотой хамтран төрөл садан нь армид байгаа ядуу айл өрхөд тэтгэвэр олгодог болгох талаар мөдхөн хуралдах хурал дээр надтай цуг шаардагтун гэлээ.

Тэр инээмсэглэн

— Gaira! Gaira! гэж аялж гарав.

Будаггүй ширээнийхээ ард, аюулд учраад байгаа эх орныхоо харуулд өдөрт арван хоёроос арван дөрвөн цаг суухдаа секцийн хорооны эгэл энэ дарга, өмнөө байгаа зорилгын лут их, мэдэлдээ байгаа хөрөнгийн өчүүхэн бага хоёрын зөрүүг эс анзаарахын учир нь тэрээр өөрийгөө агуу их ард түмний амьдралд ууссан, эл үндэстний салшгүй нэг хэсэг, бүх эх орончтой хүсэл эрмэлзэл нэгтэй гэж төдий

чинээ их санаснаас тэр билээ. Тэр хүн хэчнээн ялагдлаа ч бүтэшгүй хэр нь гарцаагүй болох ялалтын баярт бэлтгэн байдаг тийм эрэмгий зоригтны нэг юм аа. Тэд ямар ч атугай ялах ёстой шүү дээ. Вангийн засгийг устган хуучин ертөнцийг үндсээр нь урвуулсан орох орон, оочих аягагүй ядуус, энэ өчүүхэн галт шилний мэргэжилтэн Трюбер, энэ хэний ч үл мэдэх зураач Эварист Гамлен дайснаас өршөөл энэрэл эрэхгүй ээ. Ялалт эсвэл үхэл, үүнээс өөр зам тэдэнд үгүй. Иймээс тэдний цог золбоо бадарч, сэтгэл нь амгалан байгаа билээ.

## II

Варнавчуудын сүмээс гармагцаа Эварист Гамлен бүслэлтийг баатарлагаар даван туулсан хотын дурсгалд зориулж Тионвиллийн гэж нэрийг нь сольсон Дофины талбайг зүглэв.

Парисын хамгийн хүн олонтой дүүрэгт орших энэ талбай зуугаад жилийн өмнө гоёмсог үзэмжээ алдсан агаад хотын захиргааны том түшмэлийг байрлуулахаар IV Генрихийн үед гурван талд нь барьсан цагаан чулуун баганатай улаан тоосгон нэгэн ижил харшийн заримынх нь сайхан хөх занар дээвэр, хоёр гурван давхар арчаа муутай шавар тагтаар солигдож, зарим нь цэцгийн сав, шувууны тор, хатааж буй цагаан даавуу зэрэг юмс алаглан үзэгдэх том жижиг цонхтой, халтар хултар шохойдсон, олхиогүй, муухай яйжгай нүүртэй байшингуудад сууриа гутамшигтайхан тавьж өгөн газартай тэгширсэн ажээ. Гар урчуул, алтны дархан, цутгагч, цагчин, галт шилч, хэвлэхийн ажилчин, үйлчин, оёдолчин, угаалгачин болон вангийн шүүхийн төлөөлөгчдийг цааш харуулсан хүчит салхинаас амь хэлтэрсэн настай хэдэн түшмэд зэрэг есөн жорын хүн энд пиг дүүрэн сууна.



Хаврын нэгэн өглөө байлаа. Шинэхэн нэрсэн сархад лугаа адил мансууруулагч мандах нарны туяа хана туурган дээр тусан наадаж адрын хөндийг ч нэвтлэн гийгүүлнэ. Гильотина<sup>6</sup> шиг цонхны жааз цугаараа сөхөгдөж дор нь эзэгтэй нарын үсээ самнаагүй сэгсгэр толгой үзэгдэх ажээ. Хувьсгалт онц шүүхийн дарга ажилдаа очих замдаа моддын дор наадах багачуулын хацрыг явуут өхөөрдөн илнэ. Шинэ гүүрэн дээр үл бүтэх Дюмуриегийн урвасан тухай хашхиралдаж байлаа.

Цамхагт цагийн гудамжнаа, сүүлчийн хааны өмнөхөн үед нэмж давхарласан вааран дээвэртэй, жижигхэн тагт үгүйсэн бол өнөө хүртэл зэгсэн аятайхан үзэмжээ хадгалсаар байх байсан IV Генрихийн үед баригдсан барилгад Эварист Гамлен суудаг билээ. Парламентын ямар нэгэн хуучин гишүүний байшинг энд сууж буй гар урчуул, борчуулын гэр бүлийн аж байдалд тохируулах зорилгоор болохтой газар бүрд нь ташаалавч, хагас давхарлаг хийжээ. Намсгаж, нарийсгаж ихээхэн зай муутай болгосон тийм нэгэн жижиг өрөө шүү юманд хаалгач бөгөөд оёдолчин иргэн Ремакль аж төрдөг байлаа. Түүний, дагзаараа тааз тулан ширээний ард завилан суугаад үндэсний гвардийн албаны хувцас оёж байхыг нь гаднаас шилэн хаалгаар нь харж болох хийгээд зуух нь шатнаас өөр яндан гэхээр юм үгүй учир Ремакль авгай гал тогооныхоо хэншүүгээр байшингийнхныг утаж, бал бурамд халтартсан авч цэлмэг өдөр шиг хөөрхөн охин Жозефина нь үүдэндээ мужааны Мутан гэдэг нохойтой наадан байдаг билээ. Хөх том, шилбэ бүдүүн. дур хүсэл ихтэй Ремакль авгай, Ажиглах хорооны арван хоёр гишүүний нэг ахлагч Дюпанд бие юүгээн найр тавьдаг гэсэн сураг бий. Ямар ч атугай нөхөр нь хүүхнээ ихээхэн харддаг ба эр эм хоёр байшин цуурайтгал тачигнатал муудалцсанаа түүнээсээ дутуугүй сүржин эвлэрэх нь олонтой. Цамхагт цагийн гудамжинд мухлагтай, эрдэнийн зүйлсийн дархан иргэн Шапрон, цэргийн оточ, түшмэл, жорлон цэвэрлэгч, шүүхийн хэдэн ажилтан дээд давхарт сууна.

Эварист Гамлен ажлын нь өрөө эхийнх нь тасалгаатай хамт байдаг эцсийн дөрвөн давхар өөд хуучны морин шатаар өгсөв.

Доод давхрын өргөн чулуун шатны халааг авсан, паалантай тоосго суулгаж хийсэн модон шат тэнд дуусдаг билээ. Хана түшүүлсэн шатаар дээврийн хонгил руу ордог бөгөөд энэ үед тэндээс ахимаг насны тарган хүн бууж явлаа. Ягаан хацар нь түүний эрүүл гэдгийг илтгэнэ. Томоос том боодолтой юм элгэндээ тэврэн дааж ядан яваа мөртөө тэр хүн «харамсалтай нь би зарцаа алдчихлаа...” гэж гиншин аялах ажээ.

Тэрээр дуулахаа болин Гамлены амрыг эелдгээр эрлээ. Эварист найрсгаар хариу мэндлэн боодолтой юмыг нь доош хамжилцан аваачиж өгсөнд өвгөн түүнд ихэд талархав.

Тэр хүн юмаа ахин авангаа

— Энэ бол хатуу цаасаар хийсэн бүжигчин хүүхэлдэйнүүд байгаа юм. Хуулийн гудамжинд байдаг тоглоомын наймаачинд аваачиж өгье.

Энэ дотор учиргүй олон бий, цөмийг нь би хийсэн юм. Би эднүүст баяр баясгалан, уйтгар зовлон үл мэдэх мөнх бус бие хайрласан билээ. Нигүүлсэнгүй бурхан болохоороо би эднийг оюун ухаантай болгоогүй юм гэв.

Энэ нь тайж, дамлан завшигч байсан иргэн Морисс Бротто бөгөөд эцэг нь ажлаасаа ашиг хонжоо олж тайж язгуур худалдаж авсан юм. Хуучны сайхан цагт Морисс Бротто нь дез-Илетт ноён хэмээгдэж хувьсгалаар албан тушаал, ашиг орлого, орд харш, эдлэн хөрөнгө, хэргэм цолоо алдталаа өөрийн орондоо оройн зоог үргэлж барьж, Морисс Бротто-дез-Илеттэд хувиршгүй үнэнч сэтгэлээ бат хадгалан явдаг прокурорын гэргий үзэсгэлэнт хүүхэн де-Рошмор хүрэлцэн ирж гэрэл гэгээ нь болдог байж билээ. Хувьсгал түүнийг байдгаас нь салгасан учир тэрээр зорчин яваа хүмүүсийн хөргийг зурж, Шүүрхийн гудамжнаа өөрийн хийсэн бин, сам боорцог борлуулж, ардын төлөөлөгч нарын үгийг зохион өгч, залуу бүсгүйчүүдэд бүжиг заан аяга хоолоо олж идэх хэрэг гарчээ. Одоо хана түшүүлсэн шатаар мацаж байж орж гардаг, нуруу тэнийлгэн босож ч үл болох тагтандаа Морисс Бротто ваартай цавуу, эвхсэн олс, хайрцагтай усан будаг, зүссэн цаас бэлдэн хатуу цаасаар хүүхэлдэй урлан үүнийгээ наймаачдад зарахад цаадуул нь өөрийн ээлжид цааш тоглоомын үүргийн худалдаачдад дамладаг ба эд нар нь үүнийг урт шургаагт өлгөж багачуулын хорхойг хөдөлгөн Елисейн талаар авч явдаг байв. Нийгмийн хэрэг явдлын эргүүлгэн дунд өөртөө учирсан гамшиг зовлонг үл анзааран Бротто, санаа амарлингуй байдлаа алдалгүй, хүрэн сюртук цамцныхаа хармаанд түнтийтэл хийн хаа ч очсон авч явдаг Лукрецийн номыг зугаагаа гаргах гэж уншина.

Эварист Гамлен сууцныхаа хаалгыг түлхэхэд дорхноо нээгдэв. Ядуу болохоор өрөөгөө цоожлохын хэрэггүй учир эхийгээ сурсан заншлаараа хаалгаа түгжихэд Гамлен «Яах юм,бэ? Аалзны шүлс, тэр тусмаа миний муусайн зургийг хэн хулгайлах вэ?» гэдэг байлаа. Маягт тохируулан хайр дурлалын явдлыг зурж, сумгүй саадаг, үргэсэн шувууд, осолтой тоглоом, аз жаргалын тухай мөрөөдлийг сайтар нийлсэн бийрээр хүрч ядан гаргаж, шувуу маллагч бүсгүйчүүдийн банзлыг сөхөсхийн, малчин охидын мээмийг ягаанаар будаж байсан анхны бүтээлүүд нь урлах өрөөнд нь зузаан тоосноо дарагдчихсан хана түшүүлээстэй, овоолоостой новшрон хэвтэнэ.

Гэвч эл маяг түүний араншинд огт тохирохгүй байлаа.

Тоомжиргүйхэн янзаар янагийн явдлыг харуулсан зургууд нь уран зураачийн цогцос эмнэг гэдгийг илтгэнэ. Мэдлэгтнүүд энэ талаар эндүүрсэнгүй, Гамлен дурлалын сэдвээр ажиллахдаа уран чадвартай гэж хэзээ ч цуунд гарсангүй. Хэдийгээр тэр одоо гучин нас хүрээгүй ч энэ сэдэв нь балар эрт цагт хамаарах мэт түүнд бодогдоно. Хаант байгууллын үед гарцаагүй байх ёс суртахууны ялзрал, ордны садар самуун явдлыг Гамлен түүнээс олж харсан билээ. Ийм жигшүүртэй төрлийг сонирхон, хамжлагат нийгмээс болж ёс суртахууны талаар уналтын байдалд орлоо гэж тэрээр биеэ зэмлэнэ. Одоо чөлөөт үндэстний иргэн, тэрээр эрх чөлөө, хүний эрх, францын Үндсэн хууль, бүгд найрамдах улсын ачтанууд, харгислалын хорт могойг газарт дарж буй ардын баатар Геракл зэргийг тод томруун зурж түүндээ өөрийн эх оронч гал цогоо цөмийг нь шингээдэг байлаа. Гэтэл энэ зургууд нь ч түүнд амь зуучихуйц орлого өгч чадахгүй байсан нь харамсалтай. Уран зураачдын хувьд их л бэрх үе иржээ. Үүнд вангийн эсрэг дөрвөн зүг найман зовхист цэргээ тараачихсан Конвент, нэгдэн нягтарсан Европын өмнө бохирч сөхрөөгүй, хатан зоригт омог бардам, өөрийгөө хуурагч, үл хайрлагч Конвент, улаан гараараа өөрийгөө тасчигч, ээлжит зорилтоо алан хядлага гэж тунхаглан, гишүүдээ хурдан гэгч Онц шүүхийн зууш болгох гэж яарагч хуйвалдагчийг шийтгэх үл энэрэгч Онц шүүх байгуулсан, үүний зэрэгцээ шинжлэх ухаан, сайн сайхан бүхний нөхөр тайвуун, бодлогошронгуй Конвент, хуанлийг өөрчилж<sup>7</sup>, тусгай сургууль байгуулаад уран баримал, уран зургийн уралдаан зарлаж, зурагчдыг урамшуулах шагнал бий болгон, жил болгон үзэсгэлэн гаргаж, Афин, Ромын жишээгээр музей нээсэн, нийтийн баяр ардын эмгэнэлийн өдрийг баяр ёслолын шинжтэй болгосон Конвент буруутай биш ээ. Гэвч Англи, Герман, Орос болон Польшид нэг үе тэгж их алдаршиж байсан францын урлаг одоо гадаадтай худалдаагүй болжээ. Уран зураг сонирхогчид, урлагийг үнэлэгчид, ихэс дээдэс, санхүүгийнхэн хоосорч, гадаадад дүрвэж, эсвэл нуугдсан байлаа. Хувьсгалаар хөлжсөн хүмүүс болох улсын газрыг худалдан авсан тариачид, дамчид, армид хүнс нийлүүлэгчид Паль Роял дахь тоглоомын газрын эзэд нь хогшил баялгаа сайрхан үзүүлж зүрхлэхгүй байсны дээр тэд уран зураг огтхон ч эс сонирхоно. Зураг худалдахад Реньо шиг цуутай, залуу Жерар шиг овсгоотой байх хэрэгтэй. Грёз, Фрагонар, Гуэн гуйлгачин болжээ. Прюдий, зурсан

зургаа Копиад өгч зураасан бараар барлуулан чүү чамай эхнэр хүүхдээ тэжээж, эх оронч зураачид Эннекен, Викар, Топино-Лебрэн өлсөж байлаа. Зуруулагч хүндээ өгөх ч, будгаа худалдаж авах ч мөнгөгүй Гамлен «Тамд өс авагч охин тэнгэрт мөшгөгдсөн харгис хаан» гэдэг зургаа асар том даавуун дээр дөнгөж эхлээд орхижээ. Дутуу орхисон, бодит хэмжээнээс ч том, аймаар амьтад, салаа хэлээ арзгануулсан ногоон могой язганасан тэр зураг өрөөний нь талыг эзэлжээ. Зургийн наад хэсэгт зүүн талд нь завин дотор зогсоо туранхай, догшин дүртэй Хароныг чадалтай сайхан зурсан боловч тэнд сургуулийн нөлөө орсон нь мэдэгдэж байлаа. Урлах өрөөний хамгийн гэгээтэй буланд өлгөөтэй байгаа мөн л гүйцээгүй, бага хэмжээний өөр нэгэн зураг түүнээс ч илүү бодитой, чадалтай болжээ. Үүн дээр үхлүүт хэвтээ Орестийг дүү Электра<sup>8</sup> нь өндийлгөж байгаагаар дүрсэлжээ. Залуу бүсгүй, ахынхаа нүд рүү унжих ширэлдсэн үсийг өрөвдөм хөдөлгөөнөөр янзалж байв. Орестийн толгой элэг эмтрэм гоё бөгөөд зурагчийн царай лугаа төстэйг нь харахаа андашгүй.

Гамлен, зохиомжийг нь гунигтайяа харах нь олонтоо. Бийрээ шүүрэн авах сан гэхээс загатнасан гар нь Электийн зоригтойёо таталсан дүрс рүү явах авч тэр дороо арчаагүй бууна. Зураачийн урам зориг бадран ихийг бүтээх хүслэн дүүрэн байв. Гэвч олны олхиогүй сонирхолд тохируулах, мөн алив дэмий юманд авьяасаа гарздаж чаддаггүйн улмаас хурууныхаа үзүүрээр ор нэр болгодог захиалгыг хийхэд хүчээ зарцуулах хэрэгтэй байлаа. «Түүний зурсан шог зургийг найз Демей нь нэг өнгөөр юм уу, өнгө ялган бузгай чадмаг барладаг ба Оноре гудамжнаа хэв худалдаалдаг иргэн Блез түүний нь хямдхан авдаг байжээ. Гэвч ойрмогоос юм авахаас цааргалах болсон Блез өдөр ирэх тутам хэвийн гүйлгээ муудаж байна гэж итгүүлнэ.

Гэтэл энэ удаа Гамленыг гачигдал зовлон нь ухаан оруулж, ядавч шинэ юм шиг бодогдсон санаагаа биелүүлбэл хэвийн худалдаачныг ч, барлагчийг ч, өөрийг нь ч баяжуулчихмаар санаа толгойд нь орлоо. Энэ нь эх оронч хөзрийн тухай санаа агаад хуучин дэглэмийн ноён хатан, боолыг нь суутнууд, эрх чөлөө, тэгш эрхээр солих ёстой байв. Тэрээр бүгдийнх нь нооргийг хийгээд ихэнхийг нь бүр гүйцээж барлуулахад болмоорыг нь Деманд өгөх гэж яарав. Өвдөгнийхөө завсар буугаа хавчуулан, их бууны овоолгоостой сум гишгээд бөмбөр дээр сууж буй гурван талт малгай, улаан энгэртэй албаны хөх хувцас, шар өмд, хар гутал өмссөн сайн дурын цэрэг л хамгийн дориун болсон

мэт түүнд санагдана. Энэ бол бундангийн боолыг орлосон «Бундангийн иргэн» юм. Хагас жил гаруй Гамлен сайн дурын цэрэг эрсийг зурж буй боловч сонирхол буураагүй л байгаа билээ. Бүх нийтийн сэтгэл хөөрсөн өдрүүдэд тэрээр хэдэн зураг заржээ. Бусад нь урлах өрөөний хананд өлгөөтэй байв. Усан будаг, шороон будаг, хоёр өнгийн харандаагаар зурсан тав зургаан ноорог ширээ, сандал дээгүүр хөглөрнө. Парисын талбай бүрд цэрэг элсүүлэх тавцан босгож, гинжээр чимэглэсэн гуанз болгоноос «Үндэстэн мандтугай! Эрх чөлөөтэй амьдаръя, эсвэл үхье!» гэж хашхиралдан байсан ерэн хоёр оны зургаан сард Гамлен Шинэ гүүрээр буюу захиргааны дэргэдүүр өнгөрөх тоолондоо гурван өнгийн даавуу уясан түшмэд нар «Марсельезын» аялгуунд сайн дурынхныг бүртгэж байсан, үндэсний далбаа хатгасан асрын зүг бүх бие сэтгэлээрээ тэмүүлэн байж билээ. Гэвч цэрэгт орвол эхийгээ аяга хоолгүй хаяна гэсэн үг байлаа.

Сэтгэл үймэрч царай нь улайн, хөлс нь цувсан бэлэвсэн авгай Гамлен хаалганы цаанаас дуулдам аахилан амьсгаадсаар өрөөнөө орж ирлээ. Оройвч малгадаа хааш яаш торгосон үндэсний тэмдэг нь хором бүрд уначихмаар санжганана. Сагсаа сандал дээр тавиад амсхийн зогсох зуураа тэрээр идэш уушны үнэ өндөр байна гэж үглэв.

Эрийнхээ амьд сэрүүн ахуйд Гамлен авгай Гренель-Сен Жермен гудамжнаа «Шательро хот» хаягтай мухлагт хутга мэсийн зүйлс худалдаж байсан бол одоо зураач хүүгийнхээ асрамжид түүний ядуухан аж ахуйг хөдөлгөн яваа билээ. Эварист хоёр хүүхдийн ууган нь юм. Онере гудамжнаа үйлчин байсан охин Жюле нь нэгэн язгууртны хамт хилийн чанадад зайлж гарсан болохоор түүний тухай асуугаагүй нь дээр биз ээ.

— Ээ бурхан минь гээд сүүрс алдсанаа авгай хүүдээ түүхийвтэр талх үзүүлэн, — Талх улам л үнэд орсоор, бас тэгээд цэвэр улаан буудайных биш байж шүү. Зах дээр өндөг, ногоо, бяслаг аль нь ч нүдний гэм. Туулайн бөөр идсээр байгаад өөрсдөө туулайн бөөр болох вий гэв.

Тэгээд нэлээд дуугүй сууснаа

— Гудамжинд нялх үрийнхээ амыг хөдөлгөчих юм юу ч үгүй хүүхнүүдтэй дайралдлаа. Ядуус юмаар туйлгүй гачигдах үе ирээ шив. Дэглэм журам сэргэн тогттол энэ явдал үргэлжилнэ дээ хэмээн түүний өгүүлэхүйд Гамлен ууртайяа хөмсөг зангидан

— Ээж ээ, бид идэх уух юмгүй зовж байгаад дамчин панзчид л буруутай. Иргэдийг бүгд найрамдах улсад дургүй болгон эрх чөлөөг устгахын тулд тэд ард түмнийг өлсгөлөнгөөр зовоон гадаадын дайсантай сүлбээлдэж байгаа юм. Бриссог<sup>9</sup> аялдан дагалдагчдын хуйвалдаан, Петионыхан, Ролланыхны<sup>10</sup> урвалт л ийм юманд хүргэж байна! Федералчууд зэвсэг барин Парис руу ирж өлбөрч үхээгүй байгаа эх орончдыг бут ниргэчхээгүй байгаа нь л яамай. Хором ч алдаж болохгүй, гурилд тогтвортой үнэ тогтоож, хүнсний барааг дамлагчид, ард түмний дунд самуун дэгдээгчид, мөн гадаадтай ялт харилцаа хийгсдийг цаазлах нь чухал, Конвент, хуйвалдааны хэргийг таслах онц шүүх саяхан байгуулсан. Үүнд дан эх орончид орох боловч эх орноо бүх дайснаас нь аврах хүч тэдэнд хүрэлцэх болов уу даа? Робеспьерт найдаж болно, тэр ачтай хүн. Ялангуяа Маратад<sup>11</sup> хамаг найдлагаа тавих хэрэгтэй, тэр ард түмэндээ хайртай, жинхэнэ гачигдал зовлонг нь ойлгож түүний төлөө үйлчилдэг билээ. Тэр хүн бүгдээс түрүүн урван шарвагчдыг илчлэн хуйвалдааныг илрүүлдэг. Тэр шударга, зүрхтэй хүн. Сөнөх аюул заналхийлж байгаа бүгд найрамдах улсаа ганц тэр л аварч чадна гэлээ.

Гамлен авгай толгой сэгсрээд тэмдгээ унацгаачхав.

— Эварист, боль, чиний тэр Марат бусдаас юугаар ч илүүрхэх юмгүй бултын л адил хүн. Нас чинь залуу, цус чинь шингэн болоод түүнийг сонирхож байгаа юм. Маратын тухай одоо ярьж байгаа «юмаа урьд Мирабо, Лафайета<sup>12</sup>, Пепион, Бриссо нар дээр ярьж л байсан шүү дээ.

— Хэзээ ч би ингэж яриагүй! гэж Гамлен ойрмогхон болж өнгөрснийг үнэхээрийн умартан зөрөв.

Цаас, ном, бийр, харандаа новшрон хэвтэх будаггүй модон ширээн дээр хэсэгхэн газар юмыг нь зайлуулаад Гамлен амгай сияан хувин, хоёр цайр таваг, хямд архитай нэг аяга, хоёр төмөр сэрээ, хар талх тавилаа.

Эх хүү хоёр шөлөө чимээгүйхэн ууж, гахайн бөөн өөхөөр хоолоо даруулав. Эх нь жижиг тонгоргоны үзүүр дээр өөхтэй жаахан талх тавин шүдгүй ам руугаа үе үе хийж үнэ ихтэй хоолоо хүндтэй гэгч нь иднэ.

Ихэнхийг нь хүүдээ үлдээсэн авч цаадах нь ямар нэгэн гүн бодолд сэтгэл самуурчээ.

— Эварист, ид, хүү минь ид гэж эх байн байн өгүүлнэ.

Энэ үгс нь алив нэгэн сургаал адил баяр баясгалантай сонстох ажээ.

Авгайг амьжрахад бэрх байна гэж ахиад гомдол мэдүүлэхэд Гамлен тогтвортой үнэ бол хүнд байдлаас гарах гав ганц арга мөн гэж хэлэв.

— Одоо хэнд ч мөнгө алга аа. Гадаадад дүрвэгсэд цөмийг нь аваад явчихсан. Итгэлтэй хүн ер байхгүй. Цөхрөлд оруулах юм бол бий гэж эх татгалзлаа.

— Боль, ээж ээ, боль! Түр зуурын үгүйрэл хоосролыг их юманд бодож болно гэж үү? Хувьсгал хүн төрөлхтнийг эгнэгт жаргуулна! гээд Гамлен түүнийг налав.

Эмгэн талхны хэлтэрхий архинд дүрэв. Дотор нь онгойн тэрээр вангийн мэндэлсэн өдөр задгай газар бүжиглэж явсан залуу зандан насаа инээмсэглэнхэн дурсав. Мэсийн дархан Жозеф Гамлен түүнийг зуучилсан тэр нэгэн өдөр сэтгэлд нь урган ирлээ. Энэ нь ямархуу янзтай болж өнгөрснийг санаандаа тодорхойёо өрж эхлэв. «Хувцасла. Гревын талбай дахь ноён Бьенассийн дэлгүүр лүү очиж Дамьеныг<sup>13</sup> дөрвөн мөчөөр нь салгахыг үзье» гэж ээж нь түүнд хэллээ. Сониучхан зантай хурсан олны дундуур тэд арайхийж гарав. Бьенассийнд залуу хүүхэн, дэгжин ягаан цамцтай Жозеф Гамлентай тааралдаад хэргийн учир хаашаа хэлбийхийг гадарлалаа. Хааныг хороогчийг хэрхэн бахиар хавчиж, хайлсан тугалгаар түлэн дөрвөн мориноос биеийг нь холбон таслаад галд хийхийг хүүхний харан байх үес ард нь зогсоо Жозеф Гамлен царайны нь өнгө үсний нь самналт гоолигхон биеийг нь гайхан бахдаад ханахгүй байж билээ.

Шилэн аягатайгаа дуустал уучхаад эмгэн амьдралаа үргэлжлүүлэн бодсоор байлаа.

— Эварист, де Лаллийг<sup>14</sup> цаазлахыг үзэх гэж яарсан сониуч улс Шинэ гүүрэн дээр жирэмсэн намайг унагаачих шахсанд би айсандаа чамайг дутуу гаргачихсан юм. Хумсын чинээхэн юм ертөнцөд мэндлэхэд чинь эмч ч чамайг хүн болно гэж бодоогүй билээ. Гэвч бурхан нигүүлсэн үзэж чамайг минь надад үлдээнэ гэдэгт би эргэлзээгүй юм шүү. Хүч хөдөлмөрөө хайрлалгүй чадах ядахаараа чамайг бөөцийллөө. Эварист, чи ачийг минь хариулан, хар багаасаа чадахынхаа хэрээр миний элбэрэл анхаарал тавьсанд хариу тус хүргэх гэж мэрийж байсан үнэнийг хэлэх хэрэгтэй. Чи төрөлхийн төвшин елдэг хүүхэд ээ. Дүү охин чинь тийм хар дотортой хүн биш боловч

биеэ тоосон түргэн ууртайгаараа чамаас ондоо. Түүнийг бодвол чи золгүй амьтан бүрд өрөвчхөн сэтгэлээр ханддаг байсан. Айлын дэггүй жаалууд шувууны үүр сандаахад чи тэднээс дэгдээхэйг нь булаан эхэд нь авч өгөх гэж үргэлж чармайдаг сан. Тэгээд ч зөвхөн газарт нухуулан хайр найргүй занчуулсны хойно л үүнээсээ буцах явдал цөөнгүй тохиолдсоон. Долоохон настайдаа дүрсгүй хүүхэдтэй огт зодолдолгүй гудмаар өөрийгөө сургамжлан томоотой гэгч явдаг байлаа. Өөртэйгөө дайралдсан гуйлгачин бүрийг надаар юм өгүүлэх гэж дагуулж авчран энэ заншлыг чинь болиулах гэж би чамайг нэвширтэл зодох удаа ч гарсан юм сан. Алив нэг хүний зовлон үзэхдээ чи нулимс мэлмэрүүлж байдаг аа. Чи өсөж торниод сайхан хархүү боллоо. Царайгаар бардамнан гангалж явдаг залуусаас ялгаатай нь чи үүнийгээ огт мэдэхгүй мэт байгаад би тун хачирхдаг байж билээ.

Эмгэн үнэн хэлж байлаа. Хорин настайдаа Эварист дур булаам мөртөө тун төв, Минервагийн<sup>15</sup> төрхийг хадгалсан, бүсгүй хүнийх шиг цэвэрхэн царайтай байлаа. Одоо хар нүд, цонхигор хацарт нь нууц тачаал, гүн уйтгар тодорно. Гэвч эхийгээ харахдаа түүний харц агшин зуурын дотор залуугийнх нь шиг төвшин эелдэг байдалтай болон хувирах ажээ.

— Чи зүс царайгаараа түрээ барин охид эргүүлж болох байсан. Гэтэл чи надтай хамт мухлагт үлдэхийг голчилдог байлаа. Тэгэхэд чинь миний банзлаас зуурах хэрэггүй явж нөхөдтэйгөө нарги гэж би заримдаа шаарддаг байсан шүү дээ. Чамайг сайн хүү гэдгийг амьсгалаа хураах үедээ ч давтан хэлнэ ээ. Эцгээ талийгаач болсны дараа чи надад тавих бүх халамжийг өөртөө үүрэхээс эмээсэнгүй. Хэдийгээр мэргэжил чинь ашиг олзоор маш хомс боловч чиний ачаар би гачигдаж зовох гэгч юу болохыг үзсэнгүй. Хэрвээ одоо бид үгүйрэн хоосордог юм гэхэд би чамайг зэмлэхгүй, энэ бүхэнд хувьсгал л буруутай гэв.

Гамлен дургүйцэн дохисон авч эх нь мөрөө хавчисхийлгэсэнээ

— Би язгууртан биш ээ. Баячуулын хүч чадалтай байх үед тэдний ноёрхлыг амссаан, тэднүүс эрх ямбаа хэтрүүлэн хэрэглэж байсан гэж би хэлэх байна. Герцог Каналейлийн барлагууд эцгийг чинь хурдан зайлж ноёндоо зам тавьж өгсөнгүй гэж улаан нүүрэн дээр минь саваагаар занчиж билээ. Тэр австри хүүхэн<sup>16</sup> дэндүү ихэрхэг зантай, их үрэмхий болохоор нь дургүй минь хүрдэг юм. Ван ч яах вэ, би тийм муу хүн гэж боддоггүй байсан минь үнэн, зөвхөн түүнийг шүүн тасалсны хойно л эндүү санаж байснаа ухаарсан юм. Хэдийгээр

хуучин дэглэмийн үед бага ч атугай баяр хөөр амсаж байсан боловч түүнийг устсанд харамсаагүй л дээ. Гэвч чи хувьсгал тэгш эрх тогтооно гэж бүү ярь, хүмүүс хэзээ ч тэгш эрхтэй болохгүй. Тануус орон даяар замбарааг нь алдуулсан ч гэсэн энэ нь бүтэшгүй зүйл, хэзээ ямагт хүмүүс баян хоосон, тарган туранхай байх болно гэв.

Тэрээр ийнхүү хуучилсаар сав суулгаа хураав. Зураач аль хэдийн түүнийг чагнахаа болиод хөзрийнхөө устгасан гилийн боолын оронд хийх ёстой улаан малгай, ар хормой нь урт хүрэм өмссөн санкюлотын дүрсийг эрж байлаа.

Нэгэн хүн хаалга тогшин, балтгар нуруутай, өндрөөсөө өргөөшөө илүү, шар үс, майга хөлтэй, зүүн нүдэнд нь цагаа унасан, баруун нүд нь цэхэр тул бараг цагаан үзэгдэх, пэмбэгэр зузаан уруулыг нь дорсгой шүд нь дорвойлгосон нэгэн залуухан тариачин хүүхэн үүдээр орж ирэв.

Тэрээр Гамленд хандан зураач мөн бишийг нь лавлаад Арденны армийн сайн дурын цэрэг сэтгэлт хархүү Ферраных нь зургийг зурж өгөхөөс татгалзах эсэхийг магадлав.

Баатарлаг дайчныг Парист буцаж ирэнгүүт нь хөргийг дуртайяа зурж өгье гэж Гамлен хариуллаа.

Бүсгүй, одоохон зураад аль гэж төлөв атлаа шаргуухан шалав. Зураач өөрийн эрхгүй инээмсэглэн, харж зурах юмгүй, энэ нь даанч боломжгүй зүйл гэж татгалзав.

Хөөрхий бүсгүй юу ч дуугарсангүй. Ийм бэрхтэй юм болно гэж тэр зүүдэлсэн ч үгүй. Зүүн мөр лүүгээ толгойгоо гилжийлгэн гэдсээ тэвэрч тэрээр уй гашуундаа мангуурсан мэт дуу шуу ч үгүй, дороо хөдлөлгүй зогсоно. Түүний гэнэн хонгор байдал сэтгэлийг нь сэргээсэнд Гамлен, заяа мөхөс дурлалт бүсгүйн санааг засахаар усан будгаар зурсан нэгэн цэргийн зургийг түүнд өгөн Арденнд байгаа хар хүүтэй чинь төс байна уу гэж асуув.

Хүүхэн сүүмгэр харцаар цаасыг ширтэн эрүүл нүд нь бага багаар сэргэн гялалзсаар баяр хөөрөөр гэрэлтэн, өргөн нүүрэнд нь баясгалант инээмсэглэл тодорлоо.

— Тийм ээ, тэр мөн байна. Ферран Жюль, амьд Ферран Жюль яг дүрээрээ байна гэж бүсгүй хэлэв.

Зураач зургаа түүнээс авч амжаагүй байтал тэрээр бүдүүн улаан хуруугаараа цаасыг нямбай гэгч дөрвөлжлөн эвхэж цамц бошинз хоёрынхоо завсраар өвөртлөн Гамленд таван ливрийн цаасан тэмдэгт

өгөөд тэнд байгсдад сайн сайхныг хүсэн ерөөсөөр өрөөнөөс гуйвсаар  
хурднаа гарч одлоо.

### III

Тэр өдрөө үдийн хоолны дараа Эварист, Оноре гудамжнаа Шуудангийн албан тасалгаанаас холгуйхэн Ораторийн өмнө орших «Амур - Зураач» гэдэг хаяг бүхий мухлагтаа зөвхөн хэв ч биш хайрцаг, шахмал цаасан эдлэл, төрөл бүрийн тоглоом худалдаалдаг иргэн Жан Блезийнх рүү явлаа. Зургаан жилийн өмнө барьсан хуучин байшингийн нь доод давхарт мухлаг байдаг билээ. Орох хаалганы нуман тотгон дээр хүн дүрст мангасын эвэртэй толгойн шавмал чимэг байх ба хаалганы дээд самбарт нь бүр 1770 онд Жан Блезийн эцгийн өлгөснөөс хойш одоо болтол нар бороонд ихэд гандсан, Бушегийн зургаас хуулбарласан «Сицийлица буюу Амур - зураач» гэдэг тосон будгийн зураг байх ажээ. Хаалганы хоёр тал, цонхны янзыг нимфа<sup>17</sup> бурхны толгойгоор гоёсон агаад зөвхөн Парист л байсан хамгийн том шилэн цонхны цаана гоёмсог хэв, өнгөт барын салбарт гарсан сүүлийн үеийн шинэ зүйлс дэлгэж байв. Буалийн чадмаг боловч тун хайхрамжгүй зурсан, якобинчуудын дургүйг хүргэгч, зарим хэнээтнүүдийн нь Урлагийн нийгэмлэгт алтан хошуу өргөх шалтаг болсон «Эр эмийн янагийн ажил», «Ичингүйрэн татгалзсан нь» зэрэг дурлалын сэдэвт зураг Дебюкурын, гурван сандал дээр халхайн суугч дууч бялзуухайн өнгөт өмдтэй хээнцэр эрийг дүрсэлсэн «Ардын зугаалга», залуу Карл Вернегийн хийсэн морьд, аэростатууд «Виргинийн угаалга», өнө эртний баримлын хуулбар зэргийг тэр өдөр үзэж болох байлаа. Мухлагийн дэргэдүүр тасралтгүй хөврөн хөлхөх иргэдийн дотроос алив юм үзэх дуртай сэтгэмтгий ноорхойчуул л үзмэрийн сонирхол татам хоёр цонхны өмнө бусдаас удаан зогсож энэ ертөнцийн жаргал цэнгэлээс өөрийн хувийг нүд хужирлахын төдий ч атугай эдлэхийг хичээх бөгөөд мэл гайхан цэл хөхрөн таг дуугүй дороо зогсох тэдний дэргэдүүр язгууртнууд тоомсоргүйхэн ширэв татсанаа хөмсөг зангидан өнгөрнө.



Эварист, бүр алсаас, дөнгөж байшингийн барааг хармагцаа хоёрдугаар давхрын, хаалганы зүүн талын угалзат төмөр сараалжны нь цаана ваартай улаан лиш цэцэг тавьсан цонх өөд ширтэв. Жан Блезийн охин Элодийн өрөөг энэ цонх гийгүүлдэг юм. Хэвийн худалдаачин, цор ганц охиныхоо хамт мухлагийн дээд давхрыг бүхэлд нь эзлэн суудаг билээ.

Амьсгаагаа дарах гэсэн мэт үүдэнд нь саатасхийснээ Эварист хаалганы бариулыг эргүүлэв. Худалдан авагчийн бусдыг нь дотроос хичээнгүйлэн сонгож авсан Фрагнор хүү, Нежон нарын хоёр барыг дөнгөж зараад Элоди авсан төгрөгөө хайрцагт хийхээсээ урьдтай, тэр үед худалдаанд их хохирол учруулж байсан хуурамч мөнгөн тэмдэгт жинхэнэтэйгээ тэнцэхүйц их гүйлгээнд байсан тул тэднийг гэрэлд барин хөөрхөн нүдэндээ нэг нэгээр нь ойртуулж далд тэмдэг, судал, өлзий зэргийг анхааралтай ажиглав. Урьд вангийн гарын үсгийг дуурайлгасан гэмт хэрэгтнүүдийг нэгэн үе шийтгэж байсанчлан хуурамч мөнгө үйлдэгсдийг хороох ял ноогдуулж байсан ч мөнгө хэвлэх ялтас зоорь бүрээс олдож, мөн бүгд найрамдах улсын нэр хүндийг хугалах, эх орончдыг хоосруулахын тул швейцарчууд франц руу хуурамч төгрөгийг сая саяар нь зөөвөрлөн авчирч зуушны газруудад багц багцаар нь тараан хаяж, англичууд дуурайлгамал пиуг боодол боодлоор нь манай эрэг дээр өдөр бүр буулгаж байлаа. Хуурамч цаас авчихаас Элоди эмээж, бас өөрөө дуурайлгамал тэмдэгт заран Питтын<sup>18</sup> хамсаатан гэдэг нэр олчихоос бүр ч их айж байлаа. Гэвч тэрээр төөрөгт одондоо найдан хэзээ ч мултарч дөнгөнө гэдэгт итгэнэ.

Ямар ч инээмсэглэлээс илүү дурлалыг илчлэх тэр гунигт царайгаар Эварист Элодийг харав. Цаадах нь хархан нүдээ үл мэдэг аньсхийн доогтойхон мишилзэж түүнийг хялавхийн харсан нь нэгдүгээрт тэрээр өөрийгөө залуугийн сэтгэлтэй хүн нь гэж мэдсэнийх, тэгээд ч энэ нь түүнд нэлээд таатай санагдсаных, хоёрдугаарт ийм царай нь янаг залуугаа өдөн, гомдлоо тоочиход нь түлхэц болох хийгээд хэрвээ дурлалаа нээгээгүй аваас илчлэхэд хүргэдэг билээ. Харин энэ удаад бол яг тийм байв.

Мөнгөө хайрцагтаа хийгээд ажилдаа авч явдаг сагснаас нэхэж байсан хүзүүний цагаан даавуу ороолт аван сүлжиж гарав. Тэрээр ажилд ягшуур, аальгүй бөгөөд зүү утас нийлүүлж суухдаа харчуулд таашаагдах, өөртөө гоёл хийх хоёр зорилгыг зөнгөөрөө агуулдгийн дээр тааламжтайяа хүлээлгэн зовооё гэсэн хүнийхээ дэргэд их л хайхрамжгүй, цөхрөнг нь барвал аятайхан мэт санагдсан хүнийхээ дэргэд ааш муутай нэхэх зэргээр хэн түүнийг шохоорхож вэ гэдгээс шалтгаалж янз бүр нэхдэг билээ. Одоо тэрээр Эваристын сэтгэлийг ахиухан хөндөх гэж ажилдаа хамаг анхаарлаа тавьсан дүрэм үзүүлнэ.

Элоди тийм ч залуу, тийм ч хөөрхөн хүүхэн биш билээ. Халти харахад бол царай муутай ч үзэгдэж мэднэ. Хар үс, чидун жимс лүгээ адил царайтай түүний хайхрамжгүй зангидсан алчуурынх нь дороос мушгирсан хар үс нь бултайн хар хүрэн нүд нь тормолзоно. Шалихгүй шонтгор хамар, төвгөр шанаа, эв хавгүйдүү боловч тачаангуй байрын баясгалантай дугуй царай нь хачин аальгүй инээмсэглэлээрээ залуугийн бахдалыг төрүүлдэг ой хээрийн бурхан Боргезийн толгойн барималтай адилхан нь зураачийн нүднээ тусна. Живэр нь уруулын нь тачаангуйг илтгэж байлаа. Тэр жирийн маягаар зөрүүлж зангидсан алчуурын дороос товгор хөх нь хайр энхрийллээр дүүрсэн мэт төмбийнө. Уяхан бэлхүүс, шаламгай хөл, чийрэг бие нь дур татам онгон хөдөлгөөнөөр хөдлөх ажээ. Харц, амьсгаа, хормойны нь чичиргээ цөмөөрөө дурлалыг амлан зүрхнээ шивнэнэ. Лангууны ард тэрээр бүжгийн тэнгэр, Шардены маягийн<sup>19</sup> жирийн эзэгтэй болгон гайхалтайгаар хувиргахын тул шилүүсэн хэвнэг, шидэт таяг, ороонго титмийг нь авчихсан дуурийн вакханг<sup>20</sup> мэт санагдаж байлаа.

— Аав гэртээ алга. Удахгүй ирнэ, жаахан азна гэж бүсгүй зураачид хэлэв.

Жижигхэн бор гар дахь зүү нь нимгэн цагаан даавууг түргэн түргэн хатгана.

— Ноён Гамлен, танд энэ зураг таалагдаж байна уу?

Гамлен хуурамч зан гаргаж чадахгүйн дээр дурлал нь түүнийг зориг оруулан ний нуугүй байхад хүргэв.

— Бүсгүй минь, та маш уран нэхэж байна аа. Гэвч миний саналыг сонсох нь танд тааламжтай байгаа бол танд зурж өгсөн угалзыг энгийн ч гэхэд хэцүү, нарийн ч гэхэд хэцүү, ер нь Францад нэхмэл эд, гэрийн тавилга, замын чулуу зэргийг чимэглэх урлагт дэндүү удаан ноёрхсон чимэглэлийг чамин маягаараа санагдуулж байна. Энэ цацаг, гинж сүүлчийн хааны үед амжилт олж байсан утгагүй, болхидуу маягийг санагдуулж байна. Маяг барил сэргэжээ. Халаг гэж! Бид алсаас эхэлж байна. Жигшүүрт XV Людвикийн үед гоёл чимэглэлийн урлагт хятадын нөлөө нэвтэрсэн юм. Хоргыг цүдгэр, болхи матмал сэнжтэй хийсэн нь эх орончдын зуух галлахад л хэрэг болно. Эгэл жирийн юм л сайхан. Эрт дээр үе рүүгээ эргэж орох нь чухал. Давид, Геркуланумын ханын зураг, этруссын ваараас санаа аван ор, сандлын зургийг хийж байгаа хэмээн Гамленыг хэлсэнд

— Би тэр ор, сандлыг үзсэн. Тун гайхалтай юм билээ. Мөдхөн өөр тавилгыг хэн ч тоохоо болих байх аа. Тан шиг би бас дээр үеийг эрхэмлэдэг юм гэж Элоди тосон авч өгүүлэв.

— Тэгэхлээр, бүсгүй минь, та ороолт дээрээ грекийн хээ, ороонгын навч, могой буюу зөрүүлсэн сум хатгасан бол спартын эмэгтэй.... болон танд тохирох байсан сан. Гэхдээ энэ угалзыг арай хялбарчлаад, арай шулуутгаад хэвээр нь байлгасан ч болно л доо гэж Эварист үргэлжлүүлэн хэлэв.

Түүний саналаар бол чухам алийг нь авч хаявал зүгээр болохыг хүүхэн асуулаа.

Залуу ороолт руу тонгойвоос Элодийн үс хацрыг нь шүргэв. Даавууг барьж үзэж байсан хоёр гар уулзан амьсгал нь нийллээ. Энэ хоромд Эварист энгүй их баяр хөөрийг амсан байсан авч Элодийн уруул өөрийнхөд нь тийм ойрхон байгааг мэдрэхтэйгээ зэрэг бүсгүйг гомдоочихоос эмээн хурднаа хөндийрэв.

Блез бүсгүй Эварист Гамленд хайртай байлаа. Залуу эрийн цогтой том нүд, гонзгойдуу, цайвар атлаа цэвэрхэн царай хагалан янзалж мөр лүүгээ долгиотуулан унжуулсан өтгөн хар үс, ихэмсэг намба, хүйтэвтэр төлөв, ширүүн авир, ямар ч бялдуучлал үгүй итгэл төгс яриа эл бүгд хүүхэнд гайхамшигтай санагдана. Ийнхүү хархүүд дурласан болохоор хүүхэнд цаадах нь эрт орой алин боловч урлагийн

гайхамшигт бүтээлээр цоорон гарч, нэрээ дуурьсгах агуу их зураачийн авьяас билигтэй мэт бодогдоно. Энэ тухай бодол нь дурлалыг нь улам ихэсгэнэ. Блез хүүхэн эрчүүдийн бүрэг занг таашаадаггүй, хэрвээ эр хүн шунал тачаалдаа дийлдэн хүслээ хангадаг юм гэхэд журмын сэтгэлийг нь өчүүхэн ч хөндөхгүй байх сан билээ. Цэцэн цэлмэг Эваристэд тэрээр хайртай хийгээд гэхдээ түүний эм хүнд хавьтаагүйд нь сэтгэлтэй болсон биш боловч түүнтэй цуг байхад хардах сэрдэх юмгүй, өрсөлдөгчөөс болгоомжлох явдалгүй байсан болохоор үүнд сайн тал бий гэж бүсгүй үзнэ.

Гэвч энэ хоромд Гамлены хэтэрхий хөдөлгөөнгүй юм гэдгийг нь хүүхэн мэдэв. Хэрвээ Ипполитад дурласан Расинова Ариция залуу баатрын догшин ачлалыг гайхан байсан авч дийлнэ гэдэг горь тасраагүй бөгөөд Ипполит илүү тэсвэртэй байсан бол бүсгүй авир араншны ширүүнээс болж цөхрөх сөн биз. Завшаан гармагц Ариция залуугийн хариу үгийг алдуулах гэж өөрөө сэтгэлээ бараг илчилсэн билээ. Наалинхай Ариция лугаа адил Блез бүсгүй эмэгтэй нь эхлэн дурлалаа ханзлах ёстой гэдэг бодлыг буруушаахгүй байв. «Хамгийн их дурласан, мөн хамгийн аймхай хүүхнүүд л тус, дэм харж байдаг юм. Эмэгтэй хүн эрэгтэй хүнд бүрэн бууж өгч болно гэж тэд тун гэнэ алддаг, гэтэл зоригтойгоор давшилтад орж ялгуулан ялалт хийлээ гэдэг сэтгэл төрүүлчихвэл цаадах нь түүнийг нь анзаарахгүй шүү дээ» гэж Элоди бодно. Хувьсгалаар баатар болон хувиртлаа Эварист нь Академийн хаалгач байсан царай тааруухан хүүхэнд, жирийн хүмүүсийн адил л сэтгэлтэй байсан гэдгийг нь лавтай (энэ талаар тэр огт эргэлзсэнгүй) мэдэж авснаас хойш энэ явдал яаж шувтрах бол гэж эргэлзэхээ больжээ.

Гэнэнд тоолж яагаад ч үл болох Элоди дурлалыг хэдэн төрөл болгон ангилна. Эваристийн түүнд төрүүлсэн сэтгэл ханилан суух тухай ноцтой бодож болохуйц гүн байлаа. Тэрээр Гамлентай дуртайяа суух байсан боловч эцгээ, ядуу зүдүү алдар нэргүй зураачид ганц охиноо өгөхөөс татгалзах вий гэж болгоомжилно. Гамлен юу ч үгүй хоосон, гэтэл хэвийн наймаач, мөнгөөр туйлж байдаг хүн билээ. «Амур - зураач» чамлахааргүй, биржийн тоглоом нь бүр ч их орлого оруулдаг хийгээд сүүлийн үед морьт цэргийн ангид өвсний оронд зэгс, ялзарсан овьёос нийлүүлэгч нэг хүнтэй түнш болсон билээ. Сен-Доминик гудамжны мэсийн дархны хүү нь Блезо, Базин, Дидо нарын хамаатан, Сен-Пьер, Флориан зэрэг иргэдийнхээр гүйдэлтэй, Европ даяар цуутай

хэв үйлдвэрлэгчтэй жишвэл үл ялих хүн. Дуулгавартай охины янзаар Элоди хувь заяагаа шийдэхдээ эцгийнхээ дур зоригийг харгалзахаар хүн биш ээ. Сувдаг, сээхэлзүүр, хүүхэн хөөмтгий, ажлын дадлага ихтэй Жан Блез залуудаа бэлэвсэрсэн ба охиноо гойд анхааран халамжилж байсангүй, балчраас нь зоргод нь тавьж, сургамжилж хайрлах гэж хашраасангүй, охиныхоо зан авирыг хайхардаггүй байснаар үл барам эмэгтэйчүүдийг мэдэх талаар гоц хүн болохоор түүний түргэн ааш, мөн сайн сайхан царайнаас илүү хүчирхэг зэвсэг болох хүний зүрхийг эзэмдэж авах чадварыг нь өндрөөр үнэлдэг боловч юу ч анзаарахгүй байхыг мэрийдэг байлаа. Биеэ гамнадаггүй хэтэрхий дур хүсэл ихтэй, өөрийгөө балалчихааргүй дэндүү няхуур, ухаан зүггүй аашлан байхдаа ч хянамгай зангаа тавьдаггүй Элоди шунал тачаалаа өргөн барихдаа ч ёс гормыг ер умартдаггүй билээ. Эцэг энэ болгоомжлолыг нэн ч ойшоон үзэх ба өөрийн нь наймааны авьяас, ов мэхийг дуурайсан болохоор нас гүйцсэн хүүхнийг хань бүлтэй болохоос бариад байгаа нууц шалтгааныг сонирхдоггүйн дээр Элоди нь гэртээ байхдаа дөрвөн даамалтай эгнэхүйц үүрэг гүйцэтгэн аж ахуйгаа хөтлөн байдаг учир түүнд нь огт дургүйцдэггүй ажээ.

Хорин долоон настайдаа Элоди амьдралаа зохиочихуйц хашир суусан, насанд хүрснээ ухварлан, залуу, хөнгөмсөг, хайнгуут эцгийнхээ дурыг дагах, зөвлөгөөг нь авах ямар ч хэрэгцээгүй гэж үзэж байлаа. Гэвч ноён Блез ядуу хүргэнээ төвхнүүлэн, пүүсийн нэг хоршоо хүн болгон олон зураачийг ажлаар хангаж байсанчлангаа түүнд ажил олгож мөн амь зуучихмаар хөрөнгө ямар нэг аргаар олж өгсөн цагт л Элоди Гамлены эхнэр болж чадах байлаа. Гэлээ ч эцэг, Гамлен хоёр нь төдийлөн сайнгүй болохоор бүсгүй эцгийгээ залууд тийм дэмжлэг үзүүлж нөгөө нь түүнийг авна гэдэг боломжгүй хэмээн тооцно.

Энэ учраас зөөлөн сэтгэлт ухаалаг Элоди нэлээдгүй хүнд байдалд оржээ. Байгаль ертөнцийг бий болгогчийг харилцан үнэнч байхын ганц гэрч болгон амрагтайгаа далдуур ханилахаас тэр өчүүхэн ч үл хулчийна. Амьдралыг өөрийнхөөрөө үздэг Элоди дураараа байдаг болохоор тийм холбоо тогтооход бүрэн боломжтой, зохисгүй юм үүнд огт үгүй гэж бодох агаад үнэнч сайн Эваристтай тэр нь ёстой бат бэх байх сан. Гэтэл Гамлен чүү чамай хоолоо олж иддэг бөгөөд бас настай эхээ тэжээх ёстой учир ийм ядуу үед түүний зүрхнээ, хамгийн энгийн ч атугай дурлалын зай үзтэл үлдсэнгүй бололтой. Тэгээд бас Эварист түүнд сэтгэлийнхээ тухай ер цухуйлгаагүй санал бодлынхоо тухай

ганц ч үг дурсаагүй юм. Хэдий тийм боловч Блез хүүхэн түүний дурлалын үгийг мөдхөн хэлүүлж дөнгөх биз хэмээн горилно.

Элоди ажил, хөвөрсөн бодлоо бүрмөсөн таслан

— Иргэн Эварист, энэ ороолт таны сэтгэлд нийцсэн тэр цагт л минийхэд таарна. Надад угалз зурж өгөөч дээ, би танаас гуйя. Харин Пенелопа<sup>21</sup> шиг таны байхгүйд хийснээ урчихъя гэв.

— Тэгье ээ, бүсгүй минь. Би танд Гармодын юлд буюу гинжээр ороосон сэлэм зурж өгье хэмээн Гамлен гунигтайхан авч урамтай нь аргагүй өгүүллээ.

Харандаагаа аван тэрээр өөрийн ихэд дурладаг нарийн чанд маягаар юлд, цэцэг хоёрын хээг зурж гарав. Энэ зуураа тэрээр урлагийг үзэх үзлийнхээ талаар хүүрнэнэ.

— Оюун санааны талаар дахин төрсөн францчууд хамжлагат ёсны олиггүй сонирхол, олиггүй хэлбэр, олиггүй зураг зэрэг өв уламжлалыг орхих хэрэгтэй. Ватто, Фрагонар, Буше нар харгис хаад болон боолчуудад ажил хийж өгч байлаа. Тэднүүсийн бүтээлд жинхэнэ арга маяг цэвэр чиглэлийг ойлгох сэтгэл, бодит байдал үнэн юм алга аа. Баг, хүүхэлдэй, хог новш, маягаас цааш юм алга! Тэдний хөнгөмсөг нялаасыг хойч үе жигших болно. Зуун жилийн дараа Ваттогийн зургууд цөм мартагдан дээврийн хөндийд ялзран хэвтэж 1893 онд уран зургийн сургуулийн сурагчид Бушегийн зурсан зурагтай даавуун дээр нооргоо хийн баллана. Давид бидэнд шинэ зам зааж өглөө. Тэр эртний урлагт ойртож яваа боловч бас энгийн гэхэд ч хангалтгүй, аугаа гэхэд ч хангалтгүй, ширүүн ч гэхэд хангалтгүй байна. Геркуланумын ханын зураг, ромын товгор хээ, этруссын ваараас манай зураачдын сурах юм зөндөө.

Тэрээр өнө эртний сайн сайхны тухай удтал хууч хөөрөөд дараа нь яс махнаасаа үзэн яддаг Фрагонарын тухай ярианд шилжив.

— Бүсгүй та түүнийг таних уу?

— Элоди танина гэж толгой дохилоо.

— Та бас Грез өвгөнийг мэдэлгүй яах вэ дээ, оготор улаан дээл өмсөж ташаандаа юлд санжгануулаад мөн ч инээдтэй шүү. Гэвч Фрагонарыг бодвол тэр эртний грекийн мэргэдийг санагдуулдаг юм. Ойрмогхон би Пале-Эгалитын гулдан хаалган тушаа муу новштой дайралдав аа. Оо түрхсэн нялганасан, гэдэлзэж годолзсон, марзганасан зэвүү хүрэм амьтан хаашаа ч юм шогшин явахгүй юу. Тэр өрөвдөм өвгөнийг хараад би, Апполлоны эзгүйд урлагийн ямар нэг хичээнгүй

зүтгэлтэн, Марсийгийнх шиг арьсыг нь урьдчилан хуулаад муухан зураачдад сургамж болгон модноос түүнийг дүүжлээсэй гэж хүсэж билээ.

Элоди хөгжилтэй янаг харцаа түүнээс салгалгүй ширтэн:

— Ноён Гамлен, та үзэн ядаж чаддаг юм байж. Энэ чинь та дур...  
гэтэл

— Гамлен та юу? гэсэн бүдүүн дуу сонсогдсон нь иргэн Блез гутлаа чохруулан хармааны цагны оосрын унжлагаа хангир жингэр хийлгэн мухлагт орж ирсэн нь тэр ажээ. Том гэгчийн гурвалжин хар малгайны нь нугалсан үзүүр мөрөнд нь хүрч сюртук цамцны хормой хөдөлнө.

Элоди ажилдаа авч явдаг сагсаа аваад өрөө өөдөө өгсөв.

— За юу гээ вэ. Гамлен, ямар нэг шинэ юм авчраа юу? гэж Блезийг асуухад

— Тийм л санаатай гэж зураач өчив.

Тэгээд санаагаа хэлсэн нь:

— Манай тоглоомын хөзөр орчин үеийн байдалтай эрс тэс зөрчилдөж байна. «Боол», «ноён» гэдэг нэрсийг эх орончид сонсоход ч муухай. Ноён, хатан, боолыг нь эрх чөлөө, тэгш эрх, ахан дүүсэг ёсоор сольсон шинэ хувьсгалт хөзрийн зургийг зохион зурлаа. Бараа бологчийн туузаар эмжсэн тамгыг хууль гэж нэрлэх юм. Ингэхлээр та цэцгийн эрх чөлөө, гилбэрийн тэгш эрх, дөрвөлжний ахан дүүсэг ёс, бундангийн хуулиар явах болно. Энэ хөзрийг овоо аятайхан зурлаа гэж бодож байгаа юм. Үүнийг Деманд өгч зэс дээр барлуулаад тэмдэгт авах санаатай.

Зураач хавтаснаас хэд хэдэн усан будгийн зураг гарган хэвийн худалдаачинд сарвайв.

Гэтэл иргэн Блез түүнийг нь харсан ч үгүй авахаас татгалзлаа.

— Наадхыгаа найз минь, Конвентэд л аваач. Тэнд л нижигнэтэл алга таших болно. Харин та энэ шинэ бүтээлээрээ сохор зоос ч олно гэж бүү горьд, тэгээд ч наадах чинь шинэ юм биш. Та жаахан хожимдчихож. Таных, надад авчирч өгсөн хувьсгалт хөзрийн гурав дахь болж байна. Танай нөхөр Дюгур өнгөрсөн долоо хоногт дөрвөн тэнгэр, дөрвөн эрх чөлөө, дөрвөн тэгш эрхтэй пикет<sup>22</sup> тоглох хөзөр өгөх гэсэн. Мэргэд, баатрууд, Катон, Руссо, Ганнибал гээд тогтоож барамгүй баахан нэртэй хөзрөөр бас намайг татах гэж оролдсон... Найз минь, энэ хөзрүүдийг модон дээр харандааны хутгаар дүй муутайхан

сийлсэн буюу зурсан байснаараа чинийхээс нэг илүү талтай. Наадагчдыг, Давидын барилаар зурсан Бартолоццын маягаар барласан зурагтай хөзрөөр тоглоно гэж бодож байгаа бол тануус хүмүүсийг мэдэхгүй л байна даа! За тэгээд ер нь хуучин хөзрийг орчин үеийн үзэл санаанд тохируулахад ингэж ёсорхох хэрэгтэй мэт бодож байгаа бол жигтэйхэн эндүүрч байгаа хэрэг. Сайхан сэтгэлт санкюлотууд «Харгис хаан» эсвэл «Тарган бодон» гэж дуудан явж хөзрийнхөө эх оронч үзэлд харшилж байгааг нь гойд залруулж байгаа билээ. Тэд хуучирсан хир болчихсон хөзрөө хэрэглээд шинийг авахгүй байна. Пале-Эгалитын үүрэнд өдөр шөнөгүй шахуу тоглож байдаг, тийш очиж ловон, хөзөрчдөд тэр эрх чөлөө, тэр тэгш эрх, тэр... та юу гэж нэрлэлээ... тэр цэцгийн хуулиа аваачиж өг, тэгээд тэнд таныг хэрхэн хүлээж авсан тухай надад яриарай.

Иргэн Блез лангуу сандайлан шар борог даавуу өмд дээрээ цацагдсан тамхийг хэдэнтээ няслан гүвээд Гамленыг туйлын өрөвдөнгүй харав.

— Иргэн зураач, би танд нэг юм зөвлөе, хэрвээ та амь зуух юм олъё гэж байвал энэ эх оронч хөзөр, энэ хувьсгалын бэлгэ тэмдэг, энэ Геракл, Гидра могой, гэмтнүүдийг мөшгөгч өс авагч охин тэнгэр, эрх чөлөөний тэнгэр, энэ тэр юмнуудаа хаяж гоо охидын зураг зур. Цаг өнгөрөх тутам хүмүүсийн эх оронч гал дөл буурна, тэгвэл эрчүүдэд хүүхэн таалагдахаа болино гэж байхгүй. Жижигхэн хөлтэй, жижигхэн гартай ягаахан бүсгүйчүүдийг зур. Хувьсгалыг хэн ч сонирхохоо байж үүн тухай сонсохыг ч хүсэхээ больсон гэдгийг ойлго.

Эварист могойд хатгуулсан мэт үсрэн босов.

— Юу? Хувьсгалын тухай сонсохыг ч хүсэхгүй байна гэнэ ээ? Эрх чөлөөний батжил, манай армийн ялалт харгисуудыг шийтгэсэн энэ бүх үйл явдлууд хойч үеийн үр сад нарын маань гайхлыг төрүүлэхгүй гэж үү? Үүгээрээ бахархахгүй байж бид яаж чадах бил ээ?.. Яагаад? Санкюлот Есүсийн шашин арван найман зуун жил хэртэй ноёрхсон байхад Эрх чөлөөний шүтээн дөрөвхөн жилийн ч нүүр үзэлгүй дарагдах юм уу?

Жан Блез илэрхий дээрэнгүй байртай татгалзан өгүүлрүүн:

— Та нар хий мөрөөдлөөр амьдарч байна, тэгвэл би бодит амьдралаар амьдарч байна. Найз минь, хувьсгал дэндүү удаан сунжирч, одоо түүнээс уйджээ гэдэгт үнэмш. Урам зориг сэргээсэн таван жил гэнэ, таван жил ах дүү мэт тэврэлдэж, алан талж, далан хэл

дэлгэж, марсальезыг хашхиралдаж, түгшүүрийн харанга дэлдэж, язгууртнуудыг дэнгийн шонгоос дүүжилж, хүмүүсийн толгойг жаданд өлгөж, эмс хүүхнүүдийг их буун дээр мордуулж, улаан малгайгаар чимсэн Эрх чөлөөний мод гэдгийг тахиж, цэцгээр чимэглэсэн тэргээр цагаан өмсгөлтэй өвгөд охид зорчлоо. Таван жил шоронд хатааж цаазаар авч хувь ноогдуулж, зарлал нааж, тэмдэг соновтор хадаж зэр зэвсэг хангир янгир хийлгэлээ... Гүйц ээ! Эцсийн эцэст хэн ч юу ч ойлгохоо больжээ. Сүүлд нь Торпейн хясаан<sup>23</sup> дээрээс чулуудахын тул Капитолийд<sup>24</sup> та нарын оруулсан аугаа хүмүүсийг харж ханалаа. Бид тэр Неккерүүд Мирабо, Лафайетүүд, Байль, Петиончууд, Манюэлийнхан болон бас бус улсыг үзлээ. Тануудыг, одоо шинэ баатрууддаа ийм хувь хүртээхгүй гэдгийг хэн батлах юм?.. Одоо хэнд ч итгэж болохгүй!

— Хэлээдхээч иргэн Блез, ямар баатрын амийг бид бусниулах гэж байгааг надад хэлээдэх! гэж Гамлен болгоомжтой байхыг хэвийн худалдаачинд сануулсан аялгаар дуу алдав.

Гэтэл цаадах нь зүрхээ даран

— Би эх оронч хувьсгалч хүн. Иргэн Гамлен би тан шиг л бүгд найрамдагч, тан шиг л эх оронч хүн. Таныг бүгд найрамдах улсад үнэнч гэдэгт би эргэлзээгүй, таныг тогтворгүй гэж зэмлэх гээгүй. Гэвч миний сэтгэл сайхан, нийтийн үйлст үнэнч гэдгээ ажил хэрэг дээр нэг биш удаа батлан үзүүлсэн гэдгийг та ч гэсэн мэдэж ав. Үндэстэнд алба хааж чадах хүн бүрд би итгэдэг юм, миний улс төрийн үзэл энэ дээ. Ард түмний хүсэл зоригоор хууль тогтоох засгийн дарамтыг үүрүүлж осолтой хүндэтгэл ноогдуулсан Марат, Робеспьер мэтийн хүмүүсийг биширдэг, боломжийнхоо хэрээр өчүүхэн дэмжлэгээ үзүүлэн, өөртөө байгаа дорой чадлынхаа чинээгээр шулуун шударга иргэний ёсоор тэдэнд туслахад бэлхэн. Хороонууд, миний энэ тэмүүлэл, миний үнэнч шударгыг гэрчилнэ ээ. Хэд хэдэн жинхэнэ эх орончидтой хамжин би ялгуусан морьт армидаа овъёос бусад бордоо нийлүүлж цэрэг эрсээ гутлаар хангаж байсаан. Өнөөдөрхөн би Верноноос Өмнөд армид жаран толгой үхэр явууллаа. Гэтэл тэр үхрийг дээрэмчдийн бугшсан Питта Конде нарын хөлсний этгээдүүд үүрлэсэн газраар тууж өнгөрөх ёстой шүү дээ. Амаар биш ажлаар би үүнийг харуулж байна гэв.

Гамлен зургаа тайвнаар хавтсандаа хийж бүчийг нь уян сугандаа хавчуулав.

— Ам ажил хоёр чинь зөрдөг нь жигтэйхэн. Нэг талаар даян дэлхийд эрх чөлөөний тугийг мандуулах манай цэрэгт туслах, нөгөө талаар гэртээ энэ эрх чөлөөг хамгаалагчдын сэтгэл санааг үймүүлэн үүнээс урваж байдаг... Баяртай иргэн Блез! гэж шүднийхээ завсраар сийгүүлэн хэлэв.

Ораторийн дагуу нарийн гудамж руу орохоосоо өмнө сэтгэлд нь уур хилэн, хайр дурлал харшин байсан Гамлен хоёрдугаар давхрын цонхон дээрх улаан лиш цэцгийг харах гэж эргэв. Тэрээр эх орноо аврагдана гэдэгт нэгээхэн ч эргэлзсэнгүй. Жан Блезийн эсэргүү үгийг тэрээр өөрийн хувьсгалд итгэх итгэлдээ харшуулан тавьж үзэв. Парисын хүн ард болж буй хэрэг явдлыг урьдын адил сонирхохоо байсан болохоор ямар ч атугай хэвийн худалдаачны үгэнд үнэний хувь яах аргагүй байна гэдгийг хүлээх хэрэгтэй болжээ. Урам сэргээсэн анхны өдрүүдийн халааг булт олны хайхрамжгүй байдал авч наян есөн оны хүсэл эрмэлзэл нь оргилсон буман олны бужигнан байсан үе тэртээд өнгөрч, ерэн онд санаа нэгт сая сая хүмүүс федералчуудын шүтээнийг тойрон нягтарч байсан цаг тэртээд хоцорчээ гэдэг нь ямар ч эргэлзээгүй болсон нь харамсалтай. За яадаг юм! Эрэлхэг эрс зориг эрмэлзлээ бадраан үхэл эрх чөлөө хоёрын нэгийг сонгож авахыг шаардан, үүрэглэгч түмнийг сэрээнэ.

Ийн сэтгэсэн Гамленд Элодийнх нь тухай бодол бүр хүч зориг оруулав.

Мөрний хөвөөн дээр ирсэн Гамлен улайсан цайсан нурмагт галт уул мэт цогцолсон баглагар үүлсийн цаагуур наран далдран, хотын байшин барилгын дээвэр алтан шаргал гэрэлд умбан цонхны шил нүд гялбам гялтганаж байхыг харав. Энэ нь аварга биетүүд хуучин ертөнцийн дүрэлзэн байгаа зомголоор Дикейн зэс цайзыг босгож байна шүү гэж тэр төсөөлөн бодож билээ.

Барагдашгүй идээ тавьсан ширээ, сэргэн мандсан хүн төрөлхтний хамт оролцох даян дэлхийг хамарсан зоогийн тухай тэрээр мөрөөднө. Харин одоо бол сайхан сэтгэлт ээж шиг эх орон нь итгэлт хүүгээ хооллуулна гэж сэтгэлээ тэжээж явав. Хэвийн худалдаачин сэдсэн санааг нь үл ойшоосонд эгдүүцсэн Гамлен хувьсгалт хөзрийг гаргах санаа бол шинэ үр ашигтай санаа, мөн усан будгийн гоё зурагтай суган дахь хавтсанд нь асар их баялаг байгаа гэж сэтгэлээ засна. Деман барлаад өгөх байх. Эх оронч хөзрийг өөрсдөө гаргаад нэг сард л арван мянган хөзөр нэг бүрийг нь хорин сүгээр арилжих биз гэж бодов.

Сэдсэн санаагаа шалавхан биелүүлэх гэж тогтож ядсан Гамлен Скобяны гудамжнаа шилчний мухлагийн дээд давхарт суудаг Демангийнх руу том том алхан явав.

Демангийн дэмжлэгээр дамжиж ордог байлаа. Шилчний эхнэр Деманг эзгүй байгаа гэсэнд найзыгаа тогтож сууж чаддаггүй сэвэлзүүр гэдгийг нь мэдэх болохоор Гамлен огтхон ч гайхсангүй, харин хааяа л нэг барихдаа тийм олноор нь тийм уран барладаг нь хачирхдаг билээ. Гамлен түүнийг жаахан хүлээхээр шийдвэл шилчний эхнэр түүнд сандал тавьж өглөө. Тэр эмэгтэй уруу царайтай байх агаад хувьсгал цонхны шил өчнөөнөөр нь хагалж байсан учир шилчдийг хөлжүүлэх биз гэж бодмоор авч ажил төрөл урагш муутай байна гэж үглэв.

Харуй бүрий боллоо. Нөхрөө хүлээхээ болин Гамлен шилчний авгайтай салах ёс хийв. Шинэ гүүрээр гарч явахдаа Гамлен, нэрийг нь хэн ч үл мэдэх, урьд тайж байсан, шинэ хувьсгалт онц шүүхээр хамгийн түрүүнд яллуулсан нэгэн хүнийг цаазын газар луу алгуурхан авч яваа тэргийг харгалзагч үндэсний гвардийн морьт отрядынхан бамбар барин, зэр зэвсгээ хан ян хийлгэн хурсан олныг замаас түлхэн зайлуулсаар Морфондугийн гудамжаар явж буйг олж үзэв. Гвардичуудын гурвалжин малгайн хоорондуур ялтны бие сүүдийн үзэгдэнэ. Түүнийг тэрэгний бөгс рүү харуулан суулгаж гарыг нь ард нь хүлсэн бөгөөд нүцгэн толгой нь арчаагүй бөнжгөнөх ажээ. Дэргэд нь алуурч тэрэгний хажуугийн хашлагыг гараар тулан зогсож байлаа.

Энэ лав, ард түмнийг өлсгөн зовоож байгаа дамчин байх гэж зорчигсод таамаглан ярилцаж ялтанг тайвнаар харан зогсоно. Гамлен, тийш дөхөж очин, алмайран зогсох олны дундаас гарч зам хөндлөн гарах гэж оролдон байгаа Деманг олж харав. Эварист түүнийг дуудан мөрнөөс татлаа. Деман эргэж харав. Энэ нь царайлаг бяралхаг залуу эр ажээ. Нэгэн үе Академид түүнийг Гераклын биед Вакхын толгой залгачихсан юм шиг гэж ярилцдаг байсан аж. Найз нар нь түүнийг «Барбару» гэж дууддаг байсан нь тэрээр ард түмний төлөөлөгчтэй адилхных билээ.

Гамлен түүнд

— Явъя. Чамтай нэг чухал юм ярилцмаар байна гэхэд Деман

— Намайг зүгээр орхиж үз гэж уурсан хариулав.

Бөөн олны дундуур шахцалдаад гарчих тохиромжтой агшин гарахыг анах зуураа тэрээр үл ойлгогдох хэдэн үг буюунав.

— Би нэг сайхан хүүхний араас явж байсан юм... Сүрэл малгай...  
мөр лүүгээ унжуулсан алтан шаргал үс... Лав оёдолчин байх аа...  
Золигийн тэрэг биднийг салгачхав шүү... Тэр урагшаа гарчхаж амжсан.  
Гүүрний цаад үзүүр бүр хүрчихсэн!

Гамлен маш чухал ажил гэж гүйн цамцнаас нь татан зогсоох гэв.

Гэвч Деман, морьд, гвардичууд сэлэм бамбарын дундуур сүлжин  
гарч оёдолчин хүүхнийг гүйцэхээр гүйн одов.

## IV

Өглөөний арван цаг болж байлаа. Дөрөвдүгээр сарын наран моддын нахиаг гийгүүлнэ. Шөнийн бороонд сэргэсэн агаар дуниартан байх нь тааламжтай. Бэлэвсрэгчдийн модот гудамжаар морьтнууд хааяа нэг давхиж алслагдсан газрын нам гүмийг эвдэх ажээ. «Лиллийн гоо бүсгүй» хаягт овоохойн өмнөх сүүдэрт цэцэрлэгийн үзүүрт Эварист урт модон сандал дээр суугаад Элодийг хүлээж байлаа. Нимгэн даавуун хүзүүний ороолт дээр тэдний гар учран амьсгал нь нийлснээс хойш Гамлен «Амур - зураачид» нэг ч очсонгүй билээ. Бардам зан нь хөдөлсөн хийгээд нэг л хулчийгаад байх болсны улмаас тэрээр долоо хоног Элодигоо харсангүй. Гамлен, иргэн Блезэд дургүй нь хүрсэн шалтгаанаа тоочсон авч дурлалынхаа тухай огт дурсаагүй, уйтгар гунигаа таг нууж тэдний босгыг дахиж алхахгүй гэж шийдсэнээ өгүүлсэн омогтой боловч уйтай ноцтой захиа бүсгүйд явуулсан бөгөөд тэрээр хэлсэн үгэндээ баттай хүрэхээр завдаж байсан нь дурласан бүсгүйд огтхон ч сайны ёр биш байлаа.



Тэс ондоо ааштай бөгөөд өөрийнх гэж тооцож байсан хүнээ алдахыг ердөө ч хүсэхгүй байсан Элоди найзынхаа зүрх сэтгэлийг хэрхэн эргүүлэн авдаг билээ гэж тэр дороо бодолхийлов. Эхлээд Тионвиллын талбай руу гэрт нь шууд яваад очдог юм бил үү гэж санажээ. Гэвч хар хүүгийн дүнсгэр зантай гэдгийг нь анддаггүй, мөн уур ихтэй байгааг нь захианаас гадарласан Элоди, эцэгт нь уурласан уураа өөрт нь гарган улмаар нүүр буруулаад байдаг болчхож болзошгүй хэмээн болгоомжилж, хүний хөлөөс зайдуу очих нь түүний

сэтгэлийг булаан зүрхийг нь эзэмдэхэд туслах тул учрыг ягштал таниулан түүнд тоогдох боломж өгөх, булзааруулж яагаад ч үл чадах нялуун хөнгөмсөг болзоо тавьсан нь дээр гэж шийджээ.

Энэ үед Английн цэцэрлэг бүрд, зугаалгын гоёмсог газар болгонд уран барилгач эрдэмтдийн зургаар хот хөдөөгийнхний амьдралыг сонирхох сонирхлыг хангах гэж урц овоохой босгосон байлаа. Нимбэгийн шүүс худалдаалагчийн түрээсэлж авсан «Лиллийн гоо бүсгүй» гэдэг овоохойн муудсан нэг ханыг хуучны цамхгийн хиймэл балгасанд тулгасан нь эвдэрхий барилгын гунигт байдлыг хөдөөгийн үзэсгэлэнтэй хослуулжээ. Элэг нимгэнтэй залууст, овоохой нурсан цамхаг хоёр хангалтгүй гэж үзээд нимбэгийн шүүсний худалдаачин уд модны дор булш хийн дээр нь «Клеонисаас, үнэнч Азортаа» гэсэн чимэг бичигтэй оршуулгын бумба бүхий багана зоожээ. Урц балгас, бунхан болох нь тэр ээ! Язгууртнууд үхэхийнхээ урьдтай өв уламжилсан цэцэрлэгүүдэд үгүйрэл сөнөл үхлийн энэ бэлгэ тэмдгийг босгож байлаа. Гэтэл одоо хотын эх орончид нь хэн хүнгүй цөмөөрөө байгалийг бишрэгсэд, Жан Жакийн шавь нар хэн хүнгүй цугаараа санаашрал мөрөөдөлд автсан уян зөөлөн сэтгэлтэй улс болохоороо тэр овоохойнуудад хиймэл сүм, хиймэл балгасны сүүдэрт хиймэл бурхны дунд дуртайяа идэж уун, бүжиг наадам хийж хайр дурлалаа нээлцэж байлаа.

Тохиролцсон цагаасаа түрүүлэн болзоондоо ирсэн Гамлен дүүжинт цаг шиг цохих зүрхнийхээ булгилалтаар цаг хугацаа тоолон хүлээнэ. Баривчлагдсан хүнийг хаашаа ч юм авч яваа эргүүл хажуугаар нь өнгөрөв. Арваад минутын дараа өвч ягаан хувцастай, тэр үеийн маягаар гартаа баглаа цэцэг барьсан хүүхэн гурвалжин малгай тавьж улаан франк, судалтай хантааз, судалтай өмд өмссөн залууг дагуулан нэгэн овоохой руу орчихыг харахад тэр хоёр нь урьдын гангачуултай үйлийн үргүй адилхан үзэгдсэн нь ямар ч хувьсгал өөрчилж үл чадах шинж чанар хүнд бий мэтээр Жан Блезийн нотолдгийг өөрийн эрхгүй зөвшөөрөхөд хүргэв.

Хэсэг азнасны дараа Рюэйл юм уу, Сенклу хоёрын нэгнээс ирсэн бололтой байрын содон өнгөөр будсан гонзгой хайрцаг барьсан эмгэн Гамлены сандал дээр суулаа. Тагт нь мэрэг үзэх зүүтэй багаж бэхэлсэн хайрцага тэрээр өмнөө тавив. Тэгээд эмгэн цэцэрлэгт наадаж байсан багачуулаас хувь заяагаа туршин үзнэ үү гэлээ. Тэр сүүлдээ «цэнгэл» нэртэй болсон «балин» боов зардаг байв. Уламжлалт нэр «балин» нь

евхарист, христосчуудын үүргийн тухай залхуу хүрэм санаа төрүүлснээс ч тэр юм уу энэ хуучин нэр нь бүгдийн залхууг хүргээд ч тэр юм уу ямар ч гэсэн «балин» боов тэр үед «цэнгэл» гэгдэж байсан билээ.

Эмгэн хормойгоороо духныхаа хөлсийг арчсанаа бүтээсэн хүмүүс чинь амьдрахад хүнд байна хэмээн бурхныг зэмлэн тэнгэрт гомдол мэдүүлж гарав. Өвгөн нь Сен-Клуд мөрний эрэг дээр мухлагтай бөгөөд сайх хөгшин торчигнуур барьж «Ноёд оо, цэнгэл аваарай цэнгэл» гэж дуудан Елисейн талаар өдөр бүр явдаг билээ. Хэдий тийм авч нас дээр гарсан тэд хөдөлмөрөөрөө хоолоо олж идэж чадахаа больжээ.

Хажуугийн нь хүн өөрийг нь өрөвдөж байгааг эмгэн үзээд лай ланчгийнхаа шалтгааныг тоочин уудалж эхэллээ. Баячуудыг хоосруулж ядуусын амнаас эцсийн үмх талхыг нь булаан авсан бүгд найрамдах улс гол буруутан нь гэнэ. Сайн сайхан юм болно гэж горьдохын гарз. Олон шинж тэмдгээр аваад үзэхэд ажил хэрэг улам л урагшгүй болсоор байна. Нантерт нэг хүүхэн хорт могойн толгойтой хүүхэд төрүүлж Рюэйлд сүмийг аянга ниргэж гонхон дээрх загалмайг хайлуулсан ба Шовилийн ойд хувилгаан тодорсон гэнэ. Баг өмссөн хүмүүс рашаан усыг бузарлаж халдвар тараадаг нунтаг цацаж байна... гэлцэх болов.

Эварист сүйх тэрэгнээс бууж буй Элодийг үзэв. Сийрсэн бүрхний нь бүдэгхэн сүүдэрт залуу бүсгүйн нүд нь гялалзан барьж яваа лиш цэцэг шигээ улаа бутрах уруулд нь инээмсэглэл тодорно. Хар торгон ороолтыг цээжин дээрээ зөрүүлэн ардаа цэцэглэн зангиджээ. Шар бошинз нь өвдөгнийх нь аясаар түргэн хөдөлж өсгийгүй шагайвч өмссөн хөл нь цухалзана.

Гамлен юм ярих гэсэн авч хэлэх үгээ олохгүй ичиж зовохдоо энэ нь Элодид ямар ч эелдэг үгнээс илүү таашаагдаж байна гэдгийг мэдэлгүй биеэ зэмлэнэ. Зангиагаа ердийнхөөсөө нямбай зангидсан нь үүнийг сайн чанар гэж үздэг Элодийн хараанаас мултарсангүй. Тэрээр Гамлен руу гараа сунгалаа.

— Би тантай уулзаж хэдэн үг солих гэсэн юм. Таны захиа над таалагдаагүй таныг бичсэн гэж үнэмшмээргүй байсан болохоор би хариу явуулаагүй юм. Хэрвээ үнэн юм бичсэн байсан бол дээр байх сан биз. Өөрөөсөө нэлээд ахмад хүнтэй улс төрийн талаар жаахан зөрөлдсөний төлөө л Оноре гудамжинд ирэхгүй гэсэнд чинь би үнэхээр итгэсэн бол таны зан чанарыг голох сон билээ. Санаа бүү зов, дахин манайхаар орохдоо эцгийг дургүйцнэ гэж халшрах явдалгүй. Та

түүнийг мэдэхгүй ээ. Одоо тэр өөрөө юу хэлснээ, таны юу гэж хариулсныг аль алиныг нь мартчихсан яваа. Би та хоёрыг бие биедээ туйлгүй сайн гэж би ердөө ч хэлээгүй. Гэхдээ тэр дотуур тамиртай хүн биш. Ний нуугүй хэлэхэд таныг ч... намайг ч... тэр нэг л их анхаарахгүй, зугаа цэнгэл ажил төрөлдөө дарагдсан хүн.

Түүнийг урц тойруулан тарьсан моддын зүг явахад Гамлен биеэ худалдсан эмстэй учирдаг түр зуурын зугааны газар гэдгийг мэдэх болохоор жаахан дургүйхэн дагав. Элоди хамгийн бөглүү буланд жижиг ширээ шилж авлаа.

— Эварист минь би танд хэчнээн их юм яримаар байна вэ? Үерхэл өөрийн эрхтэй байдаг, түүнийг эдлэхийг минь зөвшөөрнө үү? Хэрвээ та дургүйцэхгүй бол таны тухай голчлон... бас өөрийнхөө тухай бага сага ярих гэсэн юм.

Нимбэгийн шүүс худалдаалагч галуун хүзүүт лонх хоёр шилэн аяга авчрахад Элоди ч сайн эзэгтэйн янзаар шилэн аягыг дүүргэснээ балчир насныхаа тухай хуучлан мөнхүү хайртай охин шиг нь эхийнхээ гоо үзэсгэлэнг дуртайяа шагшран магтаж ярьсан нь үүнийг өөрийн хөөрхөн төрсний эх сурвалж гэж үздэгийнх билээ. Тэрээр язгуур удам судраараа бахархдаг тул өтгөс дээдсээ ямаршуухан лут хүмүүс байсан тухай их л хүндэтгэн хөөрнө! Арван зургаан настайдаа элбэрэлт ганц эхээ алдсанаас хойш хайр энхрийлэл тусламж дэмжлэг үзээгүй гэж бас ярилаа. Сэргэлэн цовоо өр нимгэн зүрхтэй хүүхэн гэж өөрийгөө яг л байгаагаар нь зураад

— Эварист таных шиг зүрх сэтгэлийг үнэлэхгүй байж чадахааргүй даан ч гунигтай ганцаардангуйгаар залуу насаа өнгөрөөжээ. Танд хэлэхэд өөрийнхөө дураар өчүүхэн ч түдгэлзэлгүй наддаа бол үнэтэй цайтай найдаж болох юм шиг санагдсан таны зүг тэмүүлдэг сэтгэлээ татаж аваагүй юм даа гэв.

Эварист түүнийг энхрийлэн хараад

— Элоди би ямар ч байсан хамаагүй юм гэж үү. Үүнд итгэж би болох уу... гэснээ илүү үг дуугаран ийм итгэл төгс эхэлсэн үерхлийг хэтрүүлчихээс эмээн чимээгүй болов.

Цаадах нь тор хадсан урт бариу ханцуйнаас цухуйх бяцхан гараа эрээ цээргүй түүнд өглөө. Гүнзгий сүүрс алдахад нь мээм нь урагш түхэлзэв.

— Эварист надаар яаж хайрлуулъя гэж байна, түүнийгээ хэлээч, та миний хайртай гэдэгт итгэхэд буруудахгүй шүү гэвэл

— Элоди... Элоди та намайг өөртөө... гээд Гамлен түгдрэв.

Элоди уруугаа харав.

— ... дурлаж байна гэдгийг мэдвэл үүнийг ахин хэлж чадах уу?  
гэж Гамлен шивнэв.

Сүүлийн үгсийг сонсоод бүсгүй сэтгэл ханасандаа улайв. Түүний нүдэнд янаглал тодрохыг Гамлен үзэж болох байлаа.

«Мань эр өөрөө түрүүлж хайраа илчиллээ гэж бодлоо!.. Намайг уурлуулчихлаа гэж айж ч байж магад» хэмээн санахдаа Элоди өөрийн эрхгүй дооглонгуйхан жуумалзав.

— Тэгэхлээр, найз минь чамд сэтгэлтэй болсныг минь мэдээгүй юм уу? гэж ялдамхан өгүүлэв.

Хорвоо дээр хоёулхнаа байх шиг тэдэнд санагдана. Энгүй их хөхин баяссан Эварист наран гийсэн цэнхэр номин тэнгэрийн мандлыг ширтэн

— Хараач, огторгуй биднийг харж байна. Амраг минь яг л тантай адил энэ тэнгэр бахдам ивээлтэй юм. Энэ тэнгэр тан шиг гоо үзэсгэлэнтэйгээрээ намайг гялбуулж, тан шиг энхрий мишээнэм... гэж дуун алдлаа.

Шим ертөнцөд өөрөө уусчихсан ч юм шиг, баяр хөөр хөгжил баяслыг орчин байгаль нь хуваалцаж байгаа ч юм шиг залуу эрд санагдана. Түүний хань бүлтэй болсныг ёслон тэмдэглэж туулайн бөөрний цэцэгс алтан гэрэвч адил бадран улиангарын мөчир том бамбар шиг дүрэлзэн асах мэт үзэгдэнэ.

Эварист сүр жавхлан, хүч чадалтайдаа эрдэн баясна. Булбарай турхан эелдэг налархай Элоди одоо дорой төрсөн эм хүн гэдэгтээ захирагдах ёстой гэж тооцон, Эваристын сэтгэлийг эзэмдэж аваад түүний эрхшээлд оров. Гамленыг эзэмшиж аваад Элоди түүнийг эзэн баатар бурхан мэт үзэн түүнийг бахархан даган биеэ өгөх сөн гэсэн хүсэл нь оргилно. Моддын сүүдэрт залуу эр бүсгүйн уруулыг халуунаар удтал шимж озоход толгойгоо гэдийлгэн Эваристэд тэврүүлсэн Элодид бие нь хайлсан тугалга шиг уян болох мэт санагдлаа.

Орчлон хорвоогийн хамгийг умартан тэр хоёр өөрсдийнхөө тухай удтал хүүрнэв. Эварист, залуу бүсгүйг баясгасан тодорхойгүй нандин бодлынхоо тухай зонхилон ярив. Элоди аятайхан, зөвхөн өөрсдөдөө хамаатай аж амьдралын талаар өгүүлэв. Дараа нь бүсгүй энд цааш удаж болохгүй гэж шийдээд эрсхэн босож цонхон дээрээ тавьсан гал

улаан лиш цэцэг гурвыг янаг залуудаа өгөн сууж ирсэн сүйх рүүгээ шурдхийн орчхов. Энэ бол өндрөөс өндөр дугуйтай шар будагтай хөлсний тэрэг байсан агаад түүнд ч, дэлбэгчид нь ч гойд юмгүй боловч Гамлен болон түүний мэтийнхэн хөлсний тэргээр хэзээ ч явж байгаагүй билээ. Лужир том дугуй нь хурднаа эргэлдсээр одох сүйх тэргэнд суусан Элодийгоо хараад муу совин нь татан зүрх нь шимшрэв. Морин тэрэг Элодийг нь жинхэнэ амьдралаас гадагш, бодит орчноос холдуулан түүний хэзээ ч хөл үл тавих ямар нэгэн гоёмсог наргиант хот, үлгэрийн үзэсгэлэнт шилтгээн рүү, зугаа цэнгэл тийш аваад явчихлаа шүү гэж ухаан нь элий балай болох мэт сэтгэлд нь зовуурьтай боловч тодхон буув.

Сүйх тэрэг далд орлоо. Эваристын сэтгэл үймрэх нь намдсан боловч энд амссан ухаангүй дурлал, янаглал амраглалын үеийг ахин хэзээ ч эдлэхгүй шүү гэж мэдэхдээ битүүхэн гонсойжээ.

Хүүхдүүдээ моддын дор тоглож байх зуур модон сандал дээр оёх нь оён, нэхэх нь нэхэн сууцгаах цайвар бошинз өмссөн хүүхнүүдээр дүүрсэн Елисейн талаар Гамлен гэр лүүгээ явав. Бөмбөр маягийн хайрцагтай «цэнгэл» жигнэмэг наймаалж буй эмэгтэйг хараад Бэлэвсрэгчдийн модот гудамжнаа дайралдсан «цэнгэл» худалдаалагч эмгэнийг санан энэ хоёр учралын хооронд амьдралынх нь бүхэл бүтэн нэг үе өнгөрсөн мэт бодогдов. Тэрээр хувьсгалын талбайгаар гарав. Хувьсгалын дайснуудын үүрд дуугаа хураасан гэж санадаг үй олны хоолой нийлүүлэн хашхиралдах, хувьсгалын аугаа их өдрүүдийн хүчит цуурайг Гамлен алсаас, Тюильрийн цэцэрлэгт явахдаа дууллаа. Улам чангарч буй шуугиан тийш шаламгайлан алхалсаар Гамлен «Бүгд Найрамдах Улс мандтугай! Эрх чөлөө мандтугай!» гэж бархиралдан буй эрэгтэй эмэгтэй улс багшран цугласан Оноре гудамжнаа хүрч ирэв.

Цэцэрлэгийн хана, байшингийн цонх, тавцан, дээвэр дээгүүр малгай нусны алчуураар даллах хүмүүс бүчжээ. Жагсаалд зам тавиулагч хүнээр тэргүүлүүлэн захиргааны түшмэд, үндэсний гвардичууд, их буучид, цагдаа, торгон цэргээр хүрээлүүлсэн, царс модны навчин титмээр тэргүүнээ чимж үенгийн арьсан захтай хуучин ногоон цув нөмөрсөн шав шар царайтай хүн хүмүүсийн толгой дээгүүр аажимхан урагшлах нь үзэгдэв. Хүүхнүүд түүн тийш цэцэг чулуудна. Энэ урам зориг нь бадарсан олны дундаас илрүүлэх ёстой ард түмний дайснуудыг, гэсгээх ёстой урвагчдыг эрэн бэдрэх мэт тэрээр нэвт шувт

ширтсэн шар нүдээрээ эргэн тойрныг харна. Гамлен түүнтэй зэрэгцэн очиж малгайгаа авч үй түмэн улстай хоолой нийлүүлэн

— Марат мандтугай! гэж хашхирлаа.

Ялсан баатар, Рок лугаа адил Конвентын танхимд оров. Цугларсан улс алгуур тарж байх завсар Гамлен жижигхэн ширмэн шон дээр сууж хүчтэйеэ цохих зүрхээ дарна. Дөнгөж сая биеэр үзсэн энэ хэрэг явдал түүний сэтгэлийг машид догдлуулан тоймгүй их баяр бахдалаар бялхуулав.

Судас үрэвсэх өвчнөөр шаналж, хорт яр шархандаа чилээрхсэн боловч үлдсэн хүч чадлаа бүгд найрамдах улсдаа зориулан, хэний ч ороход чөлөөтэй, ядуу гэртээ түүнийг халуун дотно хүлээн авч нийтийн сайн сайхны тухай их сонирхолтой ярин, хорлогчдын явуулгын тухай үе үе лавлан байдаг Маратыг Гамлен хүндлэн хайрладаг билээ. Ардын нөхрийг<sup>25</sup> зөвтгөн, Конвентэд хамгийн зүтгэлтэй хамгийн голч нэгэн хууль тогтоогчийг өгсөн хувьсгалт онц шүүхийг хөхиүлэгч Маратыг алах гэдэг дайснууд нь түүнд ялалтын баяр хийхээр бэлтгэснийг үзээд Гамлен тун хачирхав. Ялгуусан хүн хөлгийнхөө дээрээс «Бултаараа, над шиг л үхэн үхтлээ эх оронч байгтун» гэж иргэддээ уриалах мэт санагдам үхэж буй лужир эрийн шаналгаатай харц, зориг баатарлагийн бэлгэ тэмдэг гэрэлтсэн магнай, нандин бахархал, өршөөлгүй хайр тодорсон, өвчиндөө энэлж, хатангир болсон эрэмгий царай, ярвайсхийсэн уруул, ханхар цээж, хөвчин бие нүдэнд нь үзэгдсээр байлаа.

Гудамжнаа хөл хөдөлгөөн хэдийнээ тасраад шөнийн харанхуй нөмрөн авч, дэн асаагч дэнлүү барин хажуугаар нь өнгөрөх үед Гамлен — Үхэн үхтлээ!.. гэж сэтгэлдээ давтан өгүүлсээр байлаа.

## V

Өглөөний есөн цагт Люксембургийн цэцэрлэгт өөрийг нь хүлээн суугаа Элодитой Эварист уулзав.

Тэр хоёрын хайр сэтгэлээ нээлцсэнээс хойш нэг сар өнгөрч одоо тэд «Амур - зураачид» ч юм уу Тионвиллийн талбай дахь Гамленыд ч юм уу өдөр болгон учирдаг болжээ. Эл учралууд нь их л наалинхай болдог байсан авч Гамлены төлөв журамт зан ямар ч гэсэн илэрхий нөлөөлдөг байлаа. Сүжигтэй, ариун иргэн тэрээр, хуулийн өмнө юм уу эсвэл гагц бурхны өмнө юм уу, ер нь байдлыг харгалзан дурлалт бүсгүйтэйгээ хувь заяагаа холбоход бэлхэн, гэхдээ үүнийг хүнээс нууж хаалгүй ил хийнэ гэнэ. Ийм эрхэм нандин шийдвэрийг зүйн хэрэг гэж үзэх авч олон шалтгаанаар гэрлэн суух боломжгүйдээ цөхрөхийн зэрэгцээ нийтийн хэв ёсноос зөрөхөөс түдгэлзэн Элоди, бусдын нүдэнд өртөлгүй ойр зуурын хүмүүсийн хүндэтгэлийг аажимдаа олж болно гэж үзээд сэм учрахыг сэтгэлийнхээ гүнд эрхэмлэж байлаа. Хэтэрхий тахимдуу амрагийнхаа ёсорхохыг нэгэн сайхан өдөр болиулж чадна гэж тэрээр найдаж байсан агаад хэлэлгүй хойшлуулж үл болох нэгэн зүйлийг ярихаар картезианчуудын сүмийн харалдаах хүнгүй цэцэрлэгт уулзахаар болзжээ.



Үнэхээр ялдамхнаар Эваристыг харснаа Элоди гараас нь барин хажуудаа суулгаж үг бүрээ няхуур бодож ийн өгүүлрүүн:

— Эварист, би таныг, юмаа нууж хааж чадахааргүй их хүндэтгэдэг. Би өөрийгөө танд тэнцэнэ гэж боддог, хэрвээ танд бүгдийг хэлэхгүй бол тийм байж чадахгүй сэн. Миний хэлэхийг чагна, миний шүүгч бол. Өөдгүй, муу, олиггүй үйл хийлээ гэж би биеэ буруушааж чадахгүй ээ. Би тэгэхэд хэт дорой, гэнэн байж... Найз минь, миний хэчнээн хүнд байдалд байсныг алдалгүй сонс. Намайг эхээсээ эрт хагацсан, эцэг

залуу хүн учраас зөвхөн наргиан зугаа цэнгэл хөөцөлдөөд надад тун шалихгүй анхаарал тавьж байсныг та мэднэ. Би их л өр нимгэнтэй бүсгүй болж өслөө. Байгалиас надад янаг дур ихтэй зүрх заяаж оюун ухаанаар бас гомдоогүй боловч тэр үед сэтгэл минь ухаан бодлоосоо давамгайлсан юм. Эварист минь, сэтгэл ухаан бодол хоёулаа үүрд хагацашгүйгээр таных бол гэж зөвлөөгүй сэн бол тэр сэтгэл одоо ч гэсэн юунаас ч хүчтэй байх сан биз ээ.

Тэрээр хэлэх үг бүрээ урьдаас сайтар тунгаасан учир хянуур мөртөө түргэн ярина. Ийнхүү үнэнээ тоочихоор эртнээс шийдсэн нь нэгд цайлган зантайнх. хоёрт Жан-Жакийг дуурайх нь аятайхан санагддагийнх, тэгээд эцэст нь «Ганцхан надад хамаарч байгаа биш энэ нууц эрт орой алин боловч Эваристэд мэдэгдэх болохоор өөрөө үнэнээ хэлчих нь түүний өмнө нэр хүндийг минь дээшлүүлж гаднын улсын хов жив хүргэх шившгээс ангижруулна» гэж биеэ оновчтой ятгасных билээ. Дурламтгай, байгалийн жамыг дагагч Элоди өөрийгөө тийм ч их буруутай гэж бодсонгүй учир энэ нь түүний сэтгэлийг төдий л зовоосонгүй, түүнээс гадна тэрээр Эваристэд зөвхөн голыг нь ярихаар завдаж байв.

— Ээ, хайрт Эварист минь, хаягдан ганцаардсан тэр үед чамтай яагаад учирсангүй вэ? гээд бүсгүй санаа алдав.

Шүүгчээ болж өгөөч гэсэн Элодийн гуйлтыг Эварист яг таг ойлголоо. Заяаны юмыг тусгамтгай, шударга ёсыг сохроор мөрдөгч болж хүмүүжсэн Гамлен Элодийн хамгаа тоочихыг нь дуустал сонсохоор шийдэв.

Бүсгүйн тээнэгэлзэн буйг хараад Гамлен цааш ярь гэж дохив.

Харин бүсгүй тун энгийн ийн өгүүлрүүн:

— Сайн, муу чанарыг хослуулан, зөвхөн сайныгаа л өнгөн дээрээ гаргадаг нэг залуу, намайг зүгээргүй хөөрхөнд тоолон, тийм хүнд бол хачин юм даа гэж санагдам шаргуу хөөцөлдөж эхэлсэн юм. Тэр бол цэл залуу, дэгжин хүн, өөрийг нь илэн далангүй биширдэг хэд хэдэн гол шиг цэвэр нууц амрагтай байсан. Тэр царай зүсээрээ ч, түүгээр ч үл барам ухаанаараа ч намайг татаагүй ээ... Түүний хайр дурлал ч сэтгэлийг минь хөндсөн, ер нь үнэхээр надад дурласан болов уу гэж боддог. Тэр ялдамхан, болгоомжтой байсан. Би түүнээс зүрх сэтгэлээс нь өөр юм хүсээгүй, гэтэл зүрх сэтгэл нь тогтвор муутай байлаа... Би зөвхөн өөрийгөө л зэмлэж байгаа юм, энэ бол түүнийх биш миний л үйлдсэн нүгэл. Тэр надад хамаагүй болсон болохоор түүнээс гомдол

эрж байгаа юм биш ээ. Эварист минь, одоо тийм хүн огт байгаагүй юм шиг болжээ, танд андгайлъя!

Бүсгүй дуугүй болов. Гамлен элгээ тэврэн гунигт харцаар Элодийг мэлрэн хариу юу ч дуугарсангүй. Тэр, Элодийг, мөн дүү хүүхэн Жюлигээ бодно. Жюли мөн л нууц амрагийнхаа ятгалгад автсан юм. Золгүй Элодийгоос ялгаатай нь тэрээр туршлагагүйдэж зүрх сэтгэлдээ захирагдсан биш харин өөрсдийнхнөөсөө хол зугаа цэнгэлтэй элбэг дэлбэг байх гэсэндээ түүнийг дагаж явсан билээ. Гамлен, ширүүн зангаараа дүүгээ буруушааж байсан бөгөөд дурлалт бүсгүйгээ ч буруушааж чадах байлаа.

Элоди, дөлгөөн дуугаар

— Гүн ухааны ном их уншсан болохоор бүх хүн төрөлхийн үнэнч шударга байдаг байх гэж итгэдэг байлаа. Аз харихад, байгаль, ёс суртахууны сургуулиар хүмүүжээгүй, нийгмийн мухар заншил, ихэрхэг, биеэ тоосон зан, нэр төрийн тухай хуурамч ойлголт нь итгэлгүй, хар амиа хичээгч болгон хувиргасан хүний элэг рүү хувь заяа минь намайг түлхсэн юм.

Эл урьдаас тооцоолсон үг нь бүсгүйн хүсэж байсан сэтгэгдлийг төрүүлэв. Гамлены харц зөөлөрлөө.

— Толгойг чинь эргүүлсэн хүнийг хэн гэдэг юм бэ? Би таних болов уу? гэж залуу асуув.

— Та түүнийг танихгүй ээ.

— Нэрийг нь хэл л дээ?

Ийнхүү асуухыг нь мэдэж байсан Элоди үүнд нь хариу эс хэлэхээр шийдэн

— Үүнийг хэлүүлээд яах юм бэ, би гуйя. Таны төлөө, өөрийнхөө төлөө, үүнтэй үүнгүй дэндүү их юм танд ярилаа шүү дээ гэж ятгав.

Залууг шалгаагаад байхлаар нь Элоди

— Өөрсдийн ариунаас ариун дурлалынхаа төлөө энэ... хар элэгтэй хүний дүр төрхийг төсөөлж болохоор юмыг танд би огт хэлэхгүй ээ. Танд хардах сэрдэх шижим өгөхийг хүсэхгүй байна. Та бид хоёрын хооронд улиг болсон хий үзэгдэл бий болоосой гэж хүсэхгүй байна. Одоо би тэр хүнийг мартчихсан байхад түүнийг мэдэх хэрэг юу вэ? гэв.

Элодигоо, итгэмтгийнхээ харгайгаар хохирч хууртан уруу татагдсан гэдэгт эргэлзэхгүй байсан тул Эварист толгой эргүүлэгч гэдэг үгийг зориуд хэлэн нэрийг нь хэл гэж шаардсаар л байлаа; Хэрэг

явдал үүнээс тэс ондоо, Элоди нь хүсэлдээ, хазаарлан тогтоож үл чадах хүсэлдээ дийлдэн, мах цусныхаа далд нэгэн хүсэлдээ автсан гэж залуугийн санаанд ч орсонгүй, энэ янаг булбарай цогцос. дурлалын боол болсон энэ хайр булаам бүсгүй биеэ өөрөө өгсөн гэж залуугийн санаанд орсонгүй, харин заль хэрэглэн, хүч түрэн түүнийг нь эдэлсэн, ингэ гэж түүнийг нь баалсан, тэр нь алхам бүрд нь тавьсан занганд орсон гэж залуу эр үзэж үүндээ итгэж байлаа. Гамлен, өнгөн дээрээ төлөв боловч товч, оносон, бүсгүйг бачимдуулсан асуулт тавина. Энэ сүлбээ яаж үүссэн, хэр удаан үргэлжилсэн, халуун дотно буюу хөндийвтөр хоёрын аль нь байсан, хэрхэн төгссөн тухай байцаана. Тэр хүн хэрхэн ямар аргаар толгойг нь эргүүлсэн тухай зогсолтгүй лавласан нь, энэ арга нь ямар нэг дуулдаагүй ер бусын юм байх ёстой мэт санасных бололтой. Энэ асуусан зүйлс нь талаар боллоо. Цаадах нь өршөөхийг чимээгүйхэн гуйж нулимс дүүрэн нүдээр номой ширтэж хар цагаан дуу гарсангүй.

Тэр хүн нь одоо хаана байгааг Гамлены мэдэх гэхэд бүсгүй  
— Вант улсаас... гэснээ, — Францаас явсан гэж засаж хэлбээс  
— Гадаадад зугтсан байх нь ээ! гэж залуу дуун алдав.

Яг л якобинч хуний маягаар ийнхүү амархан хардахаа больж, ямар ч үндэслэх юмгүй мөртөө улс төрийн үзэл бодолдоо тохируулан дутуу дулимаг сэтгэсэнд гунихын зэрэгцээ, сэтгэл амсхийсэн Элоди түүнийг дуугүйхэн харав.

Үнэндээ бол Элодийн нууц амраг нь прокурорын бичээч, конторын жижиг ажилчин. Херувима<sup>26</sup> лугаа адил толгойтой хачин сайхан залуу билээ. Бүсгүй түүнд ухаангүй дурласан агаад гурван жил улиран өнгөрсний хойно одоо ч гэсэн түүний тухай бодоход дотор нь халуу шатдаг байлаа. Нөгөөх нь харимал, баян хүүхэнтэй ойр дотно болохыг санаархан тачаангуйн ухаанд төгс боловсорсон зүтгэлээр нь харамгүй шагнадаг хатагтайгаас болж Элодийг хаясан юм санж. Хуучин алба ажлыг устгасны дараа Парисын хотын захиргаанд ажилд орсон тэрээр санкюлот цэрэг болсон ба одоо тайж явсан авгайнхаа тэтгэмжид байгаа ажээ.

— Язгууртан! Гадаадад зугтагч гэнэ ээ! хэмээн Гамлены давтан байхад, бүх үнэний нь мэдээсэй гэж Элоди ер хүсэхгүй байсан тул тийм биш гэж хэлсэнгүй.

— Тэгээд тэр чамайг шившигтэйгээр хаяжээ?

Элодийг толгойгоо гудайлгахад залуу эр түүнийг элгэндээ тэврэв.

— Садар самуун явдалтны зууш болсон хайрт минь! Тэр шившигт завхай амьтнаас өшөөг чинь авна! Гагцхүү тэнгэр бурхан л түүнтэй дайралдуулж таалаасай! Би түүнийг танина!

Гамленыг хайр дурлалын талаар ухаалаг, жирийн, ширүүвтэр байгаасай гэж Элоди хүсэх учир гутран урам нь хугарсан боловч инээмсэглэн жишүү харж билээ. Төдийлөн хурдан дүрслэн сэтгэж чаддаггүйн улмаас бүсгүйн нүглээ тоочсон нь сэтгэлийн хөдөлгөөн ихтэй хүмүүсийн үйл тамыг цайлгадаг тэр сэтгэгдлийг түүнд төрүүлсэнгүй, бас бүсгүйн толгой эргэснийг суртахууны, нийгмийн утга учир бүхий баримт хэмээн үзсэн дээрээс Гамлен тэгж амархан хэлтрүүлээ гэдгийг Элоди ухаарч байлаа.

Тэд босон цэцэрлэгийн ногоон дундуур явав. Залуу эр, амссан зовлонгийн нь төлөө түүнийг улам их хүндэлж байна гэлээ. Элоди үүнийг шаардаагүй ээ. Элоди, энэ л байгаа чигт нь түүнд хайртай, ямар ч маргаангүй гэж тооцдог авьяас билгээр нь бахархдаг билээ.

Люксембургийн цэцэрлэгээс гарангуутаа Тэгш эрхийн гудамжнаа үндэсний театрын харалдаа хүмүүс бөөгнөрснийг харсан бөгөөд эх оронч сэтгэлгээтэй секцүүдэд, дам сонсвол, Парисыг хөнөөн бүх бүгд найрамдахчуудыг толгой дараалан хядах бодлоготой байсан орлеанчууд болон Бриссогийн<sup>27</sup> хамсаатнуудын хуйвалдааныг илрүүлэн хэд хоног хөл хөдөлгөөн ихтэй байсан учир энэ нь тэдэнд гэнэтийн үзэгдэл биш байлаа. Коммуны, Конвентоос хорин нэгэн гишүүнийг хөөхийг шаардсан хүсэлтийн бичигт Гамлен саяхан гарын үсгээ зурсан билээ.

Театрыг зэргэлдээх байшинтай нь холбосон гулдан хаалгаар орохын урдтай, сэртэн дээр зогссон ирвэсийн арьсан гадартай дуулгатай цэргийн хүний хэлэх үгийг чагнаж байгаа урт хормойт хүрэм өмссөн бөөн иргэдийн дундуур гарах хэрэг гарлаа. Праксителийн «Амур» лугаа үзэмжээрээ эгнэх энэ залуу эр Ардын нөхрийг назгай байна гэж муулж байв.

— Марат, чи унтаж байна. Федералчууд энэ завсар биднийг дөнгөлөх гинж давтаж байна гэж тэрээр өндөр дуугаар өгүүлнэ.

Түүнийг ажмагцаа бүсгүй Гамленд

— Эварист, эндээс зайлъя гэж тэвдэнгүй хэлэв. Шахцалдаан, чихцэлдээн дунд муурч унах магад тул шавааралдсан олны дотор орохоос айлаа гэж тэр өгүүлэв.

Тэд бие биедээ эгнэгт хайртай байхын андгай өргөцгөөн Үндэсний талбай дээрээс салцгаалаа.

Тэр өдөр өглөө эрт иргэн Бротто, Гамлен авгайд сайхан гэгчийн бордмол тахиа авчирч өгөв.

Ефстафий гэгээний сүмийн нэгэн сэртэн дээр зогсон хааяа захиа бичиж өгдөг байсан захын наймаач эхнэрээс үүнийг авсан бөгөөд гэтэл зээлийн тэр наймаачин хүүхнүүд нь роялч үзэлтэй, гадаадад зугтсан харчуултай сүлбээтэй гэдэг нь бүгдэд илэрхий учир Бротто хэрхэн олсноо яривал түүний зүгээс тун болгоомжгүй юм болох байлаа. Гамлен авгай бордмол тахиаг их дуртай авав. Идэш уушийг өдөр ирэх тутам гамнах болсон тул ийм шувууны барааг ойрд хэн ч хараагүй билээ. Ард олон өлсгөлөнгөөс айж, язгууртнууд, сураг сонсвол, өлсгөлөнг хүсэж, дамчид өлсгөлөн гаргахыг бүхий л аргаар оролдож байв.

Тахианы мах зоогло гэж залагдсан иргэн Бротто үдээр ирээд гал тогооноос гарах сайхан үнэрийг гайхан шагширч үүнийгээ эзэгтэйд хэлэв. Үнэндээ ч зураачийн өрөөнөө тостой шөлний сайхан үнэр хамар цоргиж байлаа.

— Ноёнтон, та хачин эелдэг хүн юм. Таны тахиаг амталж идэхийн тулд гахайн өөхний жаахан хальс, үхрийн том яс хийж ногоотой шөл чанасан билээ. Тархины яснаас өөр юм шөлийг тийм сайхан үнэртэй болгодоггүй юм гэж эмгэн хариулбал Бротто

— Авгай, энэ чинь маш сайшаагууштай санал байна. Та хачин ухаалаг хандаж, хэрвээ маргааш, нөгөөдөр, ер нь тэгээд долоо хоног дуустал энэ сайхан ясыг тогоондоо байлгавал шөлийг сайхан үнэртэй болгоно гэдэг жигтэйхэн. Панзустын Сивилла гэдэг хүүхэн яг л ингэж хуршсан гахайн өөхний хальс, урьд чаначихсан саворадо хоёрыг шинэ байцайны шөлөнд хийдэг байлаа. Тэдний нутагт, ялдамд хэлэхэд тэр ч миний нутаг байгаа юм, маш амтлаг, нүнжигтэй тархины ясыг тэгж нэрлэдэг юм гэлээ.

— Ноёнтон минь, таны энэ ярьж байгаа хатагтай нэг ясыг тэгж удаан чанадаг болохоор хэтэрхий нарийн хүн юм даа. Та тэгж бодохгүй байна уу? хэмээн асууваас Бротто

— Амьжирлагаар дорой байсан юм. Мэрэгч хүн боловч их л их гачигдаж байсан даа гэж өчив.

Энэ үед Эварист Гамлен орж ирлээ. Дөнгөж сая дуулсан зүйлдээ сэтгэл нь машид догдолсон тэрээр Элодийн толгойг эргүүлсэн хүн хэн болохыг мэдэж бүгд найрамдах улс, дурлалт хүүхэн хоёрынхоо өшөөг авна гэж ам алдаж байлаа.

Эваристтай ердийн л нэг мэнд зөрснөө иргэн Бротто цааш үргэлжлүүлэн

— Хувь заяаны төлөг үздэг хүмүүс хөрөнгөжих нь тун ховор. Тэдний гууль нь цухуйхдаа хачин амархан. Мэхэлж залиллаа гээд тэднийг хүмүүс үзэж чадахаа байдаг юм. Гэтэл хэрвээ хожмын юмыг нээрээ урьдаас мэддэг бол тэднүүсийг бүр их үзэн ядах нь зүйтэй сэн. Хэрвээ хүн өөртөө юу тохиолдохыг өмнөөс мэддэг бол амьдрал тэсвэрлэхийн аргагүй болох шүү дээ. Хэтэд учрах золгүй явдал нүдэнд нь үзэгдэж үүнээсээ урьд зовон, эцэстээ юу болохыг мэдчихсэн болохоор хүн хувь заяанаас нь ноогдуулсан түр зуурын жаргалыг эдэлж чадахгүй сэн. Үүнийг харахгүй байна гэдэг хүний жаргалын чухал сурвалж бөгөөд хүмүүс ихэнхдээ түүгээр сэтгэл ханадаг юм. Бид өөрсдийнхөө, ойр дотнын хүмүүсийнхээ тухай юу ч мэдэхгүй шахам байна бус уу. Нүдэн балай байгаа маань биднийг тайвшруулж, сэтгэлээ хуурч байгаа маань аз жаргалтай болгож байна гэж ярив.

Гамлен авгай, ширээн дээр тавагтай шөл тавин «Benedicite» уншлага уншсанаа хүү зочин хоёроо суулгаад, Броттогийн хамт сууя гэхэд нь татгалзаж, найр тавих нь түүний үүрэг гэдэг нь мэдээж хэмээн учирласаар өөрөө босоогоороо идэж эхлэв.

## VI

Өглөөний арван цагт билээ. Өчүүхэн ч салхигүй байв. Зургаан сард ийм халуун байхыг хэн ч үл санана. Иерусалимын нарийн гудамжнаа тус секцийн зуугаад гишүүн талхны мухлагийн хаалган тушаа «сүүлд» зогсож дөрвөн үндэстний гвардич, буугаа тавин тамхи нэрэнхэн дэглэм журмыг сахиулж байлаа.



Конвентыг хөдөлгөөнгүй үнэ тогтоохтой хамт л тариа гурилгүй болов. Элсэн цөлийн израилчууд шиг өлсөхийг үл хүсэх парисынхан үүр цүүрээр босоцгооно. Эр эм хүүхэд шуухад бултаараа шахцалдан, хажуугийнхаа улсыг түлхэн, нэр усаа дуудан, хүн ойрынхоо хүнд ямархуу сэтгэлээр хандаж болох вэ яг л тийм үзэн ядсан, жигшсэн, сонирхсон, тачаадсан, хайхрамжгүй зэрэг бүхий л сэтгэлийг илэрхийлсэн харцаар бие биеэ ширтэх агаад улайсам наран суваг шуудуунд ялзарч буй хог новшийг шаран, хир хөлсний үнэрийг хурцатгана. Талх цөмд нь хүрэхгүй гэдэг нь урьдын гашуун туршлагаас тодорхой тул хожимдогсод урагш чихэн зүтгэж, шахагдан гарагсад нь зарга мэдүүлэн иргэний эрхийг хөсөрдүүлж байна гэж дэмий л шалтаг заан цухалдацгаана. Эмэгтэйчүүд байраа алдахгүйг хичээх буюу урагшаа дөхөх гэхдээ тохой өвдгөөрөө учир зүггүй ёврох ажээ. Түлхэлдээн ширүүсвэл «Битгий түрээд бай!» гэж бархиралдах бөгөөд хүн бүр намайг түлхээд байна гэж батлан эсэргүүцнэ.

Өдөр бүрийн энэ эмх замбараагүй байдлаас гарахын тул секцийн бүрэн эрхт комиссарууд мухлагийн хаалганаас дугаарын сүүл хүртэл хүмүүс барьж байх олс татахыг тушаав. Гэвч зэрэгцээ зогсогчдын гар үе үе тулгаран булаацалдах нь олонтоо. Олсоо алдсан хүн ахин түүнээс барьж авна гэж санахын ч хэрэггүй. Дургүйцэгсэд ч юм уу, эсвэл төрхгүйчүүл ч олсыг нь тас огтлох болсон учир эл арга хэмжээг зогсоохоос өөр замгүй болов.

Дугаарлагчид аахилж уухилалдан, заримынх нь ухаан балартаж, бие биеэ егөөдөн, бүдүүлгээр хараан, язгууртан федерал болон ийм

зовлон таригчдыг хараан зүхэцгээнэ. Алиа наргианч нар хажуугаараа нохой гүйж өнгөрөхөд Питт гэж дуудна. Ямар нэгэн танхай этгээдэд доромжлуулсан эмэгтэй цаадхынхаа хацрыг тас хийтэл алгадах нь байн байн сонстох хийгээд хажуугийнхандаа шахуулсан залуухан шивэгчин доош харан амаа ангайсхийн амьсгаадна. Хөгжилтэй францчуудыг үг бүрээрээ, дохио болгоноороо, хөдөлгөөн бүхнээрээ хөгжөөж чадах хэсэг дүрсгүй залуус, хойчийн шударга ёс, нийтийн аз жаргалд итгэх бүгд найрамдахчуудын итгэлийг гаргасан дахилтыг далд гуйвуулан гутаалаа гэж унтууцсан өвгөн яkobинчийн дургүйцэхийг ч анхаарахгүй «Gaiga» гэж уянгалуулах ажээ.

Зарлал наагч шат сугавчлан ирж мухлагийн өөдөөс харсан хананд махны хувь ноогдуулсан тухай Коммуны зарлал наав. Зорчигчид зогсон, эвэрч амжаагүй шахуу байгаа цаасыг уншицгаана. Сагс үүрсэн байцаа наймаалагч хүүхэн сөөнгөдүү чичрэнгэ дуугаар

— За ингээд махаар тасардаг байжээ. Өвс идэж ус уух болж дээ гэж бувтнав.

Гэнэт усны сувгаас айхавтар их өмхий ханхалсанд олон хүний бөөлжис хутгаж, нэг эмэгтэйн дотор нь муухай болж балартан унаваас түүнийг хоёр үндэсний гвардичуудад өгвөл тэд хажуу тийш нь цоргоны дор чирч аваачлаа. Хүмүүс ам хамраа таглан, айсан түгшсэн үг хагас дутуу сольцгоон гүнгэнэлдэв. Бээсэн сэг булж орхио юу, хорон санаатнууд тэнд хор хийчхээгүй байгаа гэлцэх бөгөөд есдүгээр сард алагдсан ямар нэг тайж буюу ламын хүүр ялзарч байгаа юм болов уу гэсэн нь л оносон бололтой санагдана.

— Тэднийг энд хаясан юм гэж үү?

— Хааяагүй хаяж байсан юм чинь

— Энэ лав Шатлонд эд бад хийлгүүлэгсдийн нэг байх. Хоёрны өдөр би Меньял гүүрэн дээр овоолчихсон гурван зуугаад үхдэл харсан.

Үхсэн хойноо ч балаг тарьсаар байсан язгууртнуудын хонзонгоос парисынхан айж байлаа.

Настай эхээ «сүүлд» ядартлаа зогсохоос нь болиулахаар шийдэн Эварист Гамлен дугаарт орж зогсов. Хүрэн сюртук цамцныхаа хармаанд Лукрецийгээ түнгийтэл хийсэн амарлингуй хөрш Бротто нь инээмсэглэсээр түүнтэй цуг ирлээ.

Энэ нь орчин үеийн Тенирсын л урлан зурж байвал зохих хар бор хүмүүсийн амьдралаас авсан сэдэв мэт санагдсанд сайх өвгөн энэ дугаарыг үзээд бахархаж билээ.

— Энэ ачаа ачигчид, хов жив хөөцөлдөгч хүүхнүүд одоо манай зураачдын дурлаад байгаа грек, ромчуудаас илүү сонин шүү. Би хувьдаа фламандын төрлийг их шохоорхдог хүн байгаа юм гэж тэр хэлэв.

Болгоомжтой, ая зүйг олдог тэрээр тухайн үедээ голланд зургийн тоо болон сонголтоороо ноён де-Шаузелийн цуглуулга л зөвхөн дүйцэх бүхэл бүтэн үзэсгэлэнтэй байснаа дурссангүй.

— Эрт дээр үе, түүний хөхиүлсэн юм л зөвхөн сайхаан. Хэдий тийм боловч Тенирс, Стен, Остаде нарын хар бор ардын тухай сэдэвт зураг нь Ватто, Буше, Ван-Лоогийн ямар ч үнэ цэнгүй нялааснаас хавьгүй дээр. Тэд хүн амьтныг эрэмдэг зэрэмдэг дүрсэлсэн боловч Бодуэн, Фрагонар шиг бузарлаагүй шүү.

Дэргэдүүр нь сонины худалдагч

— Хувьсгалт шүүхийн зурагт хуудас! Яллагдагсдын нэрсийн жагсаалт! гэж дуудсаар өнгөрөв.

— Ганцхан хувьсгалт шүүх дутагдалтай байна. Хот бүрд онц шүүх байгуулах хэрэгтэй юм... Миний хэлэх юм энэ! Бүх өрхийн тэргүүлэгчид бүх иргэн шүүгч болох нь чухал. Дайсан их буугаар, урвагчид чичлүүр хутгаар үндэстнийг заналхийлж байхад өрөвч сэтгэл гэдэг хэлтрүүлшгүй ялт хэрэг мөн. Яалаа гэнэ ээ? Лион Марсель, Бордод бослого дэгдэж, Корсикт дургүйцэл гарч, Вандей галд автан Майнц Валансьен эвслийнхний эрхшээлд орон урвагчид хот, тосгон хуаран хааяагүй байна, шарваачид Үндэсний Конвентод хуралдан, тэрслэгчид газрын зураг барин манай жанжидтай хамт цэргийн зөвлөгөөнд оролцож байна. Гильотина л эх орныг минь авраг! гэж Гамлены хэлэхэд өвгөн Бротто

— Цаазлахыг нэг их эсэргүүцээд байх юм алга. Байгаль ертөнц бол цорын ганц хүмүүжүүлэгч багш минь, хүний амь нас ямар нэг үнэ цэнтэй байдаг гэж тэр огт заагаагүй, харин бүр шал ондоогоор, хүний амь ямар ч үнэгүй гэж элдвээр сургаж байна. Үзтэл алив амьд амьтны ганцхан үүрэг бол өөр амьтны идэш болох юм. Энэ амьтан нь өөрийн ээлжид бас л энэ зорилгод хэрэглэгдэнэ. Аллага гэдэг нь хууль ёсны эрхэнд харшлахгүй, харин ч хороох ял нь шударга ёс, ач буяны төлөө биш, зайлшгүй чухал болох буюу тэгэх нь ашигтай болсон үед хэрэглэвэл бүрэн хууль ёсны болно. Гэвч үнэнээ хэлэхэд цусыг бараг тэвчиж чаддаггүй гаж буруу зантай хүн дээ би, миний бүх номлол, энэ ёсноос гажууд зангаа хүчирдэггүй юм гэж хариулав.

— Бүгд найрамдахчууд энэрэнгүй, өр зөөлөн улс аа. Ганц харгисууд л алах ялыг засгийн чухал шинж тэмдэг мэт нотолцгоодог юм. Тусгаар тогтносон ард түмэн тухайн цагт нь үүнийг өөрчилнө. Робеспьер түүнийг эсэргүүцэж, бүх эх оронч түүний талд байсан. Үүнийг өөрчлөх хууль хурдан гарах тусмаа сайн. Гэлээ ч бүгд найрамдах улсын эцсийн дайсан хуулийн илдэнд хавчуулан унахаас нааш тэр хуулийг гаргаж болохгүй гэж Эварист ахин өгүүлэв.

Гамлен Бротто хоёрын ард голдуу энэ секцийн хожимдож ирсэн хүүхнүүд эрэмбэлэн зогссон хийгээд тэдний дунд хошуу алчуур зангидаж, чархи шагайвч өмсөөд бүсэндээ сэлэм зүүсэн нуруу өндөр, царай цэвэр нэхмэлч хүүхэн үнгэгдсэн алчууртай сэгсийсэн хонгор шар үстэй аятайхан бүсгүй, мяраа муутай хүүгээ хөхүүлж байгаа бие туранхай, царай цонхигор залуу эх гурав нүднээ тусаж байлаа.

Сүүндээ үл цадах нялх жаал хахаж цацан орилох боловч дуу нь дорой ажээ. Улайсан нүд, үрчийсэн цагаан царайтай элэг эмтрэм жижигхэн хүүгээ эх нь энхрийлсэн гашуудсан маягтай ширтэнэ.

— Улаан нялцгайгаараа юм байна шүү дээ гээд Гамлен, олонд түрэгдэж нуруунд нь шахагдан уйлагнах тэр золгүй хүүхдийг эргэн харав.

— Миний ганц эрдэнэ дээ, зургаан сартай юм... Эцэг нь цэрэгтээ, Кондод Австрийнхныг няцаагчдын нэг байгаа юм. Нэрийг нь Дюмонтейль (Мишель) гэдэг, цэмбэний мухлагийн даамал л даа. Хотын захиргааны өмнө босгосон дэвсэг дээр тэр цэрэгт элссэн юм. Хөөрхий, эх орноо хамгаалахын дашрамд юм үзэж нүд тайлах гэсэн юм сан... Намайг тэсэж байж үз гэж бичдэг. Гэтэл өөрөө хэлэн дээрээ тавих юмгүй байж би Полигоо (хүү минь Поль гэдэг юм) яаж тэжээх билээ.

— Чааваас аа гэж, энд бид бас цаг хэртэй зогсох нь ээ. Орой хүнсний хоршооны үүдэнд нөгөө л бахь байдаг нь болно доо. Гуравхан өндөг, үмх тосны төлөө амь дүйх ажил гарна аа хэмээн хонгор шар үстийг дуу алдвал

— Тосоо гэж! Барааг нь харалгүй гурван сар боллоо! гэж Дюмонтейль сүүрс алдав.

Тэгээд хүүхнүүд, идэх уух юм их үнэтэй ховор байна гэж ам амандаа шаагин гадаадад зугтагсдыг хараан зүхэж, элдэв шалдвын завхай авгай нарт зэвүү хүрэм нялганасны нь шанд дөрвөн фунтийн талх бордсон тахиа өгч байгаа секцийн комиссаруудыг цаазын газар

тонилгохгүй байгаад эгдүүцэн уурлацгааж гарлаа. Сена мөрөнд живүүлсэн бух муу усны шуудуунд асгасан тампуу гурил, жорлонд хаясан талхны... тухай дам дамаа түгшин ярилцана. Энэ бол Парисын оршин суугчдыг өлбөрүүлэх зорилго тавьсан роялч роланч, бриссотинчуудын хийж байгаа ажил аа.

Үнгэгдсэн алчууртай хонгор үст бүсгүй банзалд нь гал авалцсан мэт гэнэт чарлан түрийвчээ суйлуулчихлаа гээд байдаг чадлаараа хормой хотоо сэгсчин хармаанаа урвуулж гарав.

Сен - Жермений захын харшийг хүйс тэмтрэн Тюильрт дайран орсон боловч бусдын хөрөнгөнд хуруу дүрээгүй энэ харц ардууд хулгайн тухай дуулахдаа ихэд зэвүүцэв. Эдгээр гар урчуул, эзэгтэй нар Версерийн ордныг галдахдаа юман чинээ тоохгүй атлаа тэндээс сэтэрхий зүү ч авахыгаа ёстой гутамшиг гэж тооцох болой. Зүггүй залуус мөнгөө алдсан бүсгүйг тохуурхан ёжтой нь аргагүй хэдэн үг хэлдгийн даваан дээр нийтийн шуугиан тэднийг чимээгүй болгов. Хулгайчийг дэнлүүний шонгоос өлгөвөл таарна гэж ярилцана. Буруутай этгээдийг шуугин, махран бэдэрлээ. Өндөр гэгчийн нэхмэлч хүүхэн мухар толгойтой гэлэн лүгээ төстэй өвгөнийг заан энэ «капуцины<sup>28</sup>» л хийж байгаа ажил хэмээн ам шүд алдаж байв. Түүний үгийг огт эргэлзэлгүй үнэмшсэн улс даруйхан цээрлүүлэхийг шаардлаа.

Санамсаргүй хилс хэрэгт унасан тэр өвгөн, иргэн Броттогийн өмнөөс огт холдолгүй номхон зогсож байсан билээ. Үнэнийг хэлэхэд тэрээр гэлэнтэй тун төстэй ажээ. Есдүгээр сарын өдрүүдийн<sup>29</sup> тухай шинэхэн дуртгалыг өөрт нь санагдуулсан олны хилэнгээс тэр хүн айсан авч их л нэрэлхүү зогсож байлаа.

Сайн тунгаалгүй яаравчлан ял тулгах нь гэм зэмгүй хүнийг ч болов айлгана гэдгийг үл анхааран зөвхөн гэмт хүн гэлбэлзэн шийтгэлээс айдаг гэж жирийн ардууд итгэдэг учир эмээсэн байдал өвгөний нүүрэнд илэрсэн нь сэжиглэлийг баталж өгөв.

Ялангуяа тохиромжгүй, харгис арга хэмжээ авч байхад нь олон түмний хүсэл бодлоос ер зөрж болохгүй гэдгийг Бротто ёс болгон баримталдаг бөгөөд яагаад гэвэл ард түмний санал нь энэ тохиолдолд бурхны таалал мөн гэж тэрээр ярьдаг билээ. Гэвч Бротто туйлбаргүй хүн ажээ. Энэ хүн капуцин мөн ч байсан, биш ч байсан тэр эмэгтэйд хормын төдий ч ойртоогүй болохоор түрийвчийг нь авсан байж таарахгүй гэж тэр хэлэв.

Хулгайчийг өмөөрсөн хүн түүний хамсаатан байх нь зайлшгүй гэж цугларагсад үзсэн учир одоо хоёр хорон санаатныг гэсгээх тухай яриа гарлаа. Харин Гамлены Броттог хамгаалсанд арай ухаалаг нь түүнийг нөгөө хоёртой нь хамт секцэд аваачиж өгөх хэрэгтэй гэлцэв.

Гэнэт нөгөө хүүхэн түрийвчээ оллоо гэж баярлан хашхирлаа. Гэлэнмааг торлогдсон шиг л олны нүүрэн дээр занчина хэмээн хүмүүс тэр дороо түүн тийш дүнгэнэлдэн сүрдүүлэв.

— Ноёнтоон, өмөөрсөнд тань гялайснаа илэрхийлье, болгооно уу. Миний нэрийг дууллаа гээд танд ямар ч нэмэргүй гэвч танилцахыг соёрхоно уу. Намайг Луй де - Лонгмар гэдэг. Би нээрээ гэлэн хүн боловч энэ эмэгтэйчүүдийн нотолж байгаа шиг капуцин биш ээ. Энэ бол их алдас, би сүм хийдэд олон эрдэмтэн хутагтыг гаргаж өгсөн варнавчуудын холбооны хүн. Карл Борромео гэгээний үед холбоог үүссэн гэдэг улс ташаарч байгаа юм. Түүнийг жинхэнэ байгуулагч нь христосын эрхэм шавь Павел гэгээнийг гэж үзэх ёстой. Түүний алдрын эхний үсэг холбооны сүлдэн дээр байдаг нь дэмий биш ээ. Шинэ гүүр секцийг үүсэхэд би сүмээ орхин энгийн хувцас өмсөхөд хүрсэн юм даа гэж гэлэн Броттод өгүүлэв.

Лонгмарын хормой нь чирэгдсэн дээлийг ажиглан Бротто

— Эцэг минь, таны гадаад байдал алдар цолоо хаяагүйг чинь хангалттай гэрчлэн, таныг хараад холбооноосоо бүрмөсөн гарч дээ гэхээсээ түүнийг өөрчилж шүү дээ гэдэг сэтгэл түрүүн төрөхөөр байна. Ийм хар баринтаг өмсөж хилэнцэт харц олонд хараалгуулах юмаа өөрөө хийж байна гэсэнд

— Ямар нэг бүжигч шиг хөх фрак эгэлдрэглэчхэж би чадахгүй ээ гэж гэлэн татгалзав.

— Эцэг минь, таны зоригийг үнэлсэндээ. бас заналхийлж байгаа аюул ослыг анхаараасай гэсэндээ таны хувцасны талаар ийнхүү зааварласан билээ.

— Ноёнтоон минь, би алив аюулаас жигтэйхэн айдаг учир та миний сүсэглэн бишрэх эрмэлзлийг дэмжсэн бол дээр биз ээ. Баринтгаа өмсөхөө байсан минь нэг ёсны няцсан л хэрэг. Наад зах нь бурхны өршөөлөөр ертөнцийн хөл үймээнээс зайдуу өчнөөн жил толгой хоргодсон оронгоо орхихыг хүсэлгүй сүм дуган хоёрыг маань тэдний секц гэж нэрлээд байгаа жижиг захиргааны газар болгон хувиргаж байх зуур би өрөөнд суусаар байсан юм. Ноёнтоон, нүдэн дээр минь, улаан нүүрэн дээр минь ариун үнэн шашны сүлдийг туурганаас ховх

цохин харсаар байтал христосын эрхэм шавь Петрийн алдар нэр чимэг болон байсан яг тэр газраас цөлөгчийн малгайг өлгөлөө. Заримдаа секцийн зөвлөгөөнд сууж гүн алдас болмоор юм хэлэлцэхийг чагнаж байсан. Эцсийн эцэст энэ бузарлагдсан орноо орхиж зохион байгуулах хурлаас тавьж олгосон зуун пистолийн<sup>30</sup> тэтгэвэр аван, армийн хэрэгцээнд бүх агтыг нь авчихсан жүчээнд нүүж орсон юм. Цугларч байгаагаараа христосын сүм мөнх гэдгийг батлах хэдэн сүжигтэнд мөргөл үйлдэж өгдөг боллоо.

— Эцэг минь, хэрвээ миний нэрийг мэдэх хэрэг байвал намайг Бротто гэдэг, урьдын цагт өргөл цуглуулагч байсан гэж Броттог хариулсанд

— Ноёнтон минь, өргөл цуглуулагчаас ч үнэн үг сонсож болно гэдгийг Матфей гэгээний жишээ харуулж байгаа юм гэж эцэг Лонгмар татгалзав.

— Эцэг минь, та дэндүү эелдэг хүн юм.

— Иргэн Бротто, шударга ёсыг талхнаас эрхэмлэгч энэ улс таны бахдалыг төрүүлэхгүй байна гэж үү? Зөвхөн хулгайчийг л гэсгээхийн төлөө хэн нь ч байраа алдахаас буцахгүй байлаа биш үү? Хамгийн хэрэгцээтэй юмаар дутагдаж байгаа энэ харчуул, хүүхнүүд, ядуус цөм өөлөхийн эрхгүй шударга, ичгүүр сонжуургүй хэрэг хийсэнтэй эвлэрч чадахгүй байна шүү дээ гэж Гамлены өгүүлэхэд

— Ямар ч байсан хулгайчийг дүүжлэхийг чармайсан эдгээр хүн хүндэт гэлэн, түүнийг өмгөөлөгч, өмгөөлөгчийг өмөөрөгчийг толгой руу ус хийж мэдэх байлаа гэдгийг үнэнээр нь хэлэх хэрэгтэй. Сая бол тэд хомхой сэтгэл, юмандаа аминчирхсан хувиа хичээсэн үзэлдээ захирагдлаа. Яагаад гэвэл хулгайч тэдний нэгийнх нь юмыг авчхаад бусдад нь заналхийлж байсан учир түүнийг шийтгэснээр тэд өөрсдийгөө сэргийлэх байлаа. Энэ гар урчууд эзэгтэй нарын олонх нь үнэнч шударга, хүний юманд хүндэтгэн ханддаг байх дүүрэн боломжтой. Бөгсөн биеийг нь туйвандаж баймаажин сайн чанар олгосон эцэг эхээсээ энэ сэтгэлийг авсан биз гэж Бротто өчлөө.

Иймэрхүү үг гүн ухаантны амнаас багтаж гармааргүй гэж санаснаа Гамлен өвгөн Броттоогоос нуусангүй.

— Сайн чанар гэдэг бол хүний төрөлхийн зүйл, түүний үрийг бурхан таалал бологсдын зүрхэнд тарьсан юм.

Өвгөн Бротто уулаас сүжиггүй бөгөөд шашингүйн үзэл нь түүний баяр цэнгэлийн ширгэшгүй эх булаг нь болдог билээ.

— Иргэн Гамлен, үзвэл та чинь газар дэлхийн хэрэг явдлын талаар ярихдаа л хувьсгалч, огторгуйн талаар бол та хуучны, түүгээр ч үл барам харгис үзэлтэй хүн юм. Робеспьер, Марат хоёр ч гэсэн яг тан шиг дэвшлийг эсэргүүцэгчид. Үхсэн хааны эрх мэдлээс гарсан францчууд, үхэшгүй мөнх, түрүүчийнхээсээ зүйрлэшгүй харгис хаантай болох гэж зууралдан байгаа нь надад жигтэйхэн санагдах юм. Тамын оронтой жишвэл Бастила гяндан, шатаах ялтай вангийн шүүх юу бил ээ? Хүн төрөлхтөн өөрийн хааны дүрээр бурхныг бий болгосон байтал та харин эхийг нь хаяад хуулбарыг нь авч байна шүү дээ.

— Ээ Иргэн! Ийм юм ярихаасаа та зовохгүй байна уу? Бүдүүлэг ёс, айж эмээснээс бий болгосон муу бурхдыг, байгалийг заяагчтай хольж хутгаж яаж зүрхэлнэ вэ та? Нигүүлсэнгүй бурхныг шүтнэ гэдэг бол ёс суртахууны чухал нөхцөл мөн.

Дээд төрөлтөн гэдэг бол бүх буянтнуудын эх булаг бөгөөд бурханд итгэлгүй бүгд найрамдагч байж чадахгүй. Якобинчуудын хурлын танхимаас гүн ухаанч Гельвецийн баримлыг гарга гэж захирахдаа тэр нь францчуудын бурхангүйн үзлээр номлож завхруулж боолчлолд унагаасныг Робеспьер сайн санаж байсан... Иргэн Бротто, бүгд найрамдах улс Оюун санааны шүтээнийг тогтооход та лав ийм мэргэн шашныг дагагч болохоос татгалзахгүй биз хэмээн найднам.

— Би оюун санаанд дуртай, гэвч түүнийг мухар сохроор биширдэггүй ээ. Оюун санаа биднийг жолоодож, биднийг гэрэлтүүлэгч бамбар болдог. Түүнийг бурхан болговол таныг сохлон гэмт хэрэг бий гэдэгт итгүүлж өгнө гэж Бротто хариуллаа.

Түүний хэлдгээр, барон Гольбахын, байгалийн гүн ухааны үндэс болох алтадсан суудлуудын нэгнээ суун шүүн тунгаадаг байсан шигээ Бротто суваг дотор зогсон

— Жан - Жак - Руссо бол билэг авьяасаар дульхан, ялангуяа хөгжмийн салбарт бол таг, үнэндээ гүн ухааныхаа үзэл санааг Кальвинаас зээлдсэн мөртөө байгалиас гаргаж авсан гэж боддог хүн. Байгаль нь хүн хүнээ залгихыг сурган. нийгмийн нь байгуулал ёс горимоор халхлах буюу залруулж байгаа бүх гэмт хэргийн жишээг үзүүлж байна. Буян гэдгийг хайрлах хэрэгтэй, гэхдээ энэ нь хамтын амьдралаа тохилог болгохын тулд хүний бодож зохиосон хэрэгсэл мөн гэдгийг мэдэхэд илүүдэхгүй. Бидний ёс суртахуун гээд байгаа зүйл бол мань мэтийнхнээс, мөн чанар нь эсрэг тэсрэг хүчний тэмцэл хөнөөл сохор тоглоомдоо байдаг ертөнцийн дэглэм журамд арга нь

барагдахдаа халдсан хэрэг мөн. Ёс суртахуун нь өөрөө өөрийгөө устгаж, энэ тухай бодох тутам хорвоо даяараа галзуу тусаж гэж төдий чинээ итгэх юм. Бурхныг, байгалийг бүтээгч, орчлонг заяагч гэж зарлагч бурхны номлогчид, гүн ухаантнууд түүнийг харгис догшноор дүрсэлдэг. Эд нар бурхнаас айдгийн улмаас түүнийг өршөөнгүй гэж ярьдаг боловч үйл нь туйлын хэрцгий гэдгийг арга буюу зөвшөөрөхөд хүрдэг юм. Тэднүүс, бурхан нь хүнд ч ховор байдаг хонзонг өвөрлөж байдаг гэлцдэг. Тэд нар чухамдаа ийм аргаар л бурханд хүмүүсийг бишрүүлдэг юм. Тиймгүй бол доорд хүн төрөлхтөн, айх явдал огт үгүй энэрэнгүй шударга бурхныг тахихгүй сэн, буян хайрласны нь төлөө шал дэмий ач хариулах гэхгүй сэн. Там ариутгалын оронгүй<sup>31</sup> бол бурхан тэнгэр хамгийн өчүүхэн амьтан байх сан.

Гэтэл эцэг Лонгмар ярианд оролцон

— Ноёнтон минь, байгалийн тухай бүү яригтун, та түүнийг мэдэхгүй байна гэхэд Бротто

— Эцэг минь, би байгалийг таны дайтай сайн мэднэ гэж хэлж чадах байна хэмээв.

— Сүсэггүй хүн болохоор та түүнийг мэдэх ёсгүй, харин ганц шашин л байгаль гэж чухам юу вэ, сайн сайхан нь юу болох, хэрхэн түүнийг гуйвуулсныг бидэнд тайлбарлаж байгаа юм. Гэхдээ таныг эсэргүүцэх гэж байна гэж бүү бодогтун. Таныг төөрөгдлөөс гаргаж чадахуйц цогтой уран үг, хангалттай ухаан бурхан тэнгэрээс надад заяасангүй. Чадваргүйгээсээ болж таныг улам хилэгнүүлэн бурхныг хараалгах дэмий юм болуузай гэж би айна. Тэгээд танд тус болох гэсэн чин хүсэл байвч энэ сайн санааны минь ганц үр...

Дугаарын эхнээс адаг хүртэл цуурайтсан, мухлагийг нээж байна гэж цугларагсдад мэдэгдсэн чанга дуун түүний үгийг таслав. Учиргүй удаан гэлээ ч цөмөөрөө урагшилж эхэллээ. Үндэсний гвардич, худалдан авагчдыг нэг нэгээр нь оруулна.

Энэ секцэд хамаарах хүн мөн үү, биш үү гэдгийг нягтлагч, гэр бүлийн хүмүүсийн тоогоор ноогдсон л хэмжээнийхээ талхыг авч байгаа эсэхийг хянагч солгой гарын ханцуйдаа гурван өнгийн даавуу уясан иргэний хоёр комиссар лангууныхаа ард гэргий туслагч хоёртойгоо зогсож буй худалдагчийн ажлаас нь элбэлцэж байлаа.

Иргэн Бротто амьдралын эцсийн зорилгоо жаргал цэнгэлийг эрэн хайх явдал гэж үздэг хийгээд оюун санаа, мэдрэхүй хоёр бол бурхангүйгээр хүний ганц шүүгч мөн, өөр зорилготой байж болшгүй

хэмээн боддог ажээ. Иймээс зураачийн үг сэтгэлд нь алив нэг талаар тохирохооргүй дэндүү мухар сүсэгтэй гэлэнгийнх хэтэрхий энгийн болохыг сонсоод энэ мэргэн хүн тухайн байдалд өөрийн зан араншнаа гүн ухааныхаа үзэлд зохицуулах, тамаа цайм хүлээлтийг амархан өнгөрөөхийн тул хүрэн сюртук цамцныхаа түнтгэр хармаанаас хамгийн нандин жаргал, жинхэнэ дуршлын эх булаг нь болсон Лукрецийн ботийг гаргав. Байнгад эдэлж эргүүлж байснаас улаан савхин хавтас нь ихэд элэгдсэнээс гадна дамлагч эцэг нь өөрийн үедээ цөөнгүй мөнгө төлж хийлгэсэн гадар дээрх сүлд - алт шигтгэсэн гурван төгрөгийг Бротто болгоомжлон ховхолж хаяжээ. Номынхоо, яруу найрагч гүн ухаантны дурлалаас болж дэмий сэтгэл дэнслэхээс нь эрчүүлийг сэргийлэхийг хүсэн, амраг залуугийн сэтгэлийг доромжилж шивэгчнээ тэврэн байх үед нь янаг бүсгүйтэйгээ тааралдсан тухайгаа хүүрнэсэн хуудсыг тэрээр нээв. Энэ шүлгийг дахин дахин унших зуураа иргэн Бротто өмнөө зогсох аятайхан бүсгүйнхээ шилний нь алтан шаргал үсийг үе үе харан хөлөрсөн биеийн нь үнэрийг шунаг гэгч нь шиншилж байлаа. Яруу найрагч Лукреций ганцхан цэцэн сургаалыг баримталдаг байсан бол түүний шавь Бротто өв тэгш хүн байжээ.

Мөч тоолон хоёр алхам урагшлан Бротто номоо уншсаар байлаа. Латин хөгжмийн жигдхэн сүрлэг аялгууг бахданхан чагнаж агсан чихийг нь талх, ётон, цай, лаа, саван үнэтэй байна гэж хүүхнүүдийн хашхиралдан гомдол мэдүүлэх дуун дэмий л дэлсэх ажээ.

Ээлжээ болмогц зураач мухлагт орсонд сагс тавиурууд хоосон болсон байлаа. Талхчин, хамгийн сүүлчийн хоёр фунт ч үл хүрэх талхны буланг түүнд өгөв. Эваристыг мөнгөө төлөөд гарангуут нь цухалдсан улс мухлагт дайран орж мэднэ гэж сэрэмжлэн сараалж төмрийг хаалаа. Ийнхүү айсан нь илүүц болж, урьдын дарлагч, одоогийн чөлөөлөгчдөд захирагдаж сурчихсан ядуус толгой ганзагалсаар сажлан одов.

Өнцөг хүрээд Гамлен, Дюмонтейл хүүхнийг харлаа. Цусгүй цайсан царайтай тэрээр хүүгээ тэврэн ширмэн дээр сууж байв. Хүүхэн хөдлөх ч үгүй, уйлах ч үгүй, харах ч үгүй ажээ. Нярай жаал хурууг нь ховдоглон хөхнө. Гамлен, яахаа ч мэдэхгүй самгардан урд нь түр зогсосхийв. Хүүхэн, түүнийг ер анзаарахгүй байх мэт санагдана.

Эварист холбоогүй хэдэн үг бувтнаснаа эвэр иштэй эвхмэл хутга хармаанаасаа гарган талхаа дундуур нь зүсэж өөрийг нь гайхан харах

залуу эхийн өвдөг дээр тавиад булан тойрч одов.

Гамлены гэртээ ирэхэд ээж нь цонхон тушаа суун оймс цойлдож байв. Хүү нь хөгжилтэйгээ инээмсэглэн үлдсэн талхаа түүнд өгөв.

— Ээж ээ, уучлаарай. Гадаа энэ халуунд дугаарлан зогсож зогсож ядраад ирэх замдаа хагасыг нь идчихлээ. Таны хувь л үлдлээ.

Тэрээр хантаазнаасаа үйрмэгийг нь гүвж буй дүр үзүүлэв.

## VII

Нэгэн удаа бэлэвсэн авгай Гамлен «Дан туулайн бөөр идсээр байгаад хүрэн улаан болчих нь ээ дээ» гэж хууч үг хэлж билээ. Долоон сарын арван гуравны үдээр хүүтэйгээ хоёул туулайн бөөрний шингэн шөл ууцгаав. Тэднийг жаахан хоолоо идэж бартал хаалга онгойн нэгэн хатагтай орж ирэхэд тасалгаанаа үнэртэн ханхийж гэрэл туяа татах шиг болов. Эварист Рошмор хатагтайг танилаа. Дээр үеийн найз иргэн Броттогоо бэдэрсээр хаалга эндүүрч дээ гэж Гамлен бодоод тайж явсан түүний суудаг хонгилын үүдийг зааж өгье үү, эсвэл үзэсгэлэнт эмэгтэйг налуу шатаар дээш мацуулахгүйн тул Броттог доош дуудъя уу гэтэл хатагтай чухам л иргэн Эварист Гамлентай уулзах хэрэгтэй, түүнийг гэртээ байхад нь тааралдсандаа баярлаж хүндэтгэлээ илэрхийлж чадах байна гэв.



Давидын урлах газар зохион байгуулах хуралдаан дээр үзэгчдийн суудалд, якобинчуудын гэрт, гуанзны эзэн Венюагийн урьд хэдэнтээ дайралдсан учир тэр хоёр бие биеийнхээ зүсийг таних бөгөөд залуу эр Эваристын үзэсгэлэн, сонин галбир хатагтайн анхаарлыг татсан ажээ,

Малчны цоор лугаа адил туузаар ороосон, элчний малгай шиг өдөн соновтроор гоёсон бүрх малгай өмсөж. заар анхилуулан, мэнгэ тавьсан хиймэл үстэй Рошмор хатагтайн зузаан түрхсэн оо энгэсгийн доорх арьсны нь өнгө бас ч үхээгүй бөгөөд ийнхүү тун овжин маягласан нь ирээдүйдээ хэн ч итгэхээ больсон тэр аймшигт өдрүүдэд амьдрахын төлөө сэтгэл дэнслэн тэмүүлж байсныг гэрчилж байлаа. Лав нугалаастай энгэр, урт хормой, том гялтганасан болд товч бүхий

даашинз нь цусан улаан өнгөтэй ба энэ өнгө нь алуурч буюу алуулагчийн алины бэлгэ тэмдэг болохыг хэлэхэд хэцүү. Хатагтай Рошмор ийнхүү язгууртан хувьсгалч хоёрын сэтгэгдлийг зэрэг төрүүлж байв. Түүнийг нэгэн залуу дайчин дагалджээ.

Урт гэгчийн танан таяг барьсан нуруулаг, махлаг, мээм томтой үзэсгэлэн гоо Рошмор урлах өрөөгөөр явж бор нүдэндээ алтан хүрээтэй өсгөгч шил ойртуулан туурганд өлгөөстэй зургийг үзэх завсраа зураачийн царайлгийг бахархсанаа илэн далангүй хэлэн өөрөө бас магтуулахын тул магтаал үг урсган мишээнэ.

— Энэ юу вэ? Энэ юу харуулсан зураг вэ? Өвчтэй залуугийн дээрээс бөхийсөн энэ үзэсгэлэнт номой бүсгүйн байдал яасан сайхан, яасан уярам юм бэ?

Энэ бол «Электра, Орестын тэргүүний дэргэд» гэдэг зураг, хэрвээ үүнийг гараас гаргаваас лав хамгийн олигтой туурвил минь болох байх гэж Гамлен тайлбарлав.

— Еврипидын «Орестоос» сэдвийг нь авсан юм. Нэгэн удаа би энэ эмгэнэлт жүжгийн хуучны орчуулгаас нь миний бахархлыг төрүүлсэн үзэгдэл болох залуу бүсгүй Электра, үхлүүт хэвтээ ахыгаа өндийлгөн уруулд нь цахарсан хөөсийг арчиж нүд рүү нь унжсан үсийг янзлан илээд өс авагч охин тэнгэрийн дуугүй байх тэрхэн зуур хэлэх үгийг минь сонсооч гэж халуун хайрт ахыгаа шалгаан гуйж байгаа хэсгийг уншсан билээ. Энэ хэсгийг хэдэнтээ уншаад яагаад ч сарниулж болохгүй байгаа, грекийн хэлбэрийг ялгахад садаа болоод байгаа манан шиг юм нүдийг минь халхлаад байх мэт санагдсан юм. Эх нь арай өөр, ямар ч атугай сэтгэл хөдөлгөм байх мэт бодогдсон. Тэр тухай тодорхой ойлголттой болох сон гэдэг хүсэл минь буцлан би, Коллеж де Франсад грек хэлний багш (энэ ерэн нэгэн онд юм сан) байсан ноён Гелээс энэ үзэгдлийг махчлан орчуулж өгөөч гэж гуйсан юм. Тэр миний хүссэнийг биелүүлж би ч эртнийх нь бидний санаснаас арай энгийн, бодитой юм гэдгийг үнэмшсэн билээ. Жишээлбэл: «Хайрт ах минь ээ, таны дугхийсэнд хэчнээн их баярлаж байна. Би тусалъя, та өндийх үү?» гэж Электра Орестод хэлсэнд залуу «Тэг, тусал. Намайг өндийлгө, нүд уруул дээр минь хатсан хөөсийг арчаад аль. Намайг элгэндээ тэврээд үсийг минь хойш болгоод өгөөч, нүд халхлаад байна...” хэмээн хариулна. Ийм залуу, ийм амьд яруу найраг, гэнэн боловч тийм хүчтэй үгэнд туйлгүй догдолсон би хатагтай таны анхаарлыг татсан нооргийг хийгээд байгаа юм даа.

Ер нь бүтээлийнхээ тухай маш даруу ярьдаг зураач энэ зургийн талаар эцэс төсгөлгүй хөөрч чадах байлаа. Өсгөгч шилээ нүдэндээ ойртуулан буй хатагтай Рошморыг түүн рүү дохиход урамшсан залуу:

— Орестын хилэнг Геннекин гарамгай гаргасан юм. Гэвч Орест хилэнгээрээ биш уй гашуугаараа бидний сэтгэлийг илүү хөдөлгөж байгаа билээ. Хувь заяа нь ямар эмгэнэлтэй вэ! Үрийн хайраар жигүүрлэсэн ариун зарлигийг хүлцэн дагасан тэр залуу. бурхдыг цагаатгах ёстой боловч хүмүүс ер хэлтрүүлэхээргүй нүгэл хийсэн юм. Тэрээр шударга ёсыг доромжлуулсны өсийг авахын тул амьд байгалийн хуулийг зөрчиж, хүн төрөлхтнөөсөө тасарч цээжнээсээ зүрхээ суга татсан билээ. Аймшигтай боловч эрэлхэг муу үйлийнхээ ланчгийг омог бардам эдэлж явна... Энэ хоёроор ийм л юм үзүүлэх гэсэн юм даа гэлээ.

Даавуун дээрх зураг руугаа ойртон тэрээр түүнийг шуналтайяа ширтэнэ.

— Зарим газар нь, жишээлбэл Орестын толгой, гар бараг дууссан юм гээд түүний заахад нь хатагтай

— Гайхалтай юм. Иргэн Гамлен, Орест тантай төстэй юм гээч гэсэнд

— Та олж хараа юу? гээд Гамлен төлөвхөн инээмсэглэв.

Рошмор, Гамлены дөхүүлсэн сандал дээр суулаа. Залуу дайчин түүний хажууд зогсон сандлын нь түшлэгийг гараараа тулав. Энэхүү ганц зүйл л хувьсгал болсон гэдгийг гэрчлэх бөгөөд хуучны дэглэмийн үед бүстэй хүн, хэрвээ эелдэг, бүрэг зантай болж хүмүүжсэн л бол, мөн түүнээс гадна нийтийн дунд төлөв даруу байх нь сүүлд улаан нүүрээр учрах үес зоригоор аашлахад үлэмж тус болдог ба нэр хүндээ хугалахгүйн тул ингэх нь зүйтэй гэж тооцдог байснаас бүсгүй хүний сууж буй сандалд хуруугаа ч хүргэхийг цээрлэдэг байж билээ.

Вангийн егерийн хорооны бага даргын охин, прокурорын бэлэвсэн гэргий. хорин жилийн турш санхүүгийн ажилтан Бротто - дез - Илеттийн итгэлт найз нь байсан Луиза Маше - де - Рошмор шинэ үзэлтнүүдийн эгнээнд оржээ. 1790 оны долоон сард Марсын талбайд газар ухаж байхыг нь хүмүүс харсан аж. Засгийн эрх баригчдад жигтэйхэн тал засамтгай Рошмор, эхлээд фельянчуудыг<sup>32</sup>, удаж түдсэнгүй жирондчуудыг, дараа нь монтаньяруудыг<sup>33</sup> хүндэтгэх болсон агаад хувь нийлэх, танил тал олонтой байхад уулаас дуртай, яс хаялцуулах шуналтайн харгайгаар язгууртан, хувьсгалын

эсэргүүчүүдээс хэлхээгээ тасалсангүй. Түүнд танихгүй хүн гэж байдаггүй бөгөөд архины мухлаг, театр, гуанзны дэгжин эздийнх, тоглоомын газар, үзэсгэлэн. сонины газар, хорооны хүлээн авах өрөө зэрэг шагайхгүй газар гэж үгүй ажээ. Шинэ зуршил, наадам зугаа, жаргал цэнгэл, баяр баясгалан, ажил үйл, орлоготой үйлдвэрийг хувьсгал түүнд авчирчээ. Улс төрийн болон хайр сэтгэлийн талаар явуулга хийж ятга хөгжмөөр тоглож, байгалийн байдал зурж, романс дуулж, грек бүжиг бүжиж, үдшийн зоог барьж, хатан де - Бофер, жүжигчин Декуэн мэтийн голшиг хүүхнүүдийг хүлээн авч шөнө турш гучин нэг бириби, мэрэг наадах боловч тэрээр анхаарал тавьдаг нөхөдтэйгөө уулзах цаг олдог байлаа. Сониуч, ажилсаг, овилгогүй, гоомой эрчүүлийг судалсан, зон олон гэж хэн болохыг мэддэггүйн дээр няцсан үзлээсээ багагүй одоо баримталж байгаагаасаа хөндий, Францад юу үүтгэгдэж байгааг эх ухаарагч Рошмор зальтайн гадна аюулыг ойлгодоггүй, мөн өөрийн үзэсгэлэн гоодоо хязгааргүй эрдэх тул эрэмгий зоригтой билээ.

Түүний бараа бологч цэрэг эр орь залуу хүн агаад час улаан саагаар хажсан залаатай ирвэсийн арьсаар гоёсон зэс дуулга тэнгэрлэг царайг нь сүүдэртүүлж, учиргүй урт үс нь нуруу руугаа намиран унжина. Дур татам тахимаа халхалчихгүйн тул дөнгөж борвиор татсан цээжмэг маягийн улаан хүрэм өмсжээ. Бүргэдийн хошуу хэлбэрийн гялалзсан бариултай том илд агсжээ. Ташаандаа товчтой цэнхэр өмд нь эгцхэн хөлийг нь яг барин таарч, хар хөх манжлагын гоёмсог угалз гуяыг нь чимэглэжээ. Дүрсийг хялбархан гаргах гэж мэрийгч Давидын аль нэгэн шавь түүнийг харан «Скирос дахь Ахилла» буюу «Александрын гэрлэсэн нь» гэдэг зураг зурж болохуйц дайчин хэр нь ээ нялуун дүрд тоглох гэж гоёсон бүжигчин мэт байлаа.

Түүнийг урьд зүс үзсэн мэт Гамленд бүүр түүр санагдав. Үнэхээр ч энэ бол хоёр долоо хоногийн урьд Үндэсний театрын асар дээрээс цугларсан олны өмнө илтгэж байсан цэрэг эр мөн байлаа.

— Хүний эрх гэдэг секцийн хувьсгалт хорооны гишүүн иргэн Анри гэж Рошмор хатагтай танилцуулав.

Хайр дурлалын нь толь, эх оронч үзлийн нь амьд гэрч болсон тэр залууг Рошмор газар сайгүй дагуулж явна.

Хатагтай Гамлены авьяас чадлыг ахин шагшран магтсанаа тус болох гэж бодсон үйлчний минь хаягийг бичиж өгөхөөс татгалзахгүй биз гэж түүнээс асуулаа. Тохиромжтой сэдэв, жишээлбэл хүний

сүнсний өмнө хүзүүний ороолт тохируулж үзэж байгаа эмэгтэй, эсвэл бүрх малгайны хайрцаг барьсан уран бүсгүйг зурж болох юм гэв.

Энэ яльгүй ажил хийж чадах улс гэж фрагонар хүү, залуу Дюси, мөн түүнчлэн нөгөө Прюдом нарыг түүнд зааж өгсөн авч Рошмор үүнийг Эварист Гамленаас асуух нь дээр гэж үзжээ. Гэвч тэрээр энэ талаар тодорхой өгүүлсэнгүй ер нь энэ захиалга яриа хөөрөө үүсгэх шалтаг байжээ гэдэг нь мэдэгдэж байлаа. Үнэндээ тэр хүүхэн шал өөр зорилготой нааш иржээ. Иргэн Гамлен иргэн Маратыг таньдаг гэдгийг мэдэх болохоор хатагтай, Ардын нөхөртэй жаал ярилцах гэсэн юм, танилцуулж өгч тус болооч хэмээн түүнээс гуйв.

Маратынд түүнийг оруулж өгье гэхэд би даанч өчүүхэн хүн, ер нь тэгээд ч амьтны ярьдгаас шал өөр Марат хэчнээн их ажилтай байлаа ч хүн бүрийг хүлээж авдаг учир ямар ч хөндлөнгийн зууч хэрэггүй биз хэмээн Гамлен хариулав.

— Хатагтай минь, зовж зүдрэгсдэд тэр их л уриалгахан ханддаг, уй гашууд учрагсдыг өрөвддөг маш сайхан сэтгэлтэй болохоороо хэрэв танд золгүй явдал тохиолдсон л бол хүлээн авна. Тэр урвагчдыг илрүүлэх хэрэгт биеэ зориулсан хүн учраас та нийтийн сайн сайханд хамаатай ямар нэг зүйлийн талаар уламжлах гэж байвал таныг хүлээн авна хэмээн Гамлен нэмж хэлэв.

Эх орондоо агуу тус хүргэсэн, хойшид ч бүр ихийг бүтээх чадалтай алдарт иргэн Маратыг мэндчилэхдээ баярлах бөгөөд энэ хууль тогтоогчийг сайн санаатай, хүн төрөлхтнийг хайрлах гүн хайрыг нь хангах шинэ хөрөнгө түүнд өгч чадах чинээлэг энэрэнгүй хүмүүстэй уулзуулах гэсэн юм гэж хатагтай Рошмор хариулав.

— Баячуулыг нийгмийн тустай ажилд татаж оруулах гэсэн юм хэмээн тэр нэмж өгүүллээ.

Үнэн хэрэгтээ тэр хүүхэн, банкны эзэн Морхардыг Мараттай хоолон дээр танилцуулна гэж ам өгсөн юм санж.

Ардын нөхрийн адил швейцар гаралтай Морхард нь Жюльен (Тулузын), Делоне (Анжерын), капуцин байсан Шабо зэрэг Конвентийн хэдэн гишүүнтэй Энэтхэгийн эвслийн хувь нийлүүлсэн тэмдэгтийг дамлах зорилгоор хэлэлцээ хийжээ. Энэхүү маш хялбархан наадам нь луйвар явуулгын замаар цаасан тэмдэгтийг зургаан зуун ливр болтол ханшийг нь бууруулаад энэ үнээрээ аль болох их хэмжээгээр худалдан авсны эцэст өртгийг нь дөрвөөс таван мянга хүртэл тайтгаруулах аргаар нэмэгдүүлэх явдал билээ. Гэвч Шабо,

Жюльен, Делоне нар нэр нь хугарч гүйцсэн, Лакруа, Фабрд Эглантин мөн Дантон хүртэл хараанд орсон байлаа. Биржийн гол мөнгийг аялуулагч барон де Батц Конвентэд шинэ хамсаатныг хайгуулдаж банкны эзэн Морхардад Мараттай танилц хэмээн зөвлөсөн ажээ.

Дамчдын хувьсгалын эсэргүү бүлгийнхний бодол нь зэрвэсхэн хараад санагдам тийм ч найдваргүй биш байлаа. Эдгээр хүмүүс тухайн цагт засгийн эрхэнд байгаа хүнтэй харилцаа тогтоохыг улайрдаг агаад Марат бол өөрийн алдар цуу, бичгийн чадал, зан чанараараа асар их хүч билээ. Дантоныхан шуурганд цохиулан залуураа гараасаа алдсан учир жирондчуудын өдөр тоологдож байв. Ард түмний шүтээн болсон Робеспьер худалдагдашгүй үнэнч, сэрэмжтэй агаад аливаад авташгүй билээ. Иймээс Маратыг мэхэлж түүний найрсаг харьцаанд тулгуурлан захирагч болох өдрийг нь анах нь чухаг болсон бөгөөд зар, цуу ихтэй, нэр алдарт дуртай, шийдвэр төгс арга хэмжээ авах чадалтай зэрэг нь түүнийг захирагч болно гэдгийг хэлж байлаа. Эцсийн эцэст Марат санхүү, хөрөнгө зөөр, журам дэглэмийг сэргээхэд болохгүй гэх газаргүй байв. Эх оронч үзлээрээ түүнээс давах гэж чармайгч мухар сүжигтний эсрэг нэг бус дайрч, дундыг баригчдын адил дэмий хийрхэгчдийг нэг үе илрүүлж байсан. Дамчдыг дүүжлэн мухлагийг нь тоно гэж ард түмнийг ятгаж байсан бол одоо төрийн хар хүн болсон болохоор иргэдийг амгалан тайван ул суурьтай байхыг уриалж байлаа.

Хувьсгалын бусад зүтгэлтний адил түүний тухай дэлгэрч байсан цууг хайхралгүй энэ шулаачид түүнийг биеэ худалдахгүй гэдэгт эргэлзсэнгүй боловч ихэрхүү гэдгийг нь мэддэг ба түүнийг зуйрч, ялангуяа ямар ч бялдуучилж зусардсанаас илүү хүлцэнгүй, эрээгүй авирлаж түүнийг залилна гэж горьдож байв. Маратын тусламжтайгаар худалдах, худалдан авахыг хүссэн үнэт зүйлсийн үнийг хямдруулах юм уу өндөржүүлнэ гэж тэд тооцоолон Марат нь нийгмийн тусын тулд ажиллаж байна гэж санаад тэдний эрх ашгийн үүднээс ажиллах болно гэж бодоцгоосон ажээ.

Хэдийгээр эмэгтэй хүний дурлалаасаа татгалзах насанд хүрээгүй боловч далдуур ханилагсдыг зуучлах мэргэжил бүхий Рошмор хатагтай хууль тогтоогч сэтгүүлчийг банкны эзэнтэй танилцуулах зорилго тавих бөгөөд есдүгээр сард амь үрэгдэгсдийн цусанд будсан гартай хувьсгалчийг өөрөө төлөөлөгч нь болж яваа санхүүчдийн бүлгийнхээ түнш болгочихсон мэт ухаангүй хий бодолд нь дүрслэгдэн өрөвдөмтгий, итгэмтгийнх нь ачаар түүнийг биржийн панзчидын яг

төвд, хамгийн хайртай хүмүүсийнхээ хүрээнд. гадаадын нууц даалгавартан, дамчин, нийлүүлэгч, мөнгө атгагч, хөзөрчдийн ертөнцөд оруулчихсан мэт тов тодхон санагдана.

Кордельерын гудамжнаа сүмийн хажууд суудаг Ардын нөхрийнд аваачиж өгөөч гэж Гамленаас шалгаав. Хэсэг зөрснөө зураач хүссэний нь зөвшөөрөв.

Цэрэг эр Анригаас хамт явахыг хүсвээс бүгд найрамдах улсад маргаангүй тус хүргэсэн авч сүүлийн үес өөрийн сониндоо Парисын оршин суугчдыг оногдсон үйл лайтайгаа эвлэрэхийг зөвлөн буулт хийсэн шинж үзүүлсэн иргэн Маратаас ч гэсэн холхон байя гэдгээр арга саам хийн татгалзав.

Тэгээд Анри, ярианыхаа завсраар гүнзгий санаа алдан яруухан дуугаар бүхий л найдлагаа тавьж байсан хүмүүс болох, секцийг өөрчлөхгүй гэдгийн эсрэг боссон Робеспьер шантрамтгай зөвлөгөөгөөрөө иргэдийн гал цогийг бөхөөж байгаа Марат нарыг бүгд найрамдах улсаасаа урвасанд гашуудан үглэнэ.

— Ай Леклерк, Жак Ру<sup>34</sup> ... нартай жишвэл эд ямар дорой улс вэ! Ру... Леклерк! Тануус ёстой ард түмний нөхөд мөн! гэж тэрээр дуу алдав.

Хөх фракаа өмсөхөөр хажуугийнхаа өрөөнд орсон байсан учир яриагүй эгдүү нь хүрэх байсан энэ үгийг Гамлен дуулсангүй.

— Та хүүгээрээ бахархаж болно. Хачин авьяаслаг, хачин сайн хүн гэж Рошмор хатагтай Гамлен авгайд өгүүлэв.

Бэлэвсэн авгай Гамлен хүүгийнхээ сайн гэдгийг баталсан авч эл ертөнцийн хүчтэний өмнө номхон хүлцэнгүй байх нь ядуу буурай хүмүүсийн эн тэргүүний үүрэг гэж балчир ахуй цагаас нь түүнд сургамжилсан болох учраас тэрээр сурвалжит угсааны энэ хатагтайд өчүүхэн ч бардамнасангүй.

Хувь тавиландаа сэтгэл дундхан байх нэлээдгүй шалтгаантай тэрээр үүндээ гоморхон үглэх нь үргэлж агаад энэ гомдол нь түүний сэтгэлийг бага сага хөнгөрүүлэх бүлгээ. Өөрт нь тус болж чадах хүн мэт санагдсан хүн бүртэй уй гашуугаа хуваалцах дуртай тэр авгайд Рошмор хатагтай яг л тийм хүн мэт сэтгэл төрүүлжээ. Аятайхан далим гарсныг ашиглан хүүтэйгээ хоёул эгээ л харангасаж үхэлгүй гачигдаж зовж байгаагаа нэгэн амьсгаагаар тоочив. Хувьсгал, худалдааг хутгаар огтлох мэт тасалчихсан учир зургийг хэн ч үл авна. Хоол хүнсний зүйл ховор, олж авахад бэрхтэй.

Бардам зантай Эварист энэ гоморхлыг нь төдийлөн таашаахгүй байх байсан учир эмгэн түүнийг ирэхээс өмнө хэлэх гэснээ хэлчих гэж сандран шамшгар уруул, эвлэж үл өгөх хэлээ чинээгээр нь хурдан хөдөлгөнө. Эмгэн баян бөгөөд нөлөөтэйд тоолж байгаа хатагтайдаа хүүгийнхээ хувь зохиолыг шалавхан сонирхуулж өрөвдөх сэтгэл төрүүлэхийг мэрийнэ. Эваристын гоо үзэсгэлэн энэ сурвалжит эмэгтэйн сэтгэлийг хөдөлгөхөд нь түүнд тусална гэж санажээ.

Үнэхээр ч хатагтай Рошмор цэвдэг сэтгэл гаргасангүй. Эварист ба түүний эх хоёрын гамшиг зовлонгийн тухай бодохдоо сэтгэл нь уярч яаж тэр хоёрт нэмэр болох билээ гэж бодлогошров. Зураачийн зурсан зургийг найз баячуулыгаа худалдан ав гэж тулгадаг хэрэг!

— Францад мөнгө бий нь бий! Ганцхан ил гаргахгүй л байгаа юм гээд тэр хүүхэн инээмсэглэв.

... Эсвэл болиод, нэгэнт урлаг мөхсөн болохоор Эваристыг Морхардтынд ч юм уу, ах дүү Перрегогийн д ч юм уу ажилд оруулж, үгүй бол ямар нэг цэрэгт юм нийлүүлэгчийн итгэмжлэгдсэн хүн болгодог юм бил үү.

Гэвч сүүлд нь ийм зантай хүнд энэ нь таарахгүй ажил гэж шийдэв. Хэсэг зуур бодолхийлснээ гараа баяртайяа дэлгэн

— Хувьсгалт онц шүүхийн хэдэн ардын төлөөлөгчийг томилох ёстой юм. Таны хүү ардын төлөөлөгч, шүүгч болно. Нийгмийг аюулаас хамгаалах хорооны гишүүдтэй би танил. Би Робеспьерын ахыг мэднэ, дүү нь манайд үргэлж оройн хоол иддэг юм. Би тэдэнтэй ярилцъя. Монтане, Дюма, Фукье нартай хэнийг яриулбал зохихыг асууя гэлээ.

Сэтгэл нь догдолж, баярлаж хөөрсөн Гамлен авгай Эваристыг өрөөнөө орж ирэхэд чимээгүй гэж хуруугаараа уруулаа дарав.

Паалантай тоосго суулгасан модон гишгүүр нь дивангарын зузаан шавар шавхайд дарагдсан харанхуй шатаар Гамлен, Рошмор хатагтайн хамт уруудлаа.

Наран хэдийнээ хэвийн, дээр нь нэгэн цагт хүрэл морь сүндэрлэж байсан, одоо үндэсний далбаагаар чимэглэсэн хөшөөний суурины сүүдрийг уртасгаж, шинэ гүүрэн дээр эр эм харц ард бөөгнөрөөд, шивнэлдэн ярилцах хэсэг улсын үгийг чагнах ажээ. Гансралд автсан хүмүүс таг чимээгүй, хааяа нэг гиншин ёолж хилэгнэн дуу алдаж байлаа. Олонх нь урьд Дофины гэгдэж байсан Тионвиллийн гудамж руу шаламгайлан алхална. Хэсэг бөөгнөрсөн хүмүүс дээр очоод Гамлен Марат дөнгөж сая алагдсан гэж дуулав.

Эл мэдээ аажим аажмаар батлагдсаар энэ гэмт хэргийг үйлдэх гэж Канаас зориуд ирсэн нэг эмэгтэй Маратыг угаалгын нь өрөөнд хутгалжээ гэдэг нь тодорхой мэдэгдэв.

Зарим нь түүнийг зугтааж амжсан гэх боловч ихэнх нь түүнийг барьсан гэж байв.

Тэд, эзэнгүй орхисон мал адил чихэлдэнэ. «Өр нимгэн, уриалгахан. биднийг жолоодож агсан хэзээ ч алдаж осолддоггүй, бүхнийг таан мэдэгч, хөнөөлтнүүдийг зоригтойёо илчлэгч Марат маань байхгүй боллоо! Яах билээ, юу хийх вэ? Бид зөвлөгчөө, өмгөөлөгчөө, нөхрөө алдлаа» гэж тэд бодоцгооно. Тэд нар түүнийг хаагуур нь хутгалсан, хэн тэр хүүхнийг илгээснийг мэдэж байлаа.

— Биднийг ч гэсэн устгахыг хүсэгч тэр гэмт этгээдүүдийн гарт Марат амь эрсдэлээ. Түүний үхэл, эх орончдыг толгой дараалан бултыг нь хөнөөнө гэдгийн дохио мөн гэж тэд хүндээр сүүрс алдана.

Энэхүү эмгэнэлт үхлийн тодорхой байдал, амь алдагчийн эцсийн үг нь юу болох тухай янз бүрээр ярилцан, урвагч федералчуудын явуулсан залуу бүсгүй гэдэг нь л мэдэгдэж байсан алуурчны тухай асууцгаана. Толгой авах гэдэг бол хөнгөхөн гэсгээл гэж бүсгүйчүүл үзэн энэ хүний үнэргүй амьтныг торлогдож, хүрдэнд тэлж, дөрвөн мөчөөр нь тасчиж алах хэрэгтэй хэмээн шинэ шинэ эрүүдлэг бодож олон ялт эмийг даруйхан тонилгохыг галзуурсан мэт шаардаж байлаа.

Сэлмээ сугалан барьсан үндэсний гвардичууд яахаас ч буцахаа больсон царайтай нэгэн хүнийг секцэд чирч гулдран оруулав. Хувцас нь ноорон салбайж зэвхийрсэн хацрыг нь даган цус нарийн зам татан урсах ажээ. Марат алж хяд, тонож дээрэмд гэж цаг ямагт уриалж байсан болохоор үйлээ эдлэх нь тэр дээ гэж ярьж байх үед нь түүнийг барьжээ. Сахиул нь хилэгнэн улангассан олноос түүнийг арайхийн хамгаалж билээ. Алуурчины хамсаатан хэмээн түүнийг чичлэн ална гэж занаж байв.

Гамлен харамсан гашуудсандаа хөшсөн мэт болов. Улайсан нүдэнд нь ганц нэг нулимс гарч ирснээ хатна. Зүрхийг нь зүсэх хүүгийн уй гашуу, эх оронч эрийн түгшүүр, ард түмнээ хайрлах хайр энэ бүгд сэтгэлд нь хосолно.

«Ле - Пельтьегийн дараа, Бурдоны дараа Марат ингэчихлээ! Эх орончдын төөрөг энэ дээ. Марсын талбайд, Нансид, Парист бут цохиуллаа, цөм сүйдэж гүйцнэ» гэж тэр бодов.

Хэрвээ ялгуусан эх орончид замыг нь хаагаагүй бол түмэн зовлон эдэлсэн баатарлаг Парисын гал мэсийн аюулд хэлмэгдүүлэхээр жаран мянган роялчуудыг тэргүүлэн нааш ирж явсан урвагч Вимпфеныг санав.

Ганц цэцэн цэлмэг сонор соргог Марат л нээн илрүүлж чадах байсан урвах шарвах явдал, ялт санаархал, аюул занал хэчнээн их байна вэ? Цезарийн хуаранд гар хумхин суугаад Валансьеныг бүслэлтээс чөлөөлөхийг татгалзаж байгаа Кюстиныг түүнээс өөр хэн илчлэх вэ? Сомюр, Нант хотуудыг дайсанд идүүлэх гэж Доод Вандейд урьдчилан юу ч хийхгүй урваж байгаа Бароныг хэн илчлэх вэ? Аргоинд эх орноосоо урваж байгаа Диллоныг хэн илчлэх вэ?

— Марат байхгүй болсон! Түүнийг язгууртнууд алсан гэж муу ёрлон орилох дуун түүний орчинд хором бүрд чангарсаар байлаа.

Уйтгар гуниг, жигшил зэвүүцэл, өрөвдөл хайр сэтгэлд нь бялхах залуу эр, эрх чөлөөний төлөө тарчлан зовогчид эцсийн хүндэтгэл үйлдэхээр хандахад ноосон оройвч малгайтай нэгэн тариачин эмгэн түүнд дөхөж ирээд Марат гэдэг ямар ноёныг алчихаав. Сен - Пьер - де Керуагийн ламыг биш биз? гэж асуужээ.

## VIII

Баярын урьд өдрийн намуухан тунгалаг орой Элоди Эваристтай сугадалцан Холбооны талбайгаар зугаалж явлаа.

Багана, хөшөө, орд, уул, тахилгын овоо зэргийг босгох ажлаа ажилчид яаравчлан дуусгаж байв. Ард түмнийг төлөөлсөн Геракл болон ширгэшгүй хөхөөрөө орчлонг ундлагч байгалийг бэлэгдсэн лут том хоёр хөшөө. Могийн замд австрийн их буу нүргэлж байна уу үгүй юу гэж чих тавин чагнагч өлсгөлөн гачаал алан хядлагын эрхшээлд орсон нийслэлд гэв гэнэт сүндэрлэлээ. Вандей баатарлаг ялалтаараа Нантын дэргэд дийлдсэнийхээ орыг авч байв. Гал хөс, үзэн ядахын төмөр цагаригийн ам агуу хувьсгалт хотыг хүрээлэн нийлж байлаа. Хэдий тийм боловч уудам их эзэнт улсын эзний сүр жавхлант энэ хот үндсэн хуулийг зөвшөөрөгч хөдөөгийн хурлын депутатыг хүлээн авч байсан билээ. Бутаршгүй нягтармал бүгд найрамдах улс бүх дайснаа дийлж, федерализм ялагдал хүлээжээ.



— Тэнд гээд Эварист түм язганасан талбайг заан, — Ерэн нэгэн оны зургаан сарын арван долоонд жигшүүрт Байи эх орны шүтээний дор ард түмнийг буудсан юм. Энэ яргаллын гэрч Гренадер Пассаван гэртээ хариад хувцсаа уран «Би эрх чөлөөтэй хамт үхэх андгай өргөсөн. Эрх чөлөө одоо алга, би үхлээ!» гэж дуу алдаад духандаа сум зоосон юм гэж өгүүлэв.

Энэ зуур зураачид энгийн хөрөнгөтнүүд баярт хэрхэн төхөөрч буйг алмайран харах агаад зэвхий даасан амьдралаасаа бараг уйдсан байдал царайд нь тодорно. Агуу их үйл явдал тэдний оюунд шингээд хэр хэмжээнд зохицон тэдэн лүгээ адил өчүүхэн болжээ. Хос болгон, эцэг эхээсээ царай муутай, тэднээс аз жаргалтай болж чадахааргүй, өөрсөд шигээ гоо үзэсгэлэн баяр баясгалан дутуу төрсөн үрстээ

амьдралыг шилжүүлэн өгөх ёстой хүүхдээ тэврэх нь тэврэн, гараас нь хөтлөх нь хөтлөн, өмнөө оруулах нь оруулан явах ажээ. Залуусын тачаангуйн хүслэнг бадраасан, урьдын таатай амьдралдаа харууссан сэтгэл өтгөст төрүүлсэн нуруулаг гоолиг бүсгүйчүүд өдрийн од шиг дайралдана.

Цэргийн сургуулийн хажууд Эварист Августын үеийн ромын загвараар Давидын хийсэн египет хөшөөний дүрсийг Элодид харуулав. Оо түрхсэн өвгөн тэр хөшөөг үзэнгүүтээ

— Нил мөрний эрэг дээр байна гэж бодмоор юм гэж дуу алдав.

Элодийн найзтайгаа уулзаагүй тэр гурван хоногт «Амур - зураачид» чухал үйл явдлууд болж өнгөрчээ. Иргэн Блез нь армид ханган нийлүүлэх үедээ луйвар хэрэглэж байна гэж нийгмийг аюулаас хамгаалах хороонд хов мэдээ хүрсэн байжээ. Аз болоход хэвийн худалдаачин тус секцэд танилтай байж. Пикийн секцийн Ажиглах хороо, Нийгмийг аюулаас хамгаалах хорооноос түүнийг бүрэн итгэлтэй хүн гэж дааж аван улмаар Блезийг бүрмөсөн цагаатгасан гэнэ.

Элоди энэ бүхнийг түгшингүй яриад

— Одоо л бид санаа амарлаа, бузгай тэвдэцгээсэн шүү. Аавыг золтой л шоронд хийгээгүй. Эварист минь, жаахан л удсан бол нөлөөтэй найз нараасаа эцгийг суллуулах талаар хөөцөлдөж өгөөч гэж танаас гуйх байсан юм гэв.

Эварист хариу үг дуугарсангүй. Элоди түүний дуугүй байсны учрыг бүүр ойлгосонгүй.

Тэд сугадалцан Сена мөрний эгц эргийг даган явав. Сайхан сэтгэлт Жан Жак<sup>35</sup> хайр дурлалаа уудлан гоёор ярих бүхий л хэрэгслийг тэдний мэдэлд өргөн барьсан учраас тэр хоёр Юлия, Сен - Пре нарын хэлээр янагийн үг солилцоно.

Өлсгөлөнд учирсан хотод ганцхан өдөрт л элбэг дэлбэг байдал бий болгон хотын захиргаа гайхамшгийг бүтээв. Голын ойролцоох Тахир дутуучуудын талбай дээр яармаг нээгдэн хиам, болгосон утсан сервелатын эрээлж, халуун навчинд боосон гуя, нантер боорцог, боов, шүүрмэг бин, дөрвөн фунтийн талх, нимбэгийн шүүс, дарсыг мухлаг дэлгүүрт зарж байлаа. Түр босгосон бусад саравчинд эх оронч дуу, малгайн тэмдэг, гурван өнгийн тууз, хэтэвч, зэс гинжин оосор болон бас бус аахар шаахар юм худалдаалж байв. Нэгэн ядуухан уран дархны лангууны дэргэд зогсон Эварист, алчуур зангидсан Маратын толгойн

төвгөр дүртэй мөнгөн бөлзөг шилж аваад Элодийн хуруунд зүүж өглөө.

Тэр оройгоо Гамлен, яаралтай ажлаар түүнийг урьсан Рошмор хатагтайнд очихоор Хуурай модны гудамж руу явав. Хатагтай унтлагынхаа өрөөнөө бандан дээр хамаг нь ил шахуу гэрийн даашинзтай хэвтэж байхдаа түүнийг хүлээн авав.

Ахайтны байдал алжаангуй хуял байдлыг илтгэх бөгөөд тагийг нь хагас нээсэн төгөлдөр хуурын дэргэдэх ятга, сандал дээрх гитар, хатгамаллахаар тэлсэн пүүсүүтэй тэлүүр, ширээн дээр эхлээд орхисон зураг, цаас, ном, сэтгэл хөдлөн уншиж үзэх гэж яарч шүү дээ гэж санагдам булбарай гараар онгичин замбарааг нь алдуулсан номын шүүгээ тэргүүтэн орчны нь юмс түүний юу сонирхдог, юунд авьяастай ямар хөөрхөн болохыг нь өгүүлэх ажээ.

Ардын төлөөлөгч иргэн таны амрыг айлтгая! гэж хатагтай гараа үнсүүлэхээр сарвайнгаа хэлээд — Өнөөдөр ахмад Робеспьер, таныг маш сайн тодорхойлсон захиаг Эрман даргад надаар дамжууллаа. Түүний агуулга нь барагцаагаар «Авьяас чадвар, эх оронч үзлээрээ анхааран үзэж болохыг харуулсан иргэн Гамленыг танд өгье. Зарчим зан байдал нь бүхий л талаар хувьсгалч үзэл санаатай зохицож буй эх орончийг танд зааж өгөхийг үүргээ гэж тооцов. Бүгд найрамдагч залууд тус болох далим гарахыг ашиглахаа мартуузай...” гэж байсан. Эрманд уул захиаг даруйхан хүргэж өгсөнд тэр намайг хачин эелдэг хүлээж аваад таныг томилсон тухай тушаалд гарын үсэг зурсан шүү. Энэ бол шийдэгдсэн хэрэг гэхэд нь

— Хатагтай, эхийгээ тэжээх юм байхгүй хэдий боловч би зөвхөн бүгд найрамдах улсдаа алба хаах, түүний бүх дайснаас өшөөг нь авахын тулд л ардын төлөөлөгчийн албан тушаалыг хүлээн авъя гэдгээ нэр төрөө барьж тангараглая хэмээн Гамлен хэсэг дуугүй байснаа хариулав.

Их л хүйтэвтэр тал өгч, хайхрамжгүй мэхэсхийх мэт хатагтайд санагдав. Тэрээр Гамленыг бүдүүлэг юм гэж ч тооцож билээ. Гэвч Рошмор, залуу хүмүүст ийнхүү ширүүн харьцаж байгааг хэлтрүүлэхгүй байж чадахааргүй дэндүү дуртай ажээ.

Гамлен гоолиг хийгээд энэ нь хатагтайд мундаг юм шиг санагдана. Үдэш болгон театрын дараа зочин гийчин тэднийд цуглардаг байсан

учир «Үүнийг улам ч гялалзуулна даа» гэж хатагтай бодоод Эваристыг оройн зоогт урив.

— Ухаалаг, авьяаслаг залуус Эльвид Тальма, даалгасан сүүл холболтоор шүлэг гайхалтай хялбархан бичдэг иргэн Виже нартай та манайд уулзана аа. Иргэн Франсуа Үндэсний театрт одоо тавигдаж байгаа «Памелагаа» бидэнд уншиж өгсөн. Аргагүй л иргэн Франсуагийн бичсэн бусад зохиолын адил найруулга нь их уран, цэвэр дээ. Уярам жүжиг, бидний нулимсыг гаргасан шүү. Памелын дүрд залуу бүсгүй Ланж тоглох болсон юм гэсэнд Гамлен

— Хатагтай минь, таны саналыг бүрэн зөвшөөрч байна. Гэлээ ч Үндэсний театрыг үндэснийх гэхэд хангалтгүй байна. Лейагийн базаахгүй усан шүлгийн гутаасан тайзан дээр иргэн Франсуагийн бүтээл тавигдаж байгаа нь харамсалтай байна. «Хуулийн нөхөр» гутамшигтайгаар баларсныг хүн бүхэн санаж байна шүү дээ гэж өчвөл,

— Иргэн Гамлен, би Лейаг өмгөөлөх гээгүй, тэр миний найз ч биш гэж Рошмор хэлэв.

Бүхий л нөлөөгөө ашиглан Рошмор хатагтай олон хүний домоглож байсан тэр атаархам албанд Гамленыг тийм өр нимгэнтэйдээ ч оруулсан юм биш ээ. Энэ бүгдийг бүтээж өгснийхөө дараа ч, ахин бүтээгээд өгчхөж болох тохиолдолд ч тэрээр Францын дотоодод болон гадаадад захидал зөндөөг илгээдэг, ийм харилцаа нь тэр үед их сэжигтэй гэгдэж байсан учир эрт орой алин боловч шүүхэд дуудагдах хэрэг гарч болзошгүй тул тэнд дэмжлэгтэй болох, мөн Гамленаас эгнэгт нүүр тал олж авахыг горилж байсан юм.

— Иргэн та театрт үргэлж очдог уу? гэж хатагтай асуув.

Энэ үед залуу Бафиллаас ч гоо эр Анри тасалгаанаа орж ирлээ. Том гэгчийн хоёр гар буу бүсэндээ хавчуулжээ.

Тэрээр үзэсгэлэнт эмэгтэйн гарыг үнсэв.

Хатагтай түүнд хандан

— Энэ миний тус хүргэх санаатай Нийгмийг аюулаас хамгаалах хороон дээр өнжсөн нөгөө Эварист Гамлен шүү дээ. Гэтэл энэ надад баярлая гэж бодохгүй юм. Үүнийг жаахан зэмлээдхээч гэв.

— Ээ, та Тюильри дахь манай хууль тогтоогчидтой уулзсан юм уу! Ямар маанаг юм бэ! Чөлөөт ард түмний төлөөлөгчид дарангуйллын харшид хуралдаж байна гэдгийг хүлцэж болох уу? Капетын хуйвалдаан<sup>36</sup> хийж, Антуанетын садарлан наргиж байсан тэр дэнгийн

гэрэлд одоо манай хууль тогтоогчид шөнөд нь ажиллаж байдаг. Өвч байгаль үүнийг үзэхдээ цочиж байна гэж Анрийн дуу алдвал

— Найз минь, иргэн Гамленд баяр хүргэгтүн. Энэ хувьсгалт шүүхийн ардын төлөөлөгчөөр томилогдсон юм гэж хатагтай өгүүлэв.

— Иргэн, баяр хүргэе! Шүүхийн эрх мэдлийг атгасан чиний мэтийн зан чанартай хүнтэй уулзах завшаантай юм. Гэвч үнэнээ хэлэхэд Конвентын дундыг баригч этгээдийн байгуулсан чанд шүүхэд хуйвалдагчдыг дураар нь дургиулж, урваачдыг энэрэн өршөөж, федералчуудад шийдвэртэй цохилт өгөхөөс хулгаж өчгийг нь авахаар тэр австри хүүхнийг дуудахаасаа эмээгээд байгаа амарлингуй Немезидад\* төдийлөн итгэдэггүй билээ. Үгүй ээ, Хувьсгалт онц шүүх бүгд найрамдах улсыг аврахгүй! Биднийг цөхрөнгөө барсан байдалд байсаар атал ард түмний шүүх ажиллагааны аяндаа гарсан эрмэлзлийг дарсан тэдний хувьд хүндхэн ял ноогдох болно гэж Анри өгүүлэхэд Рошмор авгай

— Анри, алив тэр үнэртэй ус аваад өгөөч гэв.

Гамлен гэртээ ирвэл эх нь өвгөн Броттотой өөхөн дэнгийн гэрэлд хөзөр тоглон сууж байлаа. Авгай зовсон шинжгүй «ноёнтой өнгө харшин гурваар» явж байв.

Хүүгээ ардын төлөөлөгч болсон гэдгийг дуулаад тэрээр энэ бол тэр хоёрт том хувь заяа, одоогоос өдөр бүр гэдэс цатгалан байх биз гэж бодон түүнийг халуунаар тэврэв.

— Би ардын төлөөлөгчийн эх гэдэгтээ баярлаж бахархаж байна. Үнэний шүүхгүйгээр дорой буурай хүмүүс алхам бүрдээ хавчигдах байсан, үнэний шүүх гэдэг бол ертөнц дээрх хамгийн чухал, хамгийн сайхан зүйл. Эварист минь, хар багаасаа юм бүхэнд шударга, зөөлөн сэтгэлээр ханддаг байсан болохоороо чи сайн шүүгч болох биз гэж би итгэнэм. Чи шударга бус явдлыг тэвчиж чаддаггүй, эз дийлэхийг чадлынхаа хэрээр эсэргүүцдэг байсан. Чи заяа мөхөс хөөрхийсийг өрөвддөг байсан, харин шүүгч хүний чимэг бологч энэрэл л... Гэвч тэр Шүүх дээрээ ямар хувцас өмсөх вэ, надад хэлээч гэв.

Шүүгч нар хар өд хатгасан бүрх малгай өмсдөг боловч ардын төлөөлөгчдөд тусгай хувцас байдаггүй, тэд энгийн хувцастайгаа л хуралддаг юм гэж Гамлен тайлбарлав.

— Тэд жанч нөмөрч, хиймэл үс хийдэг бол зүгээр байсан юм. Энэ нь арай буурь суурьтай сүрлэг болгох байсан юм. Хааш яаш

хувцаслалаа ч гэсэн чи гоолиг, эд чамайг биш харин чи эдийг чимдэг нь ч үнэн л дээ. Гэвч ихэнх бүстэйчүүд хэрвээ ямарваа нэгэн сэтгэгдэл төрүүлье гэвэл биеэ тордох нь чухал байдаг, ардын төлөөлөгчид хиймэл үс, жанчтай л байсан бол зүгээр сэн хэмээн авгай татгалзав.

Шүүхийн ардын төлөөлөгчийн алба ямар нэг хөлстэй байдаг гэж сонссон тул тэсэж чадсангүй тохилогхон амьжирч болохуйц овоо цалин авах уу гэж асуугаад төлөөлөгч хүний аж байдал үүнийг шаардана шүү дээ гэж учирлав.


Төлөөлөгч нь нэг хуралдахад арван найман Ливрийн харамж авдаг, төрийн аюулгүй байдлын эсрэг үйлдэх гэмт хэрэг олширсноос үргэлж хуралдах ажил гардаг гэдгийг авгай сэтгэл ханамжтай чагнав.

Өвгөн Бротто хөзрөө цуглуулан ширээнээс босож Гамленд — Иргэн, танд сүрлэг бөгөөд өндөр эрх олгожээ. Баяр хүргэе. Аандаа л нэг биш гагцхүү илэрхий ашиг сонирхол, тодорхой сэтгэл санааг харгалзан сайн муу хоёрын мөн чанарыг ялгаж салгах гэж оролдож байгаа болохоор алив бусдаас арай итгэлтэй үйлчилж байж мэдэх Онц шүүхийн албанаа одоогоос ариун нэр төрөө зориулагтун. Ухаан мулгуу хүмүүсийн ялган таньж үл дөнгөх үнэн, төөрөгдөл хоёрын дунд биш харин хайрлал, жигшил хоёрын хооронд болдог зүйлийг л та шилж авах болно доо.

Ариун хууль тань болсон хүсэл эрмэлзэл дээрээ үндэслэх юм бол оноосон ял тань цаг ямагт зөв байх учраас сэтгэл зүрхний тэмүүлэлдээ захирагдвал та ташаарахгүй. Ер нь хэрвээ би таны дарга байсан сан бол Бридуа шиг л үргэлж асуудлыг шоо орхин шийдэх байсан. Үнэний шүүхийн ажилд энэ нь ямар ч болсон найдвартай арга гэв.

## IX

Тус бүрдээ арван таван ардын төлөөлөгчтэй дөрвөн секц болгон хуваасан Онц шүүхийг өөрчлөн байгуулах яг тэр үе болох есөн сарын арван дөрвөнд Эварист Гамлен үүрэгт ажилдаа орох ёстой байлаа. Шорон гяндан пиг дүүрэн, олон нийтийн яллагч хоногт арван найман цаг ажиллана. Арми ниргүүлж, хөдөөд бослого дэгдэж, хуйвалдаан гарч, нууц сүлбээ байгуулж урван тэрсэлж байгаагийн эсрэг Конвент хядлагыг сөргүүлэн тавилаа. Бурхад ундаасжээ.



Давын өмнө шинэ төлөөлөгч маань найрсаг харьцаа, эелдэг яриагаараа сэтгэлийг нь татсан Эрман даргад тал өгөхөөр очив. Робеспьертэй нэг нутаг усны бөгөөд үзэл санааг нь хуваалцагч анд нөхөр нь болох тэр хүн хараажаар, өр нимгэнтэй буянт хүн ажээ. Шүүгчийн сэтгэлд өнө удаанаар харшилж байсан Дюпати Беккария<sup>37</sup> хоёрын нэрийг цуунд гаргасан энэрэнгүй сэтгэл түүнд нэвт шингэжээ. Шүүхийн салбар бол жигшүүрт, хэрцгий цааз, эрүүдлэгийг өөрчилснөөр илрэх хэв хэвшил зөөлрөхөд тэрээр үнэхээрийн баярлана. Хэзээ ч тийм өргөн хэрэглэгдэж байгаагүй, саяхан болтол шалимгүй эндэгдлийг арилгах ердийн арга хэмжээ болж байсан хороох ял одоо бүр ч ховор үзэгдэл болж тийм ялыг гагц хүнд хэрэг хийхэд л зааж байгаа тухай сэтгэл хангалуун бодно. Тэрээр Робеспьерын адил нийгмийг аюулаас хамгаалахад л хамаагүй хэрэг бол ямар ч тохиолдолд түүнийг хэрэглэхээс дуртайяа татгалзах байлаа. Гэвч ард түмний дээд засгийн эсрэг ял хийсэн хэрэгтнийг алж гэсгээхгүй бол төрдөө тэрсэлсэн хэрэг гэж тооцох сон билээ.

Түүний бүх нөхөд сэлт яг тийм саналыг баримталдаг агаад Хувьсгалт шүүхийн үйл ажиллагааны үндэс төрийн сайн сайхны тухай хаант засгийн хуучин үзэл санаа болж бай. Хаант засгийн ноёрхож

байсан найман эрин энэ шүүгч нарт нөлөөгөө үзүүлж тэд бурхны эрх дархын зарчмаас үндэслэн эрх чөлөөний дайсныг шүүж байлаа.

Тэр өдөртөө Эварист Гамлен, олон нийтийн яллагч иргэн Фукьед бараалхахад цаадах нь нарийн бичгийнхээ даргын хамт ажилладаг албан өрөөндөө түүнийг хүлээж авав. Энэ бол лужир том бие, баргиа дуу, муурын нүдтэй хүн бөгөөд зэвхий даасан малийсан цоохор нүүр нь эрүүл агаарт биеийн хүчний ашигтай хөдөлмөр хийхийн тул төрсөн чийрэг хүмүүст бөглүү, суудлын ажил хортойгоор нөлөөлдгийг гэрчлэх ажээ. Хавтаст хэргүүдэд бунхлагдан даруулсан тэрээр, түүнийг дороо булшлах нь дээ гэж санагдам энэ их цаасан овоондоо үзтэл дуртай аж. Оюун ухааны мэдлэгийн хэмжээ нь албан ажлынхаа хүрээнээс үл халих, үүргэт биелүүлэх гэж махрагч ажилч түшмэд яаж ярих ёстой байна, яг тэгж ярина. Тэнхээ тамир орохын тулд уусан архи нь ханх тавих боловч болхивторхон яриа нь эв эрүүл учир архи нь толгойд нь жаахан ч гарсангүй дээ гэж санагдана.

Шүүхийн байрны жижиг өрөөнд тэрээр, хоёр ихэр төрүүлсэн залуу эхнэр, авга эгч Генриетта, зарц хүүхэн Пелажи нарын хамт сууна. Эл гурван эмэгтэйтэй цөмтэй эелдэг зөөлөн харьцана. Ер нь тэгээд энэ хүн тийм их ухаантай биш, элдэв шалдав юм хий боддоггүй, гэр бүлийн талаар тогтвортой гайхамшигтай ажилтан билээ.

Одоогийн шүүгч нар нь хуучин дэглэмийн шүүгчидтэй санал бодол арга барилаараа хачин адилаар Гамлен гутрангуй ажиглав. Тийм ээ, эд нар бол тэд мөн. Эрман нь урьд Артуа дахь тойргийн шүүхийн дэргэдэх прокурорын туслах, Фукье нь Шатлод прокурор байжээ. Тэд ердөө ч өөрчлөгдсөнгүй. Гэвч Эварист Гамлен, хувьсгал хүнийг цоо шинээр дахин төрүүлж чадна гэж итгэдэг юм.

Шүүхийн байшингаас үзмэрт өрөөгөөр дамжин гараад Гамлен, төрөл бүрийн бараа нямбайлан тавьсан хайрцгуудын өмнө саатав. Тено хэмээх эхнэрийн худалдаа хийж байгаа лангуун дээрх «Боолчлолын гинж», «Дарангуйллын тухай бичих гэж оролдсон минь», «Хатан хаадын гэмт хэрэг» зэрэг түүх улс төр, гүн ухааны хэд хэдэн зохиолыг эргүүлж үзлээ.

«Яг цагаа олж гарч! Бүгд найрамдах улсын зохиол ёстой мөн байна» гэж тэр бодоод худалдагчаас энэ номыг хэр авч байна хэмээн лавлавал Тено толгой сэгсрэн

— Зөвхөн дууны түүвэр, роман л гүйж байна гэлээ.

Тэгээд хайрцгаас жижигхэн боть ном гарган Гамленд үзүүлээд тэр

— Энэ сайхан ном шүү гэж хэлэв.

Гамлен «Цамцтай гэлэнмаа» гэж гарчгийг нь уншив.

Хажуугийн нь үнэртэй ус, оо, нусны алчуур хийх жижиг цүнх зардаг Сен - Жор гэдэг эмэгтэйн мухлагийн өмнө Филипп Деман зогсож байхыг Гамл-н харав. Дур булаам бөгөөд ялдамхан тэрээр голшиг худалдагч бүсгүйд хайр дуртай гэж батлан, хөргийг нь зурж өгнө гэж амлан Тюильрийн цэцэрлэгт өнөө орой уулзъя гэж шалгааж байлаа. Тэр сайхан хүн билээ. Гялалзах нүд, амнаас нь урсах үгс цөм үнэмшим ажээ. Сен - Жор бүсгүй дуугүйхэн чагнаж, түүний ятгалгад бараг автаад харцаа доош дарж байлаа.

Эдүгээгээс эрхлэх догшин үүрэгт ажилтайгаа ойр танилцахыг хүсэн шинээр томилогдсон төлөөлөгч Онц шүүхийн нэгэн хуралдаанд ажиглагчаар суухаар шийдэв. Дугуй театрт байгаа юм шиг тоймгүй олон хүн суусан шатаар Гамлен өгсөн Парисын парламентын эртний танхимд орлоо.

Тэнд нэгэн генералын хэрэг тасалж хөл ихтэй байв. Өвгөн Броттогийн ярьдагчлан тэр үед «Английн эрхэмсэг вангийн жишээгээр Конвент урвасан жанжинд нь баригдахааргүй хол байсан учир ялагдсан жанждыг хариуцлагад татжээ. Тэгээд ялагдсан жанжин яриагүй гэмт хэрэгтэн учраас ингэж байгаа юм биш, ер нь алив тулалдаанд нэг тал заавал ялагдал хүлээдэг шүү дээ. Гэвч нэгийг нь алах ял зааж жанждын дайчин сэтгэлийг сэргээхээс өөр сайн арга үгүй ээ» гэж Бротто нэмэрлэнэ.

Үхэр толгойтой, шувуун тархитай ийм гоомой гөжүүд амьтад тэр үед ялтны суудалд суусан нь цөөнгүй. Өнөөдөр түүн дээр суугч хүн өөрийн хийж явсан бүслэлт болон тулалдааныхаа тухай байцааж байгаа шүүгчээс дээрдэх юмгүй тайлбарлах хийгээд ялагч, өмгөөлөгч нар цэргийн тоо, байлдааны даалгавар, бэлтгэл төхөөрөмж, аялал, сөрөх аяны учрыг олохгүй будилж байлаа. Юу ч үл ойлгон эх адаггүй маргааныг ажиглагч түмний нүднээ, цэргийн энэ мулгуу эрийн ард дайсан халдан дайрахад нээлттэй болсон хэсэглүүлэн хуваалгаж байгаа цус бялдсан эх орон нь үзэгдэх шиг болох ба үзэгчид, бүгд найрамдах улсын дайсанд хүнд муна буулгах адил ял ноогдуулахыг тайван суух ардын төлөөлөгчдөөс нүд болон дуугаараа шахан шаардаж байлаа.

Эл өчүүхэн хүнээр төлөөлүүлэн, эх орныг тамлагч самуун, дарагдал гэдэг хоёр аймшигт мангаст цохилт өгөх ёстойг Эварист бүх

бие махбодоороо мэдэрч байв. Гэтэл үнэн хэрэг дээрээ цэргийн энэ хүн буруутай юу, буруугүй юу гэдгийг тодруулах хэрэгтэй байлаа.

Вандей дахин толгойгоо өндийлгөж, Тулон дайсанд дагаар орон, Рейны арми майнцын ялагчдад түрэгдэн ухарч Цезарийн хуаран руу татсан Умардын арми, дайсны эрчимтэй шахалтын дүнд эзэнт улсын цэрэг болон Валенсьеныг хэдийнээ байлдан дагуулсан англи, голландчуудад олзлогдож мэдэх энэ үед генералуудыг ялах буюу үхэж сургах нэг л зүйл чухаг байв. Умардын талд самгардсан шигээ газрын зураг дээр будилан байгаа дорой, мохоо энэ цэргийн оронцгийг харахдаа Гамлен «Эрлэгт нь тонилго» гэж бусдын хамт хашхирчихгүйн тул танхимаас шалавхан гарлаа.

Секцийн хурал дээр түүний дарга Оливье, Гамленыг албан тушаалд томилогдсонд баяр хүргэж эх орондоо андгай өргөх газар болон хувирсан хуучин варнавчуудын тахил өргөх газар шинэ төлөөлөгчийг хүн төрөлхтний төлөө хүний бүхий л сул талыг огоорно гэж тангараглуулав.

Гамлен гараа өргөн, Ле - Пельтегийн хөшөөний нөгөө талд, хуучин сүмийн нэгэн баганан дор баримлыг нь саяхан босгосон, эрх чөлөөний төлөө зовлонгоо эдэлсэн Маратын ариун сүнсийг барин андгайлав.

Алга таших нь дуулдсан авч бас гүнгэнэлдэх нь сонсогдлоо. Нижгэр хурал болов. Үүдэн дээр жад барьсан хэсэг секцийнхэн орилолдоно.

— Чөлөөт иргэдийн хурал дээр зэвсэглэж ирэх нь бүгд найрамдах улсын ёсонд огт нийцэхгүй гэж дарга хэлээд сүмийн агуулах байсан тасалгаанд зэвсгээ даруйхан хураахыг тушаав.

Ажиглах хорооны гишүүн сэргэлэн нүд, дарвагар уруултай бөгтөр иргэн Бовизаж индэр болж хувирсан улаан малгайгаар чимсэн тайт ширээн дээр гарч ирэн

— Генералууд биднээс урваж манай армиудыг дайсанд өгч байна. Эзэнт улсын цэрэг Перон, Сен - Кентеныг хүртэл мориор дайрч, арван дөрвөн мянган хүнтэйгээ бүслэгдсэн Тулоныг англичууд эзэллээ. Бүгд найрамдах улсын дайсан Конвентын дотор ч гэсэн хорон санаа агуулсаар байна. Нийслэлд австри хүүхнийг чөлөөлөх зорилго бүхий хуйвалдаан гэдэг тойм алджээ. Одоо Тамплиас оргосон Капетын хүүг Сен - Клууд баяр ёслолын байдалтай хүргэж хаан ширээг сэргээн түүнийг залах гэж байна гэсэн цуу гарлаа. Хүнсний бараа үнэд орж

цаасан тэмдэгтийн ханш буурсан нь манай орны зүрхэнд харийн төлөөлөгчдийн хийж байгаа явуулгын үр дүн бөгөөд энэ бүхэн бидний нүдэн дээр болж байна. Нийтийг аврахын төлөө хуйвалдагсад, урвагсдад хайр найргүй хандахыг иргэн ардын төлөөлөгчөөс би шаардаж байна гэж хэлэв.

Түүнийг индэр дээрээс бууж явахад хуралдагсдын дотроос «Хувьсгалт онц шүүх сөнөтүгэй! Дундыг баригчид сөнөтүгэй!» гэж хашхиралдах нь сонсогдлоо.

Тионвиллийн талбайн мужаан тарган улаан иргэн ахмад Дюпон индэр дээр гаран иргэн төлөөлөгчөөс асуух юм байна гэж мэдэгдээд бриссотинчуул болон бэлэвсэн авгай Капетыгийн талаар хэрхэх бодлоготой байгаа вэ? гэж Гамленаас лавлав.

Эварист, олны өмнө үг хэлж сураагүй болохоор зүрх алдав. Гэвч зэвүүцэл нь түүнийг зоригжууллаа. Тэрээр царайгаа цайлган босож бөглүү дуугаар,

— Би шүүгч. Хүн нэрээ, тогос өдөө гэдэг. Танд өгөх алив амлалт минь миний үүрэгт харш. Би шүүх дээр ярьж, түүний гадна амаа хамхих ёстой. Би таныг үүнээс хойш танихгүй. Би шүүгч, би дайсныг ч, нөхрөө ч мэдэхгүй байна гэв.

Шийдвэргүй, туйлбаргүй зүсэн бүрийн улс хуралд цугласан болохоор түүнд алга ташин баяр хүргэлээ. Гэвч иргэн ахмад Дюпон цөхөрсөнгүй, өөрийн нь санааширч байсан албан тушаалыг нь Гамлен эзэлчихсэнд өнгөрүүлж чадахгүй байлаа.

— Би ойлгож байна, түүгээр ч барахгүй иргэн төлөөлөгчийн ёсорхог зарчимч байдлыг сайшааж байна. Үүнийг эх оронч хүн гэлцдэг, тэгвэл бүгд найрамдах улсын дайсныг устгах гэж байгуулагдаад үнэн хэрэгтээ тэднийг өршөөх болсон Онц шүүхэд ажилд ороход сэтгэл зовох нь уу гэдгийг өөрөө сайн тунгааг. Шударга иргэн оролцохоосоо цээрлэх ёстой ажил хэрэг бий. Энэ Онц шүүхийн хэд хэдэн ардын төлөөлөгчид ялтангууд нь алтаар хээл цутгаж, Монтане дарга Корде бүсгүйн толгойг аврах гэж ов мэх зохиосон нь нотлогдоогүй юм гэж үү? хэмээн түүнийг хэлж барахад танхимаар нэг алга ташив.

Сүүлчийн ташилт таазанд хадан цуурайлж байхад индэр дээр иргэн Фортюне Трюбер гарч ирлээ. Сүүлийн саруудад тэр их туржээ. Царай нь цайсан тул улаан шанаа нь их л тод харагдах агаад зовхи нь улайн нүд нь шилэн юм шиг санагдана.

— Иргэд ээ гэж тэрээр сулхан, үл мэдэг давчидсан боловч гүн итгэлт хоолойгоор эхлээд

— Конвент, Нийгмийг аюулаас хамгаалах хороог сэжиглэхгүйгээр Хувьсгалт онц шүүхийг хардаж сэрдэж болохгүй. Хэрэгтний эрх ашгийн тулд заль мэх зохиосон дарга Монтанегийн нэрийг зааж иргэн Бовизаж бидний сэтгэлийг түгшүүллээ. Тэгвэл бидний санааг амраах гэж олон нийтийн яллагчийн мэдүүлгээр Монтанег тушаалаас нь огцруулан гянданд хийснийг яагаад дурссангүй өнгөрөв?... Юм бүхнийг хардан сэжиглэхгүйгээр нийтийг аврах талаар санаа тавьж болохгүй гэж үү? Авьяаслаг, сайн хүмүүс Конвентэд бүр ховордлоо гэж үү? Робеспьер, Кутон, Сен - Жюст нар цөм шударга бус улс уу? Та бүгдийн мэдэх, бүгд найрамдах улсын төлөө тулалдаж яваагүй хүмүүс л амны хэмжээгээр цуурч байгаа нь сонин. Бүгд найрамдах улсыг бүх нийтээр жигшүүлдэг болгох зорилго тавьсан бол тэд ингэж ярих ёстой биз! Иргэд ээ, бага шуугилдаж их ажиллая! Францыг хашхирч бархирснаас биш их буугаар л аварна. Манай секцийн зооринуудын тал хувийг нэгжээгүй байна. Олон иргэдэд ихээхэн хэмжээний хүрэл одоо болтол байсаар байна. Эх орончдын амиа өгч байгаа нь баячуулд сайн баталгаа болог гэдгийг тэдэнд сануулъя. Луарт болон хил дээр алдраа мандуулсан манай дайчдын эхнэр хүүхдийг та нарын өгөөмөр сэтгэлд даатгая.

Тэдний нэг торгон цэрэг, урьд Иерусалимын гудамж дахь агуулахын нярвын туслах байсан Помьег (Огюстеныг) өнгөрөгч сарын аравны өдөр Кондын хуарангаас холгүйхэн морьдоо услах гэж явахад нь австрийн зургаан морьтон довтолсонд тэрээр хоёрыг нь алаад бусдыг нь олзолжээ. Помье (Огюстен) үүргээ биелүүллээ гэж зарлахыг секцээс хүсье гэж хэлэв.

Түүний үгийг алга ташин угтаж «Бүгд найрамдах улс мандтугай!» гэж хашхиралдахад хурал тарлаа.

Гамлен сүмд Тюбертэй хоёулхнаа үлдээд түүний гарыг атган

— Чамд баярлалаа. Сайн сууж байна уу гэвээс

— Яриагүй, яриагүй! гээд нусныхаа алчуурт цусаар ханиалган, — Бүгд найрамдах улсад маань гадаад дотоодын дайсан зөндөө байна. Манай секцэд ч гэсэн мундахгүй бий. Хашхиралдсанаар биш зэвсэг, хуулиар улсыг байгуулдаг юм... За баяртай, Гамлен би бас хэдэн захиа явуулах ёстой юм сан гэж хариулав.

Тэгээд тэрээр нусныхаа алчуураар амаа таглан өрөө рүүгээ явлаа.

Оройвч малгайдаа тэмдгээ сайтар тогтоож хаддаг болсон Гамлен авгай өдөр ирэх тутам хөрөнгөтний ихэрхэг байдал, бүгд найрамдагч хүний бардам зан, ардын төлөөлөгчийн эхэд л зохих аятайхан намба олж авч байлаа. Өөрийн баримтлан хүмүүжсэн үнэний шүүхийг хүндлэх, шүүгчийн жанч, хөдрөгийг багаасаа бахдаж ирсэн. Бурхнаас газар дээр алах аврах эрх дарх заяасан хүмүүсийг харахдаа бахархан догдлох энэ бүх сэтгэл нь одоо хүртэл хүүхдээрээ шахууд тоолдог хүүгээ шүтэн бишрэхэд хүргэжээ. Конвентын хууль тогтоогчид улс төрийн байгуулал солигдож буйг хайхралгүй төрийн эрх үе залгамжлагддаг гэж итгэдгийн адил Гамлен авгай хувьсгал гарсан ч хамаагүй шүүхийн эрх үе улирдаг гэж цагаахан сэтгэлээсээ итгэдэг бөгөөд Хувьсгалт онц шүүх нь түүний гүнээ хүндэтгэн дассан урьдын шүүхийн байгууллага шиг сүр жавхлангаа бадруулж үзэгдэнэ.

Иргэн Бротто шинэ томилогдсон төлөөлөгчид гайхахын зэрэгцээ арга буюу хүндэтгэн хандана. Тэрээр, Гамлен авгайтай адилхан шүүхийн эрх мэдэл нь улс төрийн байгуулал солигдоход үл өөрчлөгдөнө гэж тооцох хийгээд эмгэнээс ондоо нь хуучин засгийн шүүхийг үзэн яддаг байсан шигээ хувьсгалт онц шүүхийг үзэж чаддаггүй билээ. Өөрийн бодсоноо ил хэлчхэж үл зүрхлэн бас дуугүй байж эс чадан тэрээр Гамленд энэ бол итгэлгүй хүн юм даа гэж сэжиглэгдэж ойлгогдохоор гаж юм ярина.

— Таны хуралдаанд нь мөдхөн оролцох Дээд Шүүхийг, бүгд найрамдах улсаа хамгаалах гэж францын сенат байгуулсан юм. Манай хуульчдын толгойд шүүгчдийг дайсандаа өгөх гэсэн сайхан бодол төрсөн нь маргаангүй. Тиймэрхүү маягийн үйл ажил, талбиун сэтгэлийг би ухварладаг боловч түүнийг алсын хараатай зүйл гэж үзэхгүй байна. Миний бодоход, яавч эвлэршгүй дайснуудаа далдуур дарж бусдыг нь хээл цутгах юм уу, ам өгөх замаар өөрийн талд татвал оновчтой мэт. Алив шүүх алгуурхан цохилт өгдөг, айлгаж байгаа шигээ гэмт хэрэгтнүүдийг дардаггүй, харин санамж өгөх зорилгыг эн түрүүн мөрдлөг болгодог. Танай шүүхийн эвгүй юм нь юу вэ гэвэл сүрдүүлж байж эсрэг тэсрэг ашиг сонирхол, хүсэл эрмэлзэл бүхий замбараагүй хүмүүсээс нягтармал, шийдвэртэй ажиллаж чадах хүчирхэг намыг байгуулаад айлгаж чадсан хун бүрээ бие биеэр нь хэмждэгт оршино. Тануус айлгаж сүрдүүлж байна, гэвч айдас гэдэг эр зоригоос ч илүү

баатруудыг төрүүлдэг юм. Иргэн Гамлен, айсны гавьяа таныг ч гэсэн бүү дайраасай гэж хүсье! хэмээн Бротто нэг удаа хэлжээ.

Энэ долоо хоногт Паде-Эгалитийн хар үстэй өндөр бүсгүй Флорад дурласан сийлбэрч Деман тийм өндөр тушаалд томилогдоно гэдэг бол урлагт их хүндтэй хэрэг гэж хэлэх, нөхөртөө баяр хүргэх зав ямар ч атугай гаргажээ.

Хувьсгалтай холбоотой зүйл бүрд яагаад ч юм жигшингүй ханддаг, олон нийтийн ажлыг янаг залуугийн нь зүрхийг эзэмдэж болох хамгийн аюултай өрсөлдөгч гэж үздэг Элоди, ялдамхан Элоди хүртэл тийм чухал ажлын шүүгч байх тавилантай хүн өөрөөс нь давуу болохыг ухварлаж байлаа. Түүнээс гадна Эваристын төлөөлөгч болсны ачаар уяхан бүсгүйг үнэхээр баярлуулсан нэгэн азтай явдал боллоо. Иргэн Жан Блез Тионвиллийн талбай дахь урлах өрөөнөө очиж эр хүн, эр хүнээ энхрийлдэг жамаар шинэ томилогдсон төлөөлөгчийг чанга гэгч тэвэрсэн ажээ. Бүх хувьсгалын эсэргүү нарын адил тэрээр бүгд найрамдах улсын эрх баригчдыг хүндэлдэг байсан бол армид ханган нийлүүлэхдээ луйвар хийлээ гэж яллах гэснээс хойш Хувьсгалт Онц шүүхээс зүрхээ авчихжээ. Амарлингуй суугаад байж болшгүй дэндүү олон ажил эрхэлж байгаа, хүний нүдэнд хэтэрхий өртөх хүн гэж тэрээр өөрийгөө тооцох ба иргэн Гамлен нь аргалбал зохих хүн мэт түүнд санагдана. Ер нь тэгээд ч Блез бол хууль зүйн талыг баримтлагч сайхан сэтгэлт иргэн билээ.

Тэрээр, зураач шүүгч рүү гараа сунган жинхэнэ эх оронч эрх чөлөө урлагийг бишрэгч болохоо харуулав. Гамлен зүрхний угаас сарвайсан гарыг уудам сэтгэлээр атгалаа.

— Иргэн Эварист Гамлен таны найзархаг сэтгэл, таны авьяас билигт ханднам. Маргааш таныг хоёр хоногоор тосгонд аваачъя, та тэнд зураг зур, тэгээд чөлөөтэй газар хоёул хууч хөөрөмз гэж Жан Блез өгүүлэв.

Жилд хэд хэдэн удаа хэвийн худалдаачин, заавраар нь байгалийн байдал, нурсан балгасны зураг зурдаг зураачидтай нийлэн хоёр гурван өдрөөр хотын зах руу зугаалга хийдэг билээ. Энэ явалтаараа тэрээр зон олонд таалагдах юм бүрийг хам хум аван ноорог хийж ажлынхаа газар ирж гүйцээгээд чамин гэгч барлан нэг өнгийн буюу өнгө ялгасан хэв болгодог нь түүнд чамгүй орлого оруулна. Энэ нооргоороо тэрээр худалдан авагчдын дунд Гюбер Роберын бүтээлээс ч багагүй зарим үед бол бүр илүү амжилт олдог хаалганы янз, хананы толь захиална.

Энэ удаад ардын төлөөлөгч цол Гамленыг уран зураачийн дайтай харагдуулсан учир Жан Блез түүгээр балгасны судалбар хийлгэхээр авч явах гэсэн юм санжээ. Гамленаас гадна барлагч бөгөөд сайн зураач Деман Роберын төсөл дээр гарамгай ажиллаж байгаа, хэний ч үл мэдэх Филипп Дюбуа нар зугаалгад оролцох ажээ. Урьдын адил Элоди хүүхэн үерхдэг бүсгүй Азарынхаа хамт зураачдыг дагалдах байв. Мөн аятайхныг ашигтайтай зохицуулж чаддаг Жан Блез «Инээдмийн шийн» жүжигчин эмэгтэй, өөртэй нь явдаг гэж дам ярилцдаг Тенененыг урьжээ.

## Х

Бямба гарагийн өглөөний долоон цагт буланг нь дээш нугалсан хар бүрх, улаан цээжмэг, хандгайн арьсан өмд, түрийг нь эргүүлсэн шар савхи өмссөн иргэн Блез Гамлены хаалгыг ташуурынхаа ишээр тогшив. Эварист хагархай толины өмнө цагаан зангиагаа зүүж байхад Гамлен авгай, иргэн Бротто хоёр намуухнаар яриа дэлгэн сууж байлаа.



— Ноён Блез, сайн явахыг ерөөе! Та байгаль зурахаар явж байгаа бол ноён Броттог дайгаад яваач, энэ бас л зураач хүн шүү дээ гэж Гамлен авгайг хэлбээс Жан Блез

— Маш сайн! Иргэн Бротто цуг явъя гэж хариу өгүүлэв.

Хэнд ч тээр болохгүй гэж итгэсний эцэст хүнтэй нийцтэй, алив зугаа цэнгэлд дуртай Бротто дуртайяа зөвшөөрөв. Элоди бүсгүй “ээж ээ” гэж дууддаг Гамлен авгайг үнсэхээр дөрвөн давхарт гарлаа. Тэрээр өвч цагаан хувцас өмсөж үнэртэн анхилуулна.

Хос морь хөллөсөн бүхээгийг нь буулгасан аян замын хуучин тэрэг талбай дээр тэднийг хүлээж байв. Роза Тевенен, Жюльена Азар хоёр ар талын суудал дээр суужээ. Элоди, жүжигчин хүүхнийг баруун талд суухыг гуйгаад өөрөө зүүн талд нь сууж турь муутай Жюльеныг дундаа оруулав. Бротто урд талын суудал дээр Тевенены өөдөөс харан тухалж Филипп Дюбуа, Азар бүсгүйн өмнөөс, Эварист Элодийн урдаас харан сууцгаалаа. Филипп Деман юу болов гэвэл түүний чилгэр бие улаачийн зүүн гар талын суудал дээр торойх бөгөөд тэрээр Америкт модонд нь хиам ургадаг орон бий гэж улаачид хачирхуулан ярьж байлаа.

Унаанд гаргууд иргэн Блез мориор тэднийг дагаж тэрэгний босгосон тоосонд булуулахгүйн тул түрүүлэн давхиж одов.

Тэрэг нь хээрийн замд гарах тусам аянчид ажил төрлөө огоорон нуга тал, ой мод, огторгуйг харахдаа баясгалантай тааламжтай

болцгоов. Эваристтайгаа байгалийн дунд голын хөвөөнд ойн зурааны ойролцоо насан туршаа ханилан суух сан. Өөрөө тахиа үржүүлнэ, Эварист нь хаа ч юм нэг тосгонд энгийн шүүгч хийнэ гэж Элоди санааширна. Замын дагуух хайлаас жирэлзэн өнгөрнө. Нэгэн сууринд орж ирвээс хашааны ноход тэргийг тосон боргоон давхиж морины хөлд орчих шахан, зам хөндөлсөн хэвтсэн том халтар нохой харууссан аятай өндийн, тахиа шувууд зүг зүг бутран нисэж амь гарахыг эрмэлзэн зам огтлон гүйлдэж хэсэг галуу бөөгнөрөөд яаралгүй холдоно. Халтар жаалууд тэргийг шохоорхон ширтэнэ. Тэнгэрт өчүүхэн ч үүлгүй, халуун өглөө боллоо. Ангасан газар хур бороо хүснэ. Тэд нар, Вильжюифын дэргэд тэрэгнээсээ бууцгаав. Жаахан яваад, Деман нь жимс зарж буй эхнэрээс интоор авч ундаассан бүсгүйчүүдийг дайлахаар одлоо. Худалдагч нь хөөрхөн хүүхэд байсан учир Деманг удтал алга болсонд Филипп Дюбуа

— Хүүе! Барбару! Барбару гэж түүнийг дуудав. Энэ хочоор нь найз нар нь ихэвчлэн дууддаг байсан юм.

Үзэн яддаг нэрээ сонссон зорчигчид чих тавин, цонх бүрээс хүмүүс цухуйв. Жимс зардаг эхнэрийнхээс гарч яваа хүдэр цээжин дээр нь намирч буй манжлагатай энгэрийг нь задгай тавьсан хантааз өмсөж интоортой сагс мөрөн дээрээ тавин таягийнхаа үзүүрт фракаа өлгөсөн шаавай хархүүг үзсэн санкюлотууд, зураачийг хуулиас гадуур гэж зарлагдсан жирондичтой андууран ёсорхсонгүй барин авч, хэрвээ өвгөн Бротто, Гамлен, гурван хүүхний баригдсан иргэнийг зураач Деман гэдэг, ёстой якобинч хүн гэж дуу нийлүүлэн батлаагүй сэн бол Демани дургүйцэн эсэргүүцэж буйг нь хайхралгүй захиргаа руу хүргэх байсан. Ямар ч болсон сэжигт этгээд итгэмжлэх бичгээ үзүүлэх хэрэг гарчээ. Тиймэрхүү юманд тун хайнгадуу Деман огт санаандгүй үнэмлэхээ биедээ авч явжээ. Үүний хүчээр л тосгоны эх орончдын гараас харин ч гайгүй ханцуйныхаа торон нударгаа л тастуулаад мултрав. Түүнийг юунаас ч илүү болгож тавьсан үндэсний гвардичууд одоо болохоор уучлахыг гуйн баяр ёслолын байдалтайгаар өргөн захиргаанд аваачъя гэж байлаа.

Суллагдаж Элоди, Роза, Жюльен гурвын дунд ороод явахдаа Деман өөрийн төдий л ойшоодоггүй, итгэл хөсөрдүүлнэ гэж хар санадаг Дюбуаг зулгаас зулайг нь хүртэл гашуунаар мушийн хараад

— Дюбуа, хэрвээ намайг дахиад Барбару гэж дуудах юм бол чинь би чамайг нойтон гартай, цайчихсан арьстай балиар үстэй тарган,

инээдмийн хүн Бриссо гэнэ шүү. Ард түмний дайсан үл бүтэх Бриссо чинь энэ байна гэдэгт хэн ч эргэлзэхгүй, чамайг үзээд айдас нь хүрч, жигшил нь төрсөн бүгд найрамдахчууд анхны шонд л өлгөчихнө... ойлгов уу? гэв.

Морио услаад ирсэн иргэн Блез энэ явдлын учрыг өөрөө оллоо гэж үнэмшүүлэвч хамаг хэрэг түүнгүйгээр ая зүй нь олдсон гэж цөм санаж байлаа.

Ахиад тэргэндээ сууцгаалаа. Замдаа Деман яг энэ Лонжюмогийн талд биеийн хэлбэр арьсныхаа өнгөөр мэлхийтэй төстэй авч түүнээс арай том, сарны хэд хэдэн амьтан дээр үед унасан юм гэнэ билээ хэмээн улаачид хуучлав. Филипп Дюбуа, Гамлен хоёр урлагийн тухай ярилцлаа. Реньогийн шавь Дюбуа Ром орж үзсэн ажээ. Тэр тэнд Рафаэлийн ханын зургийг үзсэн болохоор түүнийг уран зургийг шилдэг бүтээлийн дээд гэнэ. Корреджийн өнгө, Аннибал Карричийн уран санаа, Доменикины зургийг бахдах боловч Помпео Баттоны зурагтай арга барилаараа дүйцэх юм ер олж үзсэнгүй гэж байлаа. Ромд ноён Менажо, хатагтай Лебрэн нарынхаар орсон хэдий авч цаад хоёр нь хувьсгалыг дайсагнан үздэг учир тэдний тухай дурссангүй. Гэлээ ч сайх эр Анжелика Кауфманыг уран арга маягаар зурдаг өнө эртний үеийг мэддэг гэж шагшран магтана.

Хожуу, итали флагмандын сургуулийн уналттай зэрэгцэн дөнгөж Лесюэр, Клод Пуссен нарын үеэс эхэлсэн францын уран зургийн цэцэглэлт нь маш хурднаа тун доош буурсан тухай Гамлен харамсан ярив. Нийгмийн ёс суртахуун, түүний толь нь байсан гэж хэлж болох Академийг үүний гол шалтгаан гэж тэр үзэж байлаа. Гэвч аз болоход Академийг татан буулгаж одоо Давид ба түүний шавь нар шинэ зарчмын үндсэн дээр чөлөөт ард түмнийх байж чадахуйц урлагийг бүтээж байв. Ямар ч атаа жөтөөгүйгээр Гамлен, залуу зураачдын дотроос Геннекен, Топино - Лебренийг тэргүүн байранд тавина. Филипп Дюбуа, Давид ба багш Реньогоо эрхэмлэн, залуу Жерарыг орчин үеийн уран зургийн найдвар гэж тоолох ажээ. Элоди, Тевенены улаан хилэн малгай, цагаан бошинзыг шагширна. Жүжигчин хүүхэн хариуд нь хамт яваа хоёрынхоо хувцас хунарыг магтан яаж хувцаславал зүгээр болох тухай зөвлөгөө өгөх ба элдэв гоёл чимэг хэрэглэх нь хэрэггүй гэж боддог хэмээн ярив.

— Эгэл жирийн байхыг цаг ямагт эрмэлзэх хэрэгтэй. Тайзан дээр хувцас нь хөдөлгөөн бүрийг далдлах биш харин харагдуулах ёстой

болохоор бид үүнийг сурч байгаа билээ. Гоёлын сайхан нь үүндээ л байгаа юм, түүнд үүнээс өөр үзэмж хэрэггүй гэж түүнийг өгүүлбэл,  
— Хонгор минь, ёстой зөв. Энгийн байхаас сайхан юм алга. Бид аятай хувцаслаж сураагүйгээс элдэв гоёл хувцсандаа хийж байгаа биш заримдаа юмаа хэмнээд ч гэх юм уу даа ингэдэг юм гэж Элоди хариулав.

Тэд намрын маяг, бэлхүүсээрээ нарийхан хуниасгүй даашинзны тухай яриа дэлгэж эхлэв.

— Хэчнээн олон хүүхэн маягт захирагдан биеэ зэрэмдэглэж байна даа. Юуны урьд биеийнхээ хэлбэрт тохируулах нь зүйтэй шүү гэж Тевененыг хэлбээс

— Энгээр нь аваад нөмрөхөд хуниас нугалаас гардаг даавуу л сайхан. Эсгэж оёж хийсэн бүгд шал өөдгүй гэж Гамлен ярианд оролцов.

Парисын хүүхнүүдэд хандсан хүний амнаас гарснаас Винкельмены номд байсан нь арай зохистой энэ саналыг голж тоомсоргүй няцаалаа.

— Лапланд пальтог дуурайлгасан турк маягаар товчилдог цээжмэгтэй, флоранс буюу сицил, хасаг даавуугаар хийсэн хөвөнтэй пальтог өвөл өмсөх болно гэж Элодийн хэлэхэд,

— Энэ бол аятайхан хувцаслах боломжгүй хүмүүсийн ядарсан цагийн арга гэж жүжигчин эмэгтэй татгалзаад

— Үүнийг бэлэн хувцасны мухлагт зардаг юм. Надад гэрийн оёдолчин бий, ёстой алтан гартай хүн дээ, тэгээд хачин хямдхан оёхыг нь яана. Хонгор минь би түүнийг чам руу явууламз гэв.

Тэгээд тэд нимгэн нэхмэл, флоренцийн судалтай торго, гялгар торго, сиймхий борог даавуу зэргийг шилж сонгон хэлэлцэж дужигнуулан ярилцах ажээ.

Тэдний яриаг чагнан өвгөн Бротто, хээрийн цэцэг шиг эгнэгт сэргэн ургаж байдаг мөнхийн бус гоо цогцсыг чимэглэх хөнгөхөн, ийнхүү хурднаа солигдож буй бөс даавууны тухай сонин залхуутай авч аятайхан бодолд дарагдан явав. Түүний харц гурван залуу бүсгүйгээс, замын дагуу ургасан талын намуу, хонгор зул цэцэг рүү шилжиж сэтгэлд нь хөнгөхөн уйтгар төрөн нүдэнд нь нулимс цахилав.

Есөн цагийн алдад тэр Оранжид ирж Туатрин эр эм хоёрын унаатай, явган улсыг аль алийг нь хоноглуулдаг «Хонх» гуанзанд буудаллаа. Хэдийнээ хувцас хунараа цэвэрлэж нүүр гараа угааж

амжсан иргэн Блез, бүсгүйчүүлд тэрэгнээс гарахад нь туслав. Арван хоёр цагт үдийн хоол захиалаад тэд Сена мөрөн, ариун Женевьевийн ой хоёр талаар нь эмжсэн Лонжюмогийн ногоон тал нүднээ цэлийн үзэгддэг өв тэгш сайхан газар болох Орж, Ивет хоёр голын бэлчир тийш шууд тал дундуур явган явцгаахад тосгоны нэгэн жаал хайрцагтай будаг, хавтас, тавиур, шүхэр эн тэргүүтнийг аван түрүүлэв.

Газарчийн үүрэг хүлээсэн Жан Блез, хуучин санхүүч хоёр, тавиун сэтгэлт Вербок, Катерина, Гиссо зэрэг түгээгч бүсгүйчүүл, Шодроны охид, шидтэн Галише болон арай орчин үеийн баатрууд Каде Руссель, хатагтай Анго нарын нэрийг дооглонгуй цухас дурдан наргиантай яриа дэлгэж явлаа.

Тариа боож буй хадланчдыг харахдаа байгалийн байдалд сэтгэл гэнэт хөдөлсөн Эварист, нүдэндээ нулимс мэлтэлзэн ирэхийг мэдрэн, хотол олны хайр дурлал эв найрын тухай мөрөөдлөөр зүрх нь бялхав. Деман багваахай цэцгийн ноорсгийг хүүхнүүдийн үс рүү үлээнэ. Хотын ихэнх охидын адил тэд баглаа цэцэгт дурлах агаад ишээ тойрон түрүү мэт ургасан цэцэгтэй баавгайн чих цэнхэрхэн хонхон цэцэг, анхилам удын турьхан найлзуур, гандгарь, батраш, төлөгч өвс зэрэг зуны хуучдаар ургах хээрийн цэцэгсийг бултыг нь түүж эхэллээ. Жан - Жак ургамал судлалыг хотын хүүхнүүдийн нэг маяг болгосон болохоор тэр гурав цэцэг бүр хайр сэтгэлийн ямар бэлгэдэлтэй, мөн ямар нэртэйг андахгүй байлаа. Ган халуунд хатсан, булбарайхан цоморлог нь Элодийн гараас цацран хөлд нь унахад

— Ай, цэцэг хэдийнээ гандаж шүү! гээд санаа алдав.

Цугаараа ажилдаа орон өөр өөрийн тусгаж авч байгаагаар байгалийг дүрслэхийг чармайх авч аль нэгэн уран чадвартны бүтээл нөлөөлсний хэмжээгээр түүнийг ойлгоно. Филипп Дюбуа нь Гюбер Роберийн зурдаг маягаар эзэнгүй ферм, тайрсан мод, ширгэсэн горхины дүрсийг ноороглоно. Эварист Гамлен, Иветын эрэг дээр Пуссены байгалийн байдлыг олов. Филипп Деман тагтааны хонуур сонгон авч Калло Дюплессийн хошин сэдвээр татаж байлаа. Фламандчуудыг дуурайдаг гэж өөрийгөө тооцдог өвгөн Бротт нэг үнээг хичээнгүйлэн зурна. Элоди овоохойны зургийг ноороглож будгийн наймаачны охин найз Жлюьен нь түүнд будгийг нь шилэн өгч байв. Хүүхдүүд Элодийг бүчин зурахыг нь харна. Гэрлийг нь хэт халхалбаас тэрээр, ялаа батгана шиг шаваад хэмээн өгүүлсээр тэднийг хөндийрүүлэн мөсөн чихрээр зочилно. Тевенен хүүхдийн дотроос

хөөрхний нь эрж нүүрийг нь угаан үнсэн, үсэнд нь цэцэг хатгаж байлаа. Уран гоё хөдөлгөөний урлагаар сургуулилахтай тэнцэх ялдам сэтгэлээр биеэ чимэхийн тул, мөн түүнд эх хүний баяр баясгаланг амсах хувь ноогдоогүйн улмаас тэрээр тэднийг гунигтайяа энхрийлэх ажээ.

Роза л ганцаархнаа будгаар ч тэр, харандаагаар ч тэр зураг зурсангүй. Тевенен ролио цээжлэх, мөн үүнээс илүү орчныхоо хүмүүст таалагдах ажилтай байлаа. Хөнгөн шингэн, хосгүй гоо тэрээр дэвтэр барин нэгээс нөгөө рүү очно. «Царайн өнгө ч, хэлбэр ч, галбир ч, хоолой ч үгүй хүн» гэж хүүхнүүд түүний тухай жиг жуг гэлцэх агаад тэрээр уран хөдөлгөөн, будаг зэргээр байхгүйгээ орлуулах бүлгээ. Харимал, нүдэнд дулаахан, алжаангуй, цөхөршгүй тэр хүүхэн хотол зоны баяр хөөр, гоёл чимэг нь байлаа. Овилгогүй боловч үргэлж баясгалантай, гомдомтгой, түргэдүү зантай атлаа аманцар, хүнтэй нийцтэй, айхтар хэл амтай, тэгсэн мөртөө хачин найрсаг, ихэрхүү, даруу шударга, хуурамч, хайр булаам энэ бүх чанарыг өөртөө агуулсан Роза Тевенен ажил төрлөө зүгшрүүлж бардаггүй дагина болж чаддаггүйн шалтгаан нь Парист шүтээний өрөө ч, Грацийн хүжис ч хэдийнээ үгүй болсон бэрх цаг ирснээр тайлбарлагдана. Түүний тухай ярвагархан ярьдаг түүнийг «хойд эх» гэж нэрлэдэг Блез бүсгүй ч түүнд сэтгэл татагдахгүй байж чадсангүй.

Фейдо театрт «Визитандин бүсгүйчүүлийг» сургуулилж байхад Роза төрөлх байдал голчлох рольд тоглох болно гэж олзуурхаж байлаа. Тэрээр хэвийн байдалтай байх гэж эрмэлзээд санасандаа хүрч түүнийг олж авч байлаа.

— Тэгэхлээр, бид «Памелаг» ч үзэхээ өнгөрөө юу? гэж гоо Деман магадлав.

Үндэсний театрыг хаагаад эрэгтэй эмэгтэй жүжигчдийг номхроох байшин, Пелажийн шоронд хорьж байлаа.

— Үүнийг эрх чөлөө гэдэг юм уу? гэж сайхан хөх нүдээрээ огторгуйг ширтэн Роза Тевенен эгдүүцэн дуу алдав.

— Үндэсний театрын жүжигчид цугаараа язгууртан. Иргэн Франсуагийн жүжиг нь тайж нарын алдсан эрх ямбанд харамсах сэтгэлийг үзэгчдэд төрүүлэхийг хичээж байгаа юм гэж Гамленыг хэлбэл

— Ноёд оо, тануус өөрсдийгөө зулгуйдагсдын л тоглолтыг үзэхийг зөвшөөрөх юм гэж үү? хэмээн Роза Тевенен зэвүүрхэв.

Үд тийшээ цөмөөрөө өлсөцгөөн зуушны газар очихоор шийдэцгээлээ.

Эварист, Элодитай зэрэгцэн явахдаа анх учирснаа инээмсэглэнхэн дурсав.

— Дээвэр доорх үүрнээс хоёр ангаахай таны цонхны тавцан дээр ойчжээ. Та тэднийг авч тэжээсэнд нэг нь амьд үлдээд нисэж одсонб Нөгөө нь таны хийж өгсөн хөвөн үүрэндээ үхчихсэн гэдэг «Түүнд нь би илүү хайртай байсан юм» гэж та ярьж билээ. Тэр өдөр, Элоди та үсэндээ улаан тууз цацаглан зангидсан байсан гэв.

Филипп Дюбуа, Бротто хоёр нөхдөөсөө сүүлдээд Ромд нэг нь далан хоёр онд, нөгөө нь Академийн оршин байсан эцсийн өдрүүдэд тус тус очиж үзсэнээ ярилцав. Өвгөн Бротто хэрвээ сүүдэр мэт дагаад салж өгөөгүй Альтери гүн байгаагүй сэн бол хайр сэтгэлээ дуртайяа нээх байсан ноёнтон Мондрагоны тухай дурсав. Филипп Дюбуа, ертөнц дээрх хамгийн зочломтгой эзэн болох Кардинал де Берний зоогт уригдсанаа хэлчих далимыг алдсангүй.

— Би түүнийг танина аа. Есөн жорын амьтантай харилцахдаа тэр дуртай учир би түүнтэй нэг үе маш дотно явлаа гэж (сайрхаж байгаа ч юм биш) хэлж чадах байна. Нүдэнд үзэгдэж чихэнд сонсогдоогүй юмны тухай ярих дуртай боловч тэр их л эелдэг хүн, манийг буянтан сүжигтэн болгохыг мэрийгч танай усан толгойт якобинчууд түүний чигчий хуруунд нь ч хүрэхгүй ээ. Бидний толгойг хичээнгүйлэн авч, ийм замаар манийг буянтан мэргэд болгон, өөрийн дүр төрхөөр тэднийг бий болгогч далдын хүчинд биднийг бишрүүлэхийг эрмэлзэгч, хууль тогтоохын дон туссан бүдүүлэг амьтнаас хэлж байгаагаа ч, хийж байгаагаа ч аль алийг нь ойлгодоггүй энгийн «бурхны номлогчдыг» би дээрд үзнэ. Цагийн сайханд дез - Иллет сүмд маань мөргөл үйлддэг байсан нэг хөөрхий лам жаахан юм балгачихлаараа л «Нүгэлтнүүдийг буруушаах явдалгүй, тааруухан лам нар бид тэдний ач үрээр л хоолоо олж идэж байна шүү» гэдэг байж билээ. Ноёнтон минь ардын төлөөлөгч энэ мөргөлчин засгийн тухай зөвөөр ойлгож байсан гэдэгт итгэ. Үүнийг баримтлан, хүмүүсийг тийм байгаасай гэж хүсэж байгаагаар нь биш, харин энэ л байгаа чигээр нь удирдвал зохих юм гэж Бротто өгүүлэв.

Роза Тевенен, Бротто өвгөн рүү хүрч ирэв. Өвгөнийг нэг үе нэн ч бэлтэй аж төрж байсныг Роза мэдэх бөгөөд үгүйтэй хоосон байдал нийтийг хамарсан болохоор тийм ч доромжлолтой юм шиг санагдахгүй

байгаа одоогийн нь ядуу зүдүү байдлыг халхлан санхүүчийн урьд гялалзаж явсан үе нь хүүхний нүдэнд үзэгдэх мэт болов. Сайх эмэгтэй хүндэтгэхээ умарталгүй, хижээл жүжигчин хүүхнүүдийн сүүрс алданхан шагшдаг гар султай крезчүүлийн үеийн амьд төлөөлөгчийг үзсэн мэт түүнийг шохоорхон ширтэв. Түүнээс гадна хуучирсан боловч аятайхан хүрэн сюртуктэй энэ өвгөний ааш араншин түүнд таалагджээ.

Тэрээр ам нээн

— Ноён Бротто, шөнийн гэрлэн чимэг гийгүүлэн байх сайхан цэцэрлэгтээ холоос сонстох лимбэ хийлийн эгшигт мөнх ногоон шугуйгаар жүжигчин бүжигч бүсгүйчүүлтэй зугаалан байсны тань цөм андахгүй. Ээх, Франсезийн дуурь инээдмийн жүжигт тоглодог таны дагинас ардын өчүүхэн жүжигчид манаас үзэсгэлэн гоо байсан гэдэг үнэн биз дээ? гэсэнд Бротто

— Та андуурч байна, хатагтай минь. Хэрвээ тэр цагт тан шиг эмэгтэй надтай учраад үүнийг хүссэн сэн бол зөвхөн тэр л ганцаараа, таны хэтрүүлэн төсөөлж байгаа цэцэрлэгийн бүрэн эрхт эзэгтэй нь болон зугаалах байсан сан... гэж өчив.

Хонх гуанз бүр хөдөөгийн байдалтай ажээ. Тахиа шувууны хутгалдаж байдаг шалбааг нь хатаж үзээгүй хашааны дааман дээр өргөсөн навчит модны мөчир өлгөжээ. Хашааны буланд, цэцэглэж буй сарнайн том бутан дунд, хөвд ургасан вааран дээвэртэй жижигхэн давхар байшин байв. Баруунтай нь цэцэрлэгийн намхан хашааны цаанаас намхан моддын шовх орой ёрдойно. Зүүнтэй нь гаднаа өвсний сараалжтай агтын жүчээ, банзан ташаалавчтай пин байх ажээ. Тэнд саравчинд орвонгоор нь булга татсан хожуул, хөдөө аж ахуйн багаж овоолсон агаад хуучирсан хасаг тэргэн дээрээс цагаан азарган тахиа сүргээ харуулдана. Хашааны үзүүрт байгаа пүнзний өмнө бөөгнүүлсэн, хиргисүүр булш адил өтөг бууцыг инээд хүрэм шар үстэй, эв хавгүй бүдүүн биетэй залуу хүүхэн сэрээгээр хаяж байлаа. Нүцгэн хөлдөө угласан чархи шаахайд нь нялцгай шивх дүүрч, гүргэм мэт шар өсгий нь үе үе бултайн гарч ирнэ. Шуусан банзал дороос нь халтартсан булиа бөгөөд шалхайн унжсан булчин нь үзэгдэнэ. Байгаль, өндрөөшөө биш өргөөш нь бүдүүрүүлэн эл бүсгүйгээр жигтэйхэн наадам хийснийг гайхан сонирхсон Филипп Деман түүнийг шохоорхон харав. Энэ үед эзэн нь

— Хүүе, Колода! Усанд яваадхаач! гэж дуудлаа.

Тэрээр эргэв. Түүний царай улаан, ам том хийгээд үүдэн шүд нь эмсгий ажээ. Энэ мангар шүдийг цөм цохъё гэвэл наад зах нь бухын эвэр хэрэгтэй биз дээ. Сэрээгээ мөрөн дээрээ тавиад тэр инээмсэглэв. Тохойгоо өнгөртөл ханцуйгаа шамласан учир гуя мэт шуу нь нарнаа гялалзах аж.

Намхан өрөөнөө ширээ засаж, хуучны буунууд өлгөсөн бүрхүүлтэй зуухан дээр тахианы мах шарж байлаа. Хорь гаруй фут урт шохойдсон тасалгааны хаалган дахь ногоовтор шил, утас ээрэн суугаа чавганцын дэргэдэх сарнай цэцгээр хөвөөлсөн цорын ганц цонх хоёроор л гэрэл нэвтэрнэ. Бүр Регентлагийн үеийн<sup>38</sup> торон малгай болон оройвч өмсжээ. Өнгө нь үхсэн мойног хуруундаа ёрог даавуу барьжээ. Тэрээр нүдэндээ шавсан батганыг ч үл үргээнэ. XIV Людовик хаан сүйх тэргээр морилон явахыг тэр бүр нялх байхдаа эхийнхээ өвөр дээрээс харсан гэдэг.

Жаран жилийн тэртээ тэр Парис орж үзсэн ажээ. Тэрээр, хотын захиргааны байшин, Тюильри «Самар бүсгүй» оргилуурыг үзсэн, мөн Вангийн гүүрээр гарч явахдаа, Майлийн зах руу алим хүргэж явсан ачааны онгоцонд нүх гарч хамаг алим нь ус руу асгаран Сена мөрөн тэр аяараа ув улаан болсон зэргийг өмнөө зогсоо гурван залуу хүүхэнд уянгалаг дорой дуугаар хуучилж байлаа.

Вант улсад болсон өөрчлөлт, тангараг өргөсөн, өргөхөө татгалзсан лам нарын хооронд гарсан хагарлыг тэрээр мэдсэн ажээ. Дайн дажин дэгдэж өлсгөлөн гачаал гарч тэнгэрт муу тэмдэг үзэгдсэн тухай ч бас сонсжээ. Харин ванг цаазаар авсан гэдгийг ер итгэж өгөхгүй байлаа. Газар доорх хонгилоор ванг зугтахад нь тусалсан учир түүний оронд нэгэн харц хүнийг зандалчинд өгсөн гэж чавганц батална.

Эмгэний хөлийн тушаах сүлжмэл сагсанд Туатрины гэр бүлийн хамгийн отгон гишүүн, дөнгөж цахиур нь цухуйж буй хөхүүл жаал Жанна байх аж. Роза Тевенен уд модон өлгийг аван инээмсэглэхэд халууран татвалзах өвчин тусан мяраа нь шуугдсан жаал сулхан уйлагнав. Түүнийг үзүүлэхээр эмч дуудсан болохоор жаал нь хүнд өвдсөн бололтой. Конвентын орлогч депутат иргэн Пельпор үзсэний хөлс авдаггүй байсан нь нээрээ ажээ.

Юм юманд авхаалжтай Тевенен хаа ч тэр гэртээ байгаа юм шиг байна. Колодийн сав суулга угаах сэтгэлд нь таараагүй тул тэрээр аяга, таваг сэрээг дахин арчиж зүлгэж гарав. Сайн эзэгтэйн зангаар үе үе амтыг нь үзсээр Пуатрын авгайн шөлөө чанаж байх хооронд Элоди

дөнгөж сая зуухнаас гаргасан дөрвөн фунгийн халуун талх зүсэж байлаа. Гамлен, Элодийгоо ийм ажил хийж байгааг нь хараад

— Ойрмогхон би нэг залуу герман хүний бичсэн номыг маш сайн францчилсаныг уншлаа. Зохиогчийн нь нэрийг мартчихжээ. Тэр номд Элоди, яг л тан шиг Шарлотта хэмээх нэг хосгүй бүсгүй, яг тан шиг энхрий уян хөдлөн талх зүсэж байгааг Вертер гэдэг залуу хараад дурлачихсан тухай гардаг гэж хэлэхэд нь

— Тэгээд гэр бүл болоод төгсөж байна уу? хэмээн Элодийн асуувал

— Үгүй ээ, Вертерийн амиа хорлож байгаагаар дуусдаг юм гэв.

Цугаараа өлссөн болохоор амтархан хооллов. Хоол тун хомсхон байлаа. Нарийн хоолонд дуртай Жан Блез сайн хоолыг амьдралдаа баримталдаг нэг ёсоо болгосон болохоор сэтгэл дундхан хоцров. Түүнийг гэдэсний хэмжээгээр чихдэг болгосон юм нь нийтийн өлсгөлөнгөөс өөр юу ч биш гэдэг нь эргэлзээгүй ээ. Хувьсгалын салхи айл бүрийн голомтын галыг бөхөөжээ. Олонх иргэдэд талхны ч үйрмэг байсангүй. Ард олны гамшиг зовлонгоос ашиг хонжоо ологч Жан Блез мэтийн самбаатай хүмүүс гуанзны эрхлэгчдийнхээр хэсэн амаараа гартал ховдоглон идэж тараа таниулж байлаа. Эрх чөлөөний хоёр дахь жилд туулайн бөөр, хатаасан талх хоёр л идэж байгаа Бротто яав аа гэвэл тэрээр, Елисейн талд очих болгонд нь Гримо де Ла Рейньерын барьдаг байсан зоогийн тухай дурсан сэтгэлээ зогооно. Хүнсний талаар мэдэц ихтэйгээ гайхуулахыг хүсэн Бротто, Пуатрин авгайн тосонд жигнэсэн байцайны өмнө суун, хоол бэлдэх ярвигтай жор, элдэв идээг хийх нарийн зааврын талаар урсган ярих ажээ. Гамлены бүгд найрамдагч хүн хэтрүүлж идэхийг жигших хэрэгтэй гэсэнд дээр үеийн юмыг сайн мэддэг өвгөн, спарт нутгийн залууд хар шөл хийх найрлагыг яг хэлэв.

Хоолны дараа ажил хэргээ хэрхэвч үл огоорох Жан Блез хэрмэл академидаа эл хуль байхдаа нэлээд сонин үзэгдэх гуанзыг зур гэлээ. Филипп Деман, Филипп Дюбуа хоёрыг пүнз зурж байтал Колода гахайн тэжээл тавьж өгөхөөр ирэв. Пельпор эмч, Пуатрины голомтыг залгамжлах хүүг дөнгөж сая үзэж дуусаад байшингаас гарч зурагчид дээр очин тэднийг бүх үндэстний бахархал мөн хэмээн билэг авьяасыг нь магтсанаа гахайтай ноцолдож буй Колодийг заан

— Энэ амьтныг хараач. Бидний төсөөлж байгаа шиг энэ бол нэг хүн биш, харин бүхэл бүтэн хоёр хүн байгаа юм. Ойлгож ав, би үнэн

юм ярьж байна. Түүний биеийн зүйрлэшгүй томд гайхан би шинжилж үзээд ихэнх яс нь хос юм гэдэгт үнэмшсэн билээ. Гуя тус бүрд нь авцалдсан хоёр шаант чөмөг мөр бүрд хос мөрний яс байсан. Булчин нь хүртэл хоёр хоёр юм. Бие биетэйгээ маш нарийн наалдсан, өөрөөр хэлбэл нэг болон ургасан ихэр байсан байх гэж би санадаг. Сонин тохиол шүү. Энэ тухай ноён Сент - Илерт уламжлахад тэр надад их талархсан юм сан. Иргэд ээ, та нарын өмнө эрэмдэг хүн байна. Эзэд нь түүнийг Колода гэж дууддаг. Ёсоороо бол ганц биш хоёр хүн болохоор Колодуудаа гэвэл таарах юм. Байгальд сонин юм алийг тэр гэх вэ... Иргэн зураачид аа, сайхан амраарай. Шөнө тийшээ аадар орох байх аа даа... гэлээ.

Лааны гэрэлд Блезийнхэн хоол идээд гуанзны хашаанд Пуатрины хүү охин хоёртой муур хулгана болж тоглоход залуус, маргаашдаа итгэхээ больсон, бэрх цаг ирснээр л тайлбарлахгүй юм бол гал халуун насных гэж зохих ёсоор хэлж болох цовоо сэргэлэн наадав. Тас харанхуй болмогц Жан Блез хоолны өрөөнд дэнчин тавьж тоглоцгооё гэдэг санал гаргасанд Элоди «зүрх агнаж» наадья гэвээс цөм зөвшөөрцгөөв. Бротто өвгөн хүртэл тоглоомд дуртайяа оролцъё гэсэн тул залуу бүсгүйн заавраар Филипп Деман шүүгээ, хаалга, ханан дээр долоо, өөрөөр хэлбэл тоглогсдын тооноос нэгээр дутуу зүрх зурав. «Ла - Тур болгоомжил» гэдэг дууг аялан тойрон бүжиж байснаа Элодийн дохиогоор шохойгоор зурсан зүрхэнд гараа хүргэх гэж яарцгаав. Үүлгэрдүү самбаа муутай Гамлен хожимдож бүх зүрх эзэнтэй болчихсон байв. Тэрээр барьцаанд Сен - Жермений яармаг дээрээс зургаан сүүгээр авсан, Дюмонтейль авгайд талх зүсэж өгсөн нөгөө эвхмэл тонгоргоо өгөв. Тоглоомоо дахин эхэлж Блез, Элоди, Бротто, Роза Тевенен нар сул зүрх олж чадалгүй торгуульд бөгж, гар цүнх, савхин гадарт ном, бугуйвчаа тус тус өгцгөөлөө. Элодийн өвдгөн дээрээ тавьсан дтнчингүүдийг аз туршин сугалж эхлэв. Гэхдээ тоглоомд оролцогч бүр дуу дуулах буюу шүлэг хэлэн ямар нэг авьяас үзүүлж байж юмаа эргүүлж авах ёстой байлаа. Бротто «Орлеаны ариун бүсгүйн» эхний дуунаас Францыг ивээн тэтгэгчийн үгийг аялгуулан уншив.

*Галдийг<sup>39</sup> хайрлан гэгээрүүлэх*

*Гэгээн ажил эрхэлсэн*

*Денис гэдэг чинь би шүү*

Хэдийгээр иргэн Блез боловсролоор тэднээс нимгэн авч  
Ричмондын хариуг түгдрэлгүй хэлэв.

*Үлэмжийн сайхан гэрээ орхих гэж, та  
Үнэхээр дэмий юм бодсон шиг санагднам...*

Тэр үед бүгдээрээ францын Ариостын<sup>40</sup> сод зохиолыг дахин дахин  
уншиж, хамгийн төлөв хүмүүс ч Жанна, Дюнуагийн амрагийн явдлыг,  
Агнесса Монроз нарын адал явдлыг, далавчит илжигний гавьяаг  
шоолон инээж байсан юм. Гүн ухааны энэ наргиантай найраглалын  
шилдэг хэсгийг боловсролтой хүн бүр цээжээр мэдэж байв. Эварист  
Гамлен Элодийн өвдөг дээрээс тонгоргоо аван Грибурдоны тамд  
унасан хэсгийг дуртайя уншив. Тевенен, хөгжимгүйгээр «Хайртыгаа  
ирэхэд» гэдэг Нинагийн романсаар ая барьж, Деман «Фаридондены»  
аяар

*Хар ламын хувцсыг  
Гахайд сандраад өмсгөчихсөн чинь  
(Гэгээн Антоний, таныхад биш биз)  
Хоншоороо юүдэнд нь нуучхаад  
Хилэнцэтний тухай чарлана*

гэж дуулав.

Гэвч Деман бодолд оржээ. Энэ үед тэрээр дэнчин тавьж тоглосон  
гурван хүүхэндээ гурвуулд нь учиргүй дурлачхаад цөмд нь цогтой  
энхрий харц шидэж байлаа. Роза Тевенены уян налархай, гоо  
хөдөлгөөн, уран чадвар, зүрхнээ хоногшсон хоолой, учиртай харц нь  
түүнд таалагдсан бол Элодийг баялаг, өгөөмөр, дур булаам хүн гэж  
үзээд таашааж байлаа. Жюльена Азар цайвар хөмсөг, өнгө нь гутсан  
үс, сэвх, шалчгар мээмтэй хэдий боловч түүнд тоогдож байсны учир нь  
Вольтерын «Орлеаны ариун бүсгүй» дээ дүрсэлсэн Дюнуа лугаа адил,  
Деман нь царай муутай хүүхэнд хайр дурлалаа уужим сэтгэлээсээ  
өгөхөд бэлхэн байсан хийгээд бас тэгээд ч цаадах нь одоо сул, түүнд  
олдож мэднэ хэмээн санасных юм санжээ. Ихэрхэг зан огт үгүй тэрээр,  
тэрхүү улиг домог болсон зүйлийг нь элэгсгээр хүлээж авна гэдэгт  
ердөө ч найддаггүй боловч, бас бүтэхгүй дээ гэх үндэсгүй гэж итгэнэ.  
Иймээс ч тэрээр ямар ч болсон хэлээд алддаг билээ. Дэнчингээ авах  
үедээ аятайхан далимыг ашиглан Деман хэдэн энхрий үг Роза

Тевененд шивнэсэнд цаадах нь уурласангүй авч иргэн Блез хардамтгай харцаа түүнээс эс салгах учир юу ч хариулж чадсангүй. Элодийг Гамленд хайртай гэдгийг тэрээр мэдсээр байгаад уул бүсгүйд сэтгэлээ бүр ч их халуунаар нээсэн боловч өөрийнх нь л байвал зохих тэр зүрхийг эзэмшинэ гэж тэгж их улайрсангүй. Элоди түүнд дурлаагүй хэдий гэлээ ч түүнийг цэвэрхэнд тоолж буйгаа нууж чадсангүй болно. Харин Азар бүсгүйн чихнээ хүслийнхээ тухай Деман хамгийн шаргуу өгүүлбээс хүүхэн маш хүлцэнгүй бөгөөд нэн хайхрамжгүй байдлыг илтгэх гайхсан харцаар түүнийг ширтэж билээ. Гэвч Деман, түүний хайхрамжгүй байна гэдэгт үнэмшсэнгүй.

Гуанз уртаашаа хоёрхон унтлагын өрөөтэй ба тэр нь хоёулаа дээд давхарт нэг дор байдаг ажээ. Зүүн талынх нь цэцгэн хуартай цаасаар доторлосон арай үзэмжтэй тасалгааны нэг хананд XV Людовикийн балчир ахуй цагаас хойш ялаа батгана баасан, алтан хүрээтэй алгын чинээ толь өлгөөстэй байв. Тэнд навчин хээтэй эрээн даавуу хөшиг дээгүүр нь татсан, хаваастай хөнжлөөр бүтээсэн хоёр орон дээр жинтүү, өдөн дэр хөглөрүүлэн овоолжээ. Энэ өрөөг гурван хүүхэнд гаргаж өглөө.

Унтах цаг болоход нэг, нэг лааны тосгуур барьсан Деман, Азар хоёр үүдний чөлөөнд бие биедээ тавтай нойрсохыг ерөөв. Дурласан барч хүмүүсийг унтмагц бүсгүйчүүдийн өрөөний дээр байгаа дээврийн хөндийд очихыг гуйсан зурвас будгийн худалдаачны охинд атгуулав.

Хянамгай, сэхээтэй залуу бүр өдрөөр байшингийн дотоод байршлыг нэгд нэггүй үзэн, авдар, хуучин чемодан, шар зөгий дээр нь шавсан хатааж буй жимс, хэлхээтэй сонгино новширсон тэр хөндийг шинжсэн байлаа. Хэн ч унтдаггүй байрын доголлон эвхдэг ор болон нохой бөөс чөлөөтэй үсрэлдэх ханзархай дэвсгэр байхыг ажиглажээ.

Хүүхнүүдийн өрөөний өмнө талд жуулчдад зориулсан гурван ортой бяцхан тасалгаа байв. Гэвч биеэ оторлогч Бротто өвсний саравчинд унтахаар явжээ. Жан Блез хаашаа ч юм алга болж, Дюбуа Гамлен хоёр дорхноо унтчихав. Деман орондоо орсон боловч тогтмол ус мэт шөнийн анир чимээгүйд байшинг өлгийдөхөд тасалгаанаасаа гаран нүцгэн хөл дор нь чахрах модон шатаар өгсөв. Дээврийн хөндийн хаалгыг дутуу хаажээ. Тэндээс бүгчим халуун агаар, ялзарсан үрийн хурц үнэр ханхална. Доголон орон дээр Колода амаа ангайж дотуур цамцныхаа хормойг дээш яран, хөлөө алцайчихсан унтаж байлаа. Тэрээр их биерхүү ажээ. Хонгилын гэгээвчээр тусах сарны

гэрэл өтөг шивх үсэрч, шавар шавхайд будагдаагүй залуугийн өнгөөр гялалзах арьсыг мөнгөлөг хөх өнгөтэй болгожээ. Деман унтагч бүсгүйн дээрээс даран унав. Дорхноо сэрсэн бүсгүй эхлээд айн, тэр ч байтугай хашхирсан боловч өөрөөс нь юу хүсэж буйг ухаармагцаа тайвшран гайхсангүй, дургүйцсэн ч үгүй нойрмоглоод сэрж ядан, болж буй явдлыг мэдрэхгүй байгаа дүр үзүүлэн хэвтэхийн зэрэгцээ жаргал юугаан эдлэнхэн байж билээ.

Деман өрөөндөө эргэж ирээд өглөө болтол амгалан бөгөөд бөх нойроор нойрсов.

Маргааш нь аялагч академи орой болтол ажиллахад Парис буцахаар төхөөрөв. Жан Блез эзэнтэй тооцоогоо хийхэд иргэн Пуатрын «дөрвөлжин цааснаас» өөр мөнгө үзсэнгүй удлаа гэж гомдол эрэн алтан төгрөгийг гүйлгээнд оруулсан тэр шаагьсан залууд томхон зул өргөнө гэж ам алдаж байлаа.

Хүүхнүүдэд тэр цэцэг бэлэглэв. Түүний захирамжаар Колода чархи шаахайтайгаа, хормойгоо шуун ил гарсан хиртэй булчингаа гялалзуулсаар шатаар мацаж ханыг бүрхэн ургасан сарнайн ороонго бутнаас цэцгий нь цуцалтгүй хайчилна. Түүний бадируун гараас Элоди, Жюльен, Роза, Тевенен нарын тоссон хормойд цэцгүүд бөөн бөөнөөрөө бороо мэт асгана. Тэрэг цэцэгт дарагдлаа. Шөнөөр буцаж ирээд цөмөөрөө тэвэр тэврээр гэртээ аваачсан нь тэдний нойрон дунд ч, сэрэхэд нь ч тансаг үнэр анхилуулсаар байж билээ.

## XI

Есдүгээр сарын долооны өглөө, сэжиглэгдэн баригдсан нэгэн танилаа хамгаалж өгөөч гэж ардын төлөөлөгч Гамленаас гуйхаар явж байгаад Рошмор хатагтай урьдын сайхан цагт сэтгэлээ өгч явсан тайж Бротто, дез - Илеттэйгээ шатны чөлөөнд дайралдав. Бротто, Хуулийн гудамж дахь тоглоомын наймаачинд өөрийн хийсэн зуун дөчин дөрвөн хүүхэлдэйгээ аваачиж өгөхөөр завдаж байсан агаад ачаагаа амар аваачих гэж үүргийн ажилчдын заншлаар шургаагт хэлхжээ. Тэр бүх хүүхэнтэй мөн удтал ханилснаас сэтгэлийг нь аль ч талаар татахаа больсон хүүхнүүдтэй ч нэн эелдэг харилцана. Хэдийгээр хувирч салан итгэл хөсөрдүүлсэн, мөн овоо таргалсан нь Рошморыг түүний нүдэнд дулаахан харагдуулсан боловч, үзтэл түүнд мөн л тиймэрхүү хандах шиг болов. Ямар ч болсон ийш тийшээ хөдөлсөн паалант тоосго бүхий бохир талбайд түүнтэй тааралдаад Бротто, дез-Илеттордны довжооны гишгүүр дээр хэзээ нэгэн цагт уулздаг байсныхаа адил ёсорхгоор мэхийснээ түүнийг дээврийн хөндийгөөр орж соёрхоно уу хэмээн гуйв. Налуулан тавьсан шатаар хөнгөхөн нь аргагүй гараад Рошмор хатагтай хонгилд орж очлоо. Цонх гаргасан вааран дээврийг бүдүүн гэгчийн налуу дүнзээр тулсан ажээ. Нуруу тэнийж үл болно. Рошмор, доройхон энэ сууц дахь гав ганц сандал дээр суунгаа гайхсан гунигт харцаар хааш яаш болчихсон ваарыг хараад

— Морис, та ийм юманд суудаг байх нь ээ. Та ч энд урилгагүй зочдоос айх явдалгүй юм. Таныг олох гэвэл чөтгөр юм уу, муур л болбол таарах нь гэхэд тайж явсан хүн

— Тийм ээ, манайх давчуухан шүү. Бороо орчихлоор хэвтэр маань шал ус болчихдогийг танаас нуугаад ч яах вэ. Энэ л жаахан тавгүй дээ. Гэсэн ч цэлмэгхэн шөнө хүний хайр дурлалын гэрч болсон саран авхайг би хардаг юм. Ноёгтой минь, цаг ямагт сар, хайр сэтгэлтнүүдийг ивээгч гэгдсээр ирсэн, цайвгар төгрөг саран амраг сэтгэлт залууд хүсэлт зүйлийг нь санагдуулдаг гэв.



— Таны хэлдэг зөв өө гэж хатагтайн зөвшөөрөхөд Бротто үргэлжлүүлэн

— Ороо нь орсон үедээ муурууд миний толгой дээр аймшигтай концерт тавьдаг юм даа. Дурлал хүний амьдралд зовлон тарьж гэмт хэрэгт оруулдаг байхад дээвэр дээр мяу мяу гэлдэн үнэнчийн тангараг өргөлөө гэж тэдэнд зэм өгч болно гэж үү!

Тэр ухаалаг хүмүүс учраас өчигдөрхөн салсан найз хоёр шиг уулзаж, хэдийгээр тэдний хооронд ямар ч ойр дотно холбоо үгүй боловч элэгсэг, нөхөрсгөөр хууч хөөрцгөөнө.

Гэлээ ч де Рошмор хатагтайн сэтгэл тавгүй байлаа. Удтал наргиан зугаа аливаа сайн сайхны сурвалж болж байсан Хувьсгал одоо зөвхөн сэтгэлийг нь түгшүүлэн зовниулах болсны дээр барьдаг зоог нь өнгө жавхаа, хөгжил баяслаа алдаж эхэллээ. Хүмүүсийн хүрлэгэр царай түүний ятга хөгжмийн аялгууг сонсохдоо цэлмэхээ хэдийнээ больжээ. Хөзрийн ширээнээ хамгийн баян наадагчид ч суух нь цөөрлөө. Тэднийхээр байнга ирэгсдийн олонх нь итгэлгүй гэж зарлагдсан хаана ч юм нуугдацгааж, банкны эзэн найз Морхарат нь баригдсан тул түүний талаар хөөцөлдөхөөр Гамленыд ирсэн нь тэр билээ. Рошмор өөрөө ч хараанд оржээ. Үндэсний гвардичууд тэднийхийг нэгжиж, хоргоны нь шургуулга бүрийг онгичоод, шалавч сөхөн, гудсыг нь жадаар хатгаж үзжээ. Тэд юу ч ололгүй зооринд дарсан архинаас нь амсаж үзээд уучлал гуйн явцгаасан юм. Гэвч тэд гадаадад зайлсан ноён д'Экспилийн захиаг золтой л олсонгүй билээ. Түүгээр тэтгүүлэн байдаг үзэсгэлэнт Анрийг үнэнч гэдэгт итгэхэд бэрх сэжигтэй ширүүн үг хэлж байна хэмээн Якобинч нөхдөөс нь түүнд сэрэмж өгчээ.

Өвдгөө тохойлон гараараа эрүүгээ тулж хатагтай, сүрлэн дэвсгэр дээр суугаа хуучин андаасаа бодлогошронгуйгаар:

— Морис, та үүнийг юу гэж бодож байна гэж асуусанд

— Эдгээр хүмүүс нь гүн ухаанч, сониуч улсад тунгаан бодох, зугаацан цэнгэх баялаг зүйлийг өгч байна гэж би боддог боловч таны хувьд бол хонгор минь, Францын хилийн чанадад л байвал зүгээр дээ гэв.

— Морис энэ бүгд биднийг юунд хүргэдэг бол?

— Лунза, Шерийн эрэг дагуу, дез - Илетт орох замаар амгайгаа хэмлэн хурдлан довтолгох морьд хөллөсөн тэргэнд сууж явахдаа та надаас нэг удаа ингэж асууж билээ. Хүүхнүүд бас хэрэгт дуртай улс шүү. Өнөөдөр бид юу руу явж байгааг та мэдэхийг хүслээ гэнээ. Мэргэч эхнэрээс л асуугтун. Хонгор минь би төлөгч биш, хамгийн эрүүл гүн ухаан хүртэл ирээдүйг урьдчилан харахад тус болохгүй ээ. Юм бүхэнд төгсгөл байдаг болохоор үүнд ч гэсэн эцэс бий. Хэд хэдэн янзаар төгсөж болох юм гэж би санадаг. Эвсэл ялж, холбоотон Парист орж ирж мэднэ. Гэхдээ, тэд нэг л их холгүй байгаа боловч би тэднийг нааш ирнэ гэдэгт ямар ч гэсэн эргэлзэж байна. Бүгд найрамдах улсын цэргүүд юунд ч унтаршгүй цогтой тулалдаж байгаа билээ. Мөн Робеспьер, вангийн охинтой гэрлэж XVII Людовикийг эрийн цээнд хүртэл вант улсын ивээгч болж нэг магад.

— Та тэгж бодож байна уу? гэж энэ гайхамшигтай сүлбээнд оролцоод авах юм сан гэж тэсэж ядсан Рошмор дуу алдав.

— Мөн Вандей ялж, үнсэн товрог болсон балгас, уул овоо шиг хүүр хоёр дээр шашин ноёрхлоо тогтоож ч болзошгүй. Энэ банди нар сүрэгтээ хэчнээн хүний амь гарздуулахыг хонгор минь, та тоолж барна гэж үү. Би «хүнтэй» гэх гээд хазгай хэлчихлээ. Хувьсгалт онц шүүх оршин байснаараа дэглэмийг унагахад хүргэнэ гэж үзэж байгаа минь юунаас ч зөв болов уу. Яагаад гэвэл энэ айхавтар шүүх дэндүү олон хүний толгойг залгихаар заналхийлж байна шүү дээ. Түүний өмнө чичрэн дагжиж байгаа хүмүүс тойм алга. Тэд нэгдэн үүнийг устгах гээд бүх улс төрийн байгууллагыг ч устгах болно... Хэрвээ би эндүүрээгүй бол та, залуу Гамленыг ардын төлөөлөгчөөр томилоход гар бие оролцсон байхаа. Тэр сайн хүн, гэвч айхтар болно доо. Энэ тухай бодох тусам, хонгор найз минь, бүгд найрамдах улсыг аврах ёстой Онц шүүх түүнийг мөхөөнө гэдэг сэтгэл улам их төрөх юм. Вангийн засгийн адилаар өөрийн баяр ёслолыг бий болгож, өөрийн онц шүүх байгуулж, өөрөө шүүгч нарыг томилж тэдэндээ улсыг аюулаас хамгаалах талаар санаа тавих ажлыг даалгахыг Конвент хүссэн. Гэтэл Конвентын баяр ёслол хаант засгийнханд байраа өгч

байна, мөн Конвентын онц шүүх XIV Людовикийн шүүхээс харалган юм! Бүдүүлэг маягийн шударга ёс, удахгүй бүгдийн үзэн ядах сэтгэл, жигшлийг төрүүлэх гутамшигт тэгш эрхийн үзэл санаа хувьсгалт шүүхэд ноёрхож байна. Луиза, Францын хатан хаан, хорин нэгэн хуульчдыг ялтны ширээнд суулгахаар зэхэгч энэ Онц шүүх, хувьсгалыг дарах хорт санаа өвөрлөж «Ван мандтугай!» гэж хашхиран гэмт хэрэг үйлдлээ хэмээн нэг барлаг бүсгүйг өчигдөр алах ял заасныг мэдэв үү? Малгайдаа хар өд хадсан манай шүүгчид, Англичуудын их л дотночилдог, хамгийн бүдүүлэг марзан юмыг ч аль эмгэнэлтэй үзэгдэлд оруулдаг Вильям Шекспирийн маягаар ажиллаж байна.

— За тэгээд, Морис минь, аанай л хайр дурлалын талаар аз хийморьтой байгаа биз дээ? гэж хатагтайг асууваас Бротто санаа алдан

— Үгүй дээ, тагтаа шувууд шинэхэн хонуурынхаа харалдаа эргэлдээд эвдэрхий цамхаг дээр суухгүй юм гэв.

— Та огтхон ч өөрчлөгдсөнгүй... Баяртай, найз минь.

Тэр орой Анри, хатагтай де Рошморын урилгагүй хүрч ирээд захиагаа дугтуйлж байхад нь тааран Вернонд байгаа Ролинд гэсэн хаягийг нь уншиж завдав. Энэ захиаг Англид явуулах ёстойг Анри мэдэж байлаа. Хатагтай де - Рошморын мэдээг шуудангийн сүйхээр хүлээн авсан Ролин түүнийг загасны наймаач эхнэрээр дамжуулан Дьепп хот руу илгээдэг билээ. Тэнд нэгэн хөлгийн эзэн захидлыг эргийн хавьд эргэлдэн английн онгоц руу шөнө явуулан Лондонд түүнийг оргодол ноен д'Экспильи хүлээн авч хэрэгтэй юм гэж үзвэл Сен - Жемийн зөвлөлд дамжуулдаг байв.

Анри орь залуу, үзэсгэлэн гоо билээ. Улиссын бэлэглэсэн өвч хатан хуяг өмссөн Ахилл ч сүрлэг жавхлан, бяр тэнхээгээрээ залуу дайчинтай эн зэрэгцэж чадахгүй биз ээ. Гэвч саяхан болтол коммуны залуугийн гоо сайханд сэтгэл дэнсэлж байсан Рошмор сэжиг авснаас хойш, якобинчуудын сэрдээд байгаа энэ залуу эр түүнийг баллаж нэрийг нь хугалж мэднэ гэж бодоод сэтгэл зүрхээ буцаан авч түүнээс зулрах болсон байлаа. Де - Рошмор хатагтайгаас холбоогоо таслахад нэг л их гонсойгоод байх юмгүй гэж санавч өөрийг нь анхаарахаа больжээ гэж бодоход эвгүй байв. Мань эр, Бүгд Найрамдах улсын албанд байхдаа үрэгдүүлсэн зардлаа хатагтайгаар төлүүлчих бодолтой байжээ. Түүнээс гадна халуун хайр энхрийллээс хамгийн хүйтэн хөндий байдалд орж чаддаг хүүхнүүд, хайрлаж байснаа хаян, биширч

байснаа хөнөөхдөө тун ч юм санахгүй гэж бодон хэрвээ салах юм бол нэгэн сайхан өдөр дур булаам Луиза маань толгой цусдаж магад гэж сэтгэнэ. Ийн болгоомжилсон нь гоо хүүхний хөрсөн сэтгэлийг эргүүлж ав гэж шивнэж байлаа. Иймээс л эр хүний арван гурван мэхийг хийхээр түүн дээр ирсэн билээ. Залуу, түүнд нэг үе ойртож, нэг үе холдсоноо, дахин дөхөж ирээд үл мэдэг шүргэсхийн ахин гэнэт хөндийрөх зэргээр бүжгийн сэтгэл татах бүхий л аргыг хэрэглэв. Тэгж тэгж тэрээр сандал дээр суун ганц ч эмэгтэй эс тэссэн зүрх уяраам дуугаар байгалийн үзэсгэлэн, хүний хөл сэлүүхэн газар байхын сайхныг магтаж Эрменонвилиар зугаалъя гэж санаа алданхан гуйв.

Хатагтай ятгын утсыг цохин тэвчээргүй бөгөөд уйдсан харцаар орчноо ширтэнэ. Гэнэт Анри царайгаа барайлган эрслэн босоод цэрэгт орж хэд хоноод Мобежийн хавьцаа очно гэж мэдэгдэв.

Хүүхэн эргэлзсэн, гайхсан ямар ч тэмдэг үзүүлсэнгүй сайшаасан байртай толгой дохив.

— Миний саналыг зөв гэж үзэж байна уу?

— Маш зөв.

Рошмор шинэ найзынхаа ирэхийг хүлээж байжээ. Тэр хүн сэтгэлд нь хязгааргүй таалагдах агаад түүнтэй ойртох нь ихээхэн хонжоо Рошморт өгөх байлаа. Цаадах нь Анригаас тэс ондоо бөгөөд амилсан Мирабо, Дантон, бүх эх орончдыг Сена мөрөнд хаяна гэж ярьдаг арслан шиг хүн байжээ. Хором бүрд хонх дуугарах мэт бодогдон хатагтай эмээн хирдхийж байлаа.

Анригаас шалавхан ангижрахыг хүсэн тэрээр дуугаа хураан эвшээлгэж нот эргүүлснээ дахин эвшээлгэв. Мөд явахгүй байртай байгааг үзээд хатагтай гадуур гарах хэрэг байна гээд хувцасныхаа өрөө рүү орчихлоо.

— Хагацъя, Луиза! Хэзээ нэгэн цагт тантай ахин учрах болов уу гэж догдолсон дуугаар хашхирах зуураа Анри бичгийн ширээний шургуулгыг тэмтэрч байлаа.

Анри гудамжинд гармагцаа иргэн Ролинд гэж хаягласан захиаг задалж сонирхон уншив. Францын байдлыг захиандаа үнэхээр сонин бичсэн ажээ. Тэнд хатан хаан, Роза, Тевенен, Хувьсгалт шүүхийн тухай уламжилж хонгорхон Бротто - дез - Илеттын, амаа хамхиж байвал зохих ёстой байсан саналыг хүртэл бичсэн байлаа.

Анри уншиж бараад захиагаа хармаандаа хийн хоромхон зуур бодолхийлснээ сэтгэл эрс шулуудан, ямааны мах халуун дээрээ гэж

шийдсэн хүний маягаар Тюильрийн ордныг чиглэн явсаар Нийгмийг аюулаас хамгаалах хорооны хүлээн авах өрөөнд орлоо.

Тэр өдөр их үдийн гурван цагт Эварист Гамлен, анх удаагаа бусад арван дөрвөн төлөөлөгчийн хамт ардын төлөөлөгчийн суудалд суулаа. Эдний ихэнхийг Гамлен таних бөгөөд тэд бол эрдэмтэд, зураачид, гар урчуул зэрэг эгэл жирийн шударга хүмүүс эх орончид байв. Гамлены ижил нэг уран зураачаас гадна бас нэг хар зураг зурдаг хүн байх агаад хоёулаа л авьяас төгөлдөр улс ажээ. Мөн мэс засалч гуталчин, хувьсгалд үнэнч гэдгээ бүрнээ харуулсан маркиз явсан хүн, хэвлэгч, хэдэн жижиг худалдаачид зэрэг өөрөөр хэлбэл Парисын оршин суугчдын бүх давхаргын төлөөлөгчид тэнд байлаа. Тэдний дунд ажлын хувцастай ч, баячуулын хувцастай ч хүмүүс байх ба ромын маягаар үсээ тойруулан хайчилсан, тууз зангидсан шодон гээгтэй улс ч үзэгдэж, духдуулсан гурвалжин малгай, дагзан дээрээ тавьсан дугуй бүрх, эсвэл чих рүүгээ дарсан улаан малгайтай хүмүүс ч харагдана. Зарим нь хуучин дэглэмийн үеийнх шиг цээживч, фрак, богино өмд, бусад нь санкюлот маягаар хүрэм, судалтай өмд өмсөж ирцгээжээ. Түрийтэй савхи, аралтай шагайвч, чархи шаахай зэрэг тэр үед л өмсөж байсан эрэгтэй хүний төрөл бүрийн хувцсыг үзэж болох байлаа. Тэд нэг бус удаа хуралдсан болохоор төлөөлөгчийн суудалдаа тайван суух ба Гамлен тэдний амгалан байгаад атаархана. Зүрх нь түргэлэн цохиж чих нь хангинан, нүд нь маналзаад эргэн тойрны юмс бүрэлзэв.

Шүүхийн гүйцэтгэгч босож «Шүүхийнхэн ирж явна» гэж зарлахад гурван шүүгч жижиг тавцан дээр гараад ногоон ширээнээ сууцгаалаа. Тэд тэмдэг хадсан, сахлаг хар өдөөр чимсэн гурвалжин малгай, шүүгчийн жанчтай агаад энгэртээ гурван өнгийн туузан дээр том мөнгөн медаль зүүжээ. Тэдний өмнө тайзны дор мөн л ийм хувцастай олон нийтийн яллагчийн туслах сууж байлаа. Нарийн бичгийн дарга, шүүгчийн ширээ, яллуулагчийн эзгүй сандал хоёрын хооронд байраа эзлэв. Эдгээр хүмүүсийг харахад хэдийгээр тэд цаас эргүүлэн, шүүхийн гүйцэтгэгчийг дуудаж, ар тийшээ эргэн тонгойж алив нэг төлөөлөгчийн буюу жижүүрийн офицерын үгийг чагнах зэргээр биеэ маш энгийн авч байх боловч одоо мэддэг байсантай нь огт адилгүй илүү сайхан, илүү жавхлантай, илүү сүрлэг болчихсон мэт Гамленд бодогдоно.

Шүүгч нарын суудлын дээр Хүний Эрхийн тунхагтай хүснэгт өлгөж, хоёр талаар нь эртний, феодалын үеийн хананд де - Пельтье, де - Сен - Фаржо болон Маратын баримлыг тавьжээ. Шүүхийн ширээний өмнө танхимын голд цугларагсдын жавдан байх аж. Хацрыг нь сүүдэрлэсэн хуниастай торон саравчтай гозгор оройвч өмсөж. тэр үеийн маягаар хөхүүл хүүхнийх шиг нэгэн ижил болгон товойлгосон хөхөн дээрээ хошуу цагаан алчуур зөрүүлэх буюу хормогчныхоо элгэвчийг бултайлгасан хар, цайвар, буурал үстэй эмэгтэйчүүл эхний эгнээг эзэлжээ. Цөмөөрөө жавдангийнхаа хашлага дээр гараа зөрүүлэн тавьсан байлаа. Тэдний ард шатны гишгүүрээр дүүрэн төрөл бүрийн хувцастай харчуул шавсан агаад тэгэхэд энэ хувцаснаас болж Парисынхан хачин эрээн мяраан харагддаг байж билээ. Хаалганы баруунтай, урт хайсны ард цугларагсдын зогсох газар байна. Энэ удаа тэнд хүн сийрэг байлаа. Нэгэн зэрэг худалдаж байсан Онц шүүхийн бусад секцэд арай сонирхолтой хэргийг хэлэлцэж байснаас тус секцийн хянан үзэх хэргийг сонирхогсод цөөхөн ирсэн нь тэр ажээ.

Томхон үйл явдлын сэтгэл дэнслүүлсэн байдлыг бол давж чадахааргүй үймрэн байсан Гамленыг дээрх байдал нэлээд тайвшруулав. Тэгээд тэрээр нарийн бичгийн даргын чихэн дэх хөвөн, яллагчийн хавтсан дээрх толбо зэрэг маш нарийн юмыг хүртэл ялган үзэж эхэллээ. Сонгодог маягийг ойлгох алив ойлголт үгүй болсон үед урласан баганын толгой, өргөст халгайгаар гинж мэт ороосон гот маягийн багана зэргийг өсгөгч шилээр харж буй мэт олж үзлээ. Гэвч утхерт улаан хилэнгээр бүрсэн суудал нь элэгдэж бариул нь харласан хуучны түшлэгт сандал дээр харц нь хором бүр тусаж байв. Хаалга тоолон дээр зэвсэгтэй үндэсний гвардичууд зогсжээ.

Тэгж тэгж хэрэгтнийг цэргүүд туун орж ирэв. Хуульд заасан ёсоор түүний гарыг гавласангүй. Энэ бол тавь эргэм насны туранхай хатангир, халзан шахуу, бор царай, ширгэсэн хацар, нимгэн, хөх уруултай хуучны маягаар цусан улаан фрак өмссөн хүн байлаа.

Нүд нь эрдэнийн чулуу мэт гялалзахыг үзвэл хумх туссан байж мэдэх агаад хацар нь маажиндсан юм шиг санагдана. Тэрээр зүйргүй туранхай хөлөө ачин мойног хуруут том гараараа өвдгөө тэврэн суув. Түүнийг Мари - Адольф Гийерг гэдэг бөгөөд улсад хоол хүнс тушаахдаа шамшигдуулсан хэргээр яллагдаж байгаа хүн ажээ. Ялын төлөвлөгөөнд ноцтой маш хортойгоор завшсан нь олонтоо гэж дурдагдсан байх боловч ганц ч баттай нотолгоо алга байв. Хийсэн

хэргээ хүлээж байна уу гэж асуухад Гийерг өөртөө ноогдуулсан хэргийн ихэнхийг мэлзэж бусдыг нь өөртөө ашигтайгаар тайлбарлав. Тэрээр яг таг,, хянамгай, гайхам урнаар өчиг мэдүүлэх нь хэрэг хэлэлцээгүй нь дээр хүн юм гэдэг сэтгэгдэл төрүүлнэ. Шүүгчийг адармаатай асуулт тавихад нүүр нь тайван үг нь итгэлтэй хэвээр элгэндээ зөрүүлсэн гар нь татвалзан базлав. Гамлен үүнийг ажаад дэргэдээ суугаа зураачийн чихэнд

— Хараач, түүний хурууны томыг яана! гэж шивнэлээ.

— Нэгдүгээр гэрчийн үгийг сонсвол тэрээр шүүгдэж буй хүний хувьд тун ашиг багатай мэдүүлэг өглөө. Үүн дээр л үндэслэж бүх ялыг тулгасан юм байжээ. Дараагийн гэрчийн мэдүүлэг харин Гийергт ашигтай байв. Яллагч омогтой ярьсан боловч тодорхой юм нотолж чадсангүй. Өмгөөлөгч, хэнд ч үнэмшигдэм яриагаараа, ялтны өчиг мэдүүлэхдээ төрүүлж чадаагүй нааштай сэтгэлийг шүүхийнхэнд төрүүлэв. Завсарлагаа зарлаж, төлөөлөгчид зөвлөлдөх өрөөнд орцгоолоо. Тэд нэлээд ээдрэн юу ч шийдэж чадалгүй булаацалдан маргасны эцэст санал бараг тэг дундуураа хуваагдав. Ямар ч тохиолдолд юманд хайхрамжгүй амарлингуй хөндий ханддаг цэцэрхэх дуртайчуул нэг тал болж зоригороо аашилж эргэцүүлэн дүгнэхийг бараг хайхардаггүй, юу л гэж сэтгэлд орно, түүгээрээ шийтгэдэг хүмүүс нөгөө тал нь болжээ. Тэд ихэнхдээ гэсгээн цээрлүүлэх ял заадаг байв. Эд нь зөвхөн бүгд найрамдах улсаа бодоод бусдад огт санаа тавихаа больсон жинхэнэ эх орончид билээ. Өөрийгөө тэдэнтэй санал нэгтэй гэж үздэг Гамленд тэдний үзэл хүчтэй сэтгэгдэл төрүүлэв.

«Энэ Гийерг баширтай луйварч, манай морин цэргийн агтын бордоог дамлан арилжиж байсан этгээд биз. Үүнийг цагаатгавал урвагчийг суллан чөлөөлж, эх орноосоо тэрслэн армия бут цохиулахад тусалсан хэрэг болно» гэж тэр сэтгэв. Тэгээд унасан морьд нь бүдрэн таварцаглаж, дайсны морьт цэргийн сэлмийн ирэнд өртөж байгаа бүгд найрамдах улсын торгон цэргүүд нүдэнд нь үзэгдэх шиг болов... «Хэрвээ Гийерг гэм зэмгүй байвал яана?»

Ханган нийлүүлэх үедээ шамшиж байсан гэж сэрдэгдсэн Жан Блез гэнэт сэтгэлд нь оров. Бүгд найрамдах улсыг сөнөөхөөр дайснуудын гар хөл болж байгаа Гийерг Блез мэтийн хүмүүс хэчнээн олон бий бол. Зүрхийг нь үхүүлэх үлгэр үзүүлэх нь чухал. Гэсэн ч Гийерг гэм зэмгүй байвал яах вэ?

— Бидэнд баримт алга гэж Гамлены дуугарсанд шалгарсан эх оронч, төлөөлөгчдийн ахлагч мөрөө хавчисхийлгэн

— Маргаангүй нотолгоо гэж ер байдаггүй юм хэмээн татгалзлаа.

Эцсийн эцэст долоон хүн шийтгэхээр, найман хүн цагаатгахаар санал гаргав.

Ардын төлөөлөгчид танхимд буцан орж хуралдаан дахин эхэллээ... Хүн бүр яллах шалтгааныг дурдах ёстой тул цугаараа, шийтгүүлэгчийн эзгүй сандлын өмнө дэс дараалан ярив. Зарим нь нуршин, нэг хэсэг нь ганц хоёр үгээр хязгаарлаж, нөгөөдүүл нь тун бүрхэгдүү ярина.

Гамлены ээлж болоход тэрээр босож

— — Эх орноо хамгаалагчдыг ялалт хийх хэрэгслээс нь мухарлаж байгаа ийм хүнд хэрэгт хүнийг татахад баримт хэрэгтэй, гэтэл бидэнд тийм юм алга гэлээ.

Олонхын саналаар хэрэгтнийг гэмгүй гэж үзлээ.

Гийергийг ахин танхимд оруулахуйд цагаадсан гэдгийг нь мэдэгдэн цугларагсад хоорондоо найртайгаар шивэр авир хийв. Одоо бол энэ хүн шал ондоо харагдаж байлаа. Түүний догшин дүр зөөлөрч ам нь засарчээ. Дарга түүнийг суллах тухай шүүхийн тогтоолыг сэтгэл хөдлөм дуугаар уншин сонсоход танхим даяараа нижигнэтэл алга ташив. Гийергийг хүргэж ирсэн цагдаа түүнийг тэврэхээр ухасхийлээ. Дарга түүнд баяр хүргэн духан дээр нь үнсэв. Ардын төлөөлөгчид ч түүнийг үнсэв. Энэ үед Гамлен баярын нулимс мэлтэлзүүлэн суулаа.

Жаргаж буй нарны туяа туссан шүүхийн хашаанд бум бужигнаж байлаа. Онц шүүхийн дөрвөн секц урьд нь гучин хүнд алах ял заасан байсан тул «нэхмэлчид»<sup>41</sup> гол шатны гишгүүр дээр сууцгаан тэрэг явахыг хүлээх ажээ. Гэвч Гамлен, төлөөлөгч нар болон цугларагсадтай цуг доош буухдаа юу ч үзэж, юу ч сонссонгүй, гагцхүү дөнгөж сая хүнийг энэрсэн шударга үйл хийснээ бодон гэмгүй хүнийг таньсандаа баярлана. Хашаанд царай нь цайсан Элоди доголон нулимстай инээмсэглэн ирж түүний цээжинд ухасхийн наалдаад таг чиг болов. Жаал сэхээ ороод

— Эварист, та хэчнээн үзэсгэлэнтэй, хэчнээн уяхан, хэчнээн тавиун сэтгэлтэй хүн бэ! Энд, танхимд таны хүчирхэг бөгөөд намуухан дуу соронзон долгион адил бүх биеэр минь түгж. байлаа. Би соронзонд татагдсан юм шиг л байсан шүү. Тэнд сандал дээр байхад тань би үргэлж ширтсээр байлаа. Ганцхан таныг л харж байсаан. Харин та, найз минь миний ирснийг мэдсэнгүй юу? Намайг энд байна

гэж зөн тань хэлсэнгүй гэж үү? Би үзэгчдийн суудалд баруунаасаа хоёр дахь эгнээнд сууж байсан. Бурхан минь, сайн үйл бүтээх яасан сайхан бэ! Та тэр золгүй хүнийг аварлаа. Хэрвээ та байгаагүй сэн бол бүх зүйл дуусаж тэр алагдах сан биз. Одоо тэр таныг лав ерөөж байгаа даа. Эварист би, аз заяатайдаа, танд хайртайдаа баярланам! гээд ярьж гарлаа.

Тэр хоёр бие биеэ налан сугадалцаж гудамжаар алхахад хөл нь хөнгөрөн мөрнөөс нь жигүүр ургах мэт санагдана.

Тэд «Амур — зураачийг» зүглэв.

Ораторийн гудамж руу эргэх үед Элоди

— Дэлгүүрээр дамжиж орохгүй шүү гэлээ.

Дааман хаалгаар хашаанд ороод хоёулаа хоёрдугаар давхар өөд өгсөв. Үүдний чөлөөнд цүнхнээсээ том төмөр түлхүүр гаргаад

— Шоронгийн түлхүүр гэж бодмоор шүү. Эварист, тэгэхлээр та миний мэдлийн хүн болж дээ гэв.

Тэд хоолны өрөөгөөр дамжин бүсгүйн унтлагын тасалгаанд орлоо.

Эварист, Элодийн амтлаг уруулыг шимэн цээжиндээ тэврэв.

Хүүхэн толгойгоо гэдийлгэн нүдээ дуниаруулан хотойход үс нь мөр лүүгээ намиран бууж, бараг ухаан алдсан Элоди залуугийн гараас мултран хаалгаа шалавхан түгжлээ...

Блез бүсгүйг амрагтаа, өрөөнийхөө хаалгыг тайлж өгөөд харанхуйн дунд

— Баяртай, хайрт минь! Одоохон манай аав эргэж ирнэ. Хэрвээ шатан дээр хөлийн чимээ сонсогдвол бушуухан дээд давхарт гарч алив аюул өнгөрлөө гэж итгэтлээ бүү буу. Хаалгач хүүхний цонхыг гурав тогшиход чинь тэр чамайг гадагш гаргана. Баяртай амь минь, баяртай, голт зүрх минь гэж шивнэх үед аль хэдийнээ шөнө дүл өнгөрсөн байлаа.


Гудамжнаа гараад тасалгааны цонх үл мэдэг нээгдэн Элодийн бяцхан гараараа тасалсан гал улаан лиш цэцэг хөлийн нь дэргэд цусан дусал мэт унахыг Гамлен үзэв.

[УНДААССАН БУРХАД - 2 \(e-nom.mn\)](http://e-nom.mn)

\*

\*\*

Уг номыг “[Болор дуран](#)” шалгуураар шүүсэн болно.  
Программтай танилцах бол сурталчилгаа дээр товшиж холбоос руу орно уу.



#### Өглөгийн эзний сонорт

×

Та манай номын санд хандив өргөж болно.

#### Таны хандивласан мөнгө:

- Хэвлэгдсэн номыг цахим хэлбэрт оруулах
- Цахимд оруулсан номыг ариутган шүүх
- Цахим технологийн тоног төхөөрөмж авах
- Цахим номын санг өргөжүүлэх
- Цахим номын сангийн чиглэлээр судалгаа хийж, сурч байгаа оюутан судлаачийг дэмжихэд зарцуулагдана.

Хандив өргөх данс "Хаан банк" 5027 8982 35 (төгрөг) ЦОГТ ОХИН ТЭНГЭР САН

Qray

## 1969 оны хэвлэлийн Хэвлэн нийтлэлийн мэдээлэл

### АНАТОЛЬ ФРАНС

#### **УНДААССАН БУРХАД**

УЛСЫН ХЭВЛЭЛИЙН ГАЗАР  
УЛААНБААТАР-1969

Орчуулсан [Г. Аким](#)  
Редактор [Г. Амар](#)

Уран сайхны редактор Г. Актив  
Зураач Б. Түмэннасан  
Техн. редактор Т. Тогтох  
Хянагч Д. Болд, Д. Цэгмэд

Өрөлтөд 23/11 1968.  
Хэвлэлтэд 23/11 1969

Цаасны хэмжээ 84X108 1/32.  
Хэв. хуудас 17  
Хэв нэгж хуудас 28,56

Хэвлэсэн тоо 10 000

Хэв. газ. № 210/68.  
Зах. №433

Сүхбаатарын нэрэмжит хэвлэлийн комбинат.  
Улаанбаатар, Сүхбаатарын талбай 2

## Заметки

[←1]

Давид Жак Луи — 1748—1825 оны үед амьдарч байсан францын зураач. 1789—1794 оны францын хувьсгалаас сэдэвлэж олон тооны зураг зуржээ.

[←2]

Ле Пелетье де Сен Фражо — XVI Людовикийг цаазлуулахаар конвентэд санал оруулсны учир хаант засгийн үзэлтнүүдэд алуулсан Якобинч.

[←3]

Конвент — Ардын төлөөлөгчдийн хурал. Францын хөрөнгөтний хувьсгалаар ванг түлхэн унагаасны дараа 1792 оны 8-р сарын 10-нд бүх нийтээрээ сонгох эрхийн үндсэн дээр байгуулагджээ. Конвент нь 1794 оны термидорын 9-ний эргэлтээр хувьсгалын эсэргүү нарын гарт орсон байна. 1795 оны 10 сард Конвентыг бүрмөсөн тараажээ.

[←4]

Санкюлот — 18-р зууны үеийн францын хөрөнгөтний хувьсгалын үеийн эх орончдыг тэгж нэрлэдэг байжээ

[←5]

Gaira — Бүх юм бүтнэ!

[←6]

Гильотина — 1792 оны францын хөрөнгөтний хувьсгалын үед доктор Гильотины төслөөр хийсэн хүний толгой авдаг машин.

[←7]

Конвентын өөрчилсөн хуанли — 1793 оны арван сард гаргасан шинэ хувьсгалт хуанли Бүгд найрамдах улсын үндэслэгдсэн өдөр 1792 оны 09-р сарын 22-ноос тоолол эхлэх бөгөөд жил нь тус бүр 30 хоногтой 12 сартай байжээ. Намрын сарыг нь вандемьер, брюмер, фример, өвлийн сарыг нь нивоз, плювиоз, ванкиоз, хаврын сарыг нь жерминаль, флореаль прериаль, зуны сарыг нь меседор, термидор, фрукидор гэнэ.

[←8]

Орест Электра хоёр — Орест нь эртний грекийн миф үлгэрийн гол баатар. Агамемнон хааны хүү. Түүний эх нь өөр хүнтэй нөхцөн нөхрөө алжээ. Бурхны зарлигаар Орест эцгийнхээ өшөөг аван эхийгээ мөн алсан гэдэг. Өшөөний охин тэнгэр Эриния хилэгнэн эхийнхээ аминд хүрсэн Орестийг ухаан мэдрэлгүй болгон шийтгэсэн дүү охин Электра нь түүнийг ихэд халамжлан сувилж байжээ.

[←9]

Бриссо Жан — Жирондчуудын удирдагч. Хувьсгалт онц шүүхийн тогтоолоор 1793 онд цаазлуулжээ.

[←10]

Петион Жером, Роллан Жан — Жирондын намын зүтгэлтнүүд

[←11]

Марат Жан Поль — 1743—1793 оны үед амьдарч байсан, францын хувьсгалын томоохон зүтгэлтний нэг бөгөөд уран илтгэгч, сэтгүүлч «Ардын нөхөр» сонины редактор

[←12]

Лафайет Мари Жозеп — (1757—1834) Энэ хүн нь 1789 онд Бастиль гянданг эзлэн авсны дараа Парисын үндэсний гвардийг удирдаж хувьсгалын цаашдын өрнөлтөд аль болохоор саад хийж байв.

[←13]

Дамьен — 1757 онд XV Людовик хааныг алсны учир баригдан  
дөрвөн мөчөө тастуулан алуулжээ

[←14]

Лалли Томас — Энэтхэгт байсан Францын эзэмшихүүн газрын жанжин сайд байжээ. Английн талд урвалаа гэж 1766 онд Парист цаазаар авхуулсан юм.

[←15]

Эртний Ромын миф (домог (ЦБ)) үлгэрт гардаг шинжлэх ухаан,  
урлагийг ивээгч цэцэн билгийн охин тэнгэр

[←16]

Австри хүүхэн — Австрийн хатан хаан Мария Терезагийн охин,  
францын вангийн хатан Мария Антуанеттийг хочлон хэлжээ

[←17]

Грек ромын миф үлгэрт гардаг байгалийн сүр хүч, үзэгдлийг  
бэлгэдсэн бурхад

[←18]

Питт Вильям — Английн төрийн зүтгэлтэн. Францын хувьсгалын эсрэг тэмцлийг зохион байгуулж удирдаж байжээ

[←19]

Шарден Жан Батист — 1699—1779 он хүртэл амьдарч агсан францын зураач. Тэрээр өдөр тутмын амьдралыг харуулсан зураг голчлон зурж байжээ. Энд түүний зурагт дүрслэгддэг гэрийн эзэгтэйтэй адилхан гэсэн утгаар хэрэглэсэн байна.

[←20]

Эртний грек ромын миф үлгэрт гардаг баяр наадам, архи сархдын бурхан Вакхагийн тахилгыг тахигч эм

[←21]

Пенелопа — Гомерын «Одессей» найраглалын гол баатар эмэгтэй. Одессей хааны үнэнч гэргий. Трояны дайн дууссаны дараа нөхрөө эргэж ирэхийг 10 жил цөхрөлтгүй хүлээх зуураа өөртэй нь суухыг хүссэн харчуулын хурим хийнэ гэдэг саналыг түр ч атугай хойшлуулахын тул нэхэж байсан зүйлээ шөнө нь хөвдөг байсан гэдэг

[←22]

Пикет — хэзрөөр тоглох хуучны тоглоом

[←23]

Торпейн хясаа — Капитолийн өмнө бэлд байдаг байц хад. Түүн дээрээс төрийн хэрэгтэн урван тэрслэгчдийг доош шидэж цаазалдаг байжээ

[←24]

Капитолий — эртний ромын оршин байсан долоон довцог толгойн хамгийн өндөр нь. Ромын хамгийн том албан газар байсан тэр толгой тийш ялгуусан баатар жанждын дурсгалд зориулсан баяр ёслолыг тэмдэглэхийн тул очдог байжээ

[←25]

Маратын редакторлан гаргаж байсан сонин.

[←26]

Херувим — миф үлгэрт гардаг тэнгэр

[←27]

Бриссо Жан — Жирондчуудын удирдагч, 1793 онд хувьсгалт онц шүүхийн тогтоолоор цаазлуулжээ.

[←28]

К а п у ц и н — Католик шашны лам

[←29]

1792 оны есөн сарын 2—5-ны өдрүүдэд Парисын шоронд хоригдож байсан хувьсгалын дайснуудыг цаазалжээ

[←30]

Итали, Португал, Франц, Бразил улсад байсан алтан зоос. 18-р зууны эцсээр гүйлгээнээс гарчээ

[←31]

Ариутгалын орон — Католик шашин үхэгсэд энхжинд унахаасаа  
өмнө энд нүглээсээ салдаг гэж сургадаг байв

[←32]

Хувьсгалын үеийн улс төрийн бүлэглэл. 1791 оны хаант засгийн үндсэн хуулийн талыг баримтлагчид.

[←33]

Монтаньярууд буюу Уулынхны нам — Конвентын хэсэг депутатын нэр. «mont» буюу уул гэдэг франц үгнээс үүсжээ. Энэ нь уул бүлгийн гишүүд танхимын дээд талын суудлыг эзэлдэг байсантай холбоотой. Монтаньяруудын олонх нь якобины клубийн гишүүн байжээ

[←34]

Францын хувьсгалын зүүн жигүүрийн удирдагч ядуу ангийн эрх ашгийг хамгаалагчид.  
Якобинчуудад бут цохигджээ

[←35]

Жан Жак Русогийн «Юлия буюу Шинэ Элоиза» романы баатруудын яриагаар гэсэн үг

[←36]

XVI Людовикийг авч хаясны дараа түүнийг Луи Копет гэж дуудах болсон юм. Учир нь Бурбончуудын угсаа бол Капетингийнхний төрөлд хамаардаг байжээ

[←37]

Дюпати Шарль (1746—1788) францын шүүгч. Францын вангийн шүүхийн ажиллагааг зад шүүмжилсэн хүн. Беккария Чезаре (1738—1794) италийн хууль цаазач. Иргэний эрхийн тухай зохиолууд нь олон орны шүүх ажиллагааны хөгжилд ихээхэн нөлөө үзүүлжээ

[←38]

XV Людовикийг балчир байхад герцог Филипп Орлеанскийн төр барьж байсан үе

[←39]

Франц гэсэн үг.

[←40]

Францын Ариосто — «Орлеаны ариун бүсгүй» гэдэг найраглалыг зохиосон Вольтерыг хэлжээ. Эл найраглал нь XVI зууны үеийн Италийн яруу найрагч Ариостын уран бүтээлийг санагдуулдаг байсан учир Вольтерыг тийн нэрлэсэн байна.

[←41]

Якобины диктатурын үед Конвент болон Хувьсгалт Онц шүүхийн хурлын танхимд ирдэг байсан эмэгтэйчүүд. Тэд хурал дээр юм нэхэн суудаг байснаас тэгж нэршжээ.